| | | |
|---|---|---|
| Үндсэн ажиллагаа | Мултимедиа системийн үндсэн ажиллагаа | 1 |
| Тохиргоо ба бүртгэл | Олон төрлийн тохиргоо ба бүртгэл | 2 |
| Ухаалаг утас, эсвэл холбоо харилцааны төхөөрөмж холбох | Bluetooth®, эсвэл Wi-Fi® ашиглах | 3 |
| Навигаци | Газрын зургийн дэлгэц удирдах<br>Газрын зураг хайх<br>Маршрутын зааварчилгаа идэвхжүүлэх | 4 |
| Аудио систем | Радио сонсох<br>Дуу сонсох | 5 |
| Арын суудлын энтертейнмент систем | Арын суудлаас радио болон дуу сонсох | 6 |
| Гарны оролцоогүй дуудлага | Гарны оролцоогүй утас ашиглах | 7 |
| Холбоотой үйлчилгээ | Холбоотой үйлчилгээ ашиглах | 8 |
| Хавсралт | Холбоотой мэдээлэл<br>Сертификат ба барааны тэмдэгтийн мэдээлэл | 9 |
| Индекс | Үсгийн дараалаар хайна | |

## Танилцуулга

Таньд хэрэгтэй мэдээлэл...... 9
Ашиглалтын аюулгүй байдал ................................ 11
Гарын авлагын тэмдэг........ 12
Зурган индекс ...................... 14

## 1 Үндсэн ажиллагаа

1-1. Мултимедиа системийн үндсэн ажиллагаа
Дэлгэц ба удирдлага ........... 17
Мултимедиа системийн ерөнхий мэдээлэл............. 19
Үндсэн цэс ............................ 20
Статусын тэмдэг................... 22
Мэдрэгчтэй дэлгэц удирдах ............................... 24
Дэлгэцийн үндсэн функц ... 27
Тоо ба үсэг бичих................. 29
1-2. Газрын зургийн үндсэн ажиллагаа
Газрын зургийн дэлгэц....... 30
Автомашины одоогийн байршлыг дэлгэц дээр гаргах.................................. 32
Газрын зургийн масштаб өөрчлөх .............................. 33
Газрын зургийн чиглэл өөрчлөх .............................. 34
Газрын зураг хөдөлгөх ....... 35
1-3. Аудио системийн үндсэн ажиллагаа
Аудио систем асааж унтраах, дууны түвшин тохируулах.......................... 36
Аудио эх үүсвэр солих ........ 37
Эх сурвалж сонгох дэлгэц дээрх жагсаалтын байршлыг өөрчлөх........... 39
USB портод холбох.............. 40
1-4. Арын суудлын энтертейнмент системийн үндсэн ажиллагаа
Арын суудлын энтертейнмент системийн функц ба ажиллагаа.......................... 41
Арын суудлын энтертейнмент систем ажиллуулах........................ 44
Арын олон үйлдэлт удирдлагын самбараар арын суудлын энтертейнмент систем ажиллуулах........................ 45
Арын суудлын энтертейнмент систем асааж унтраах ................... 47
Арын суудлын энтертейнмент системийн дэлгэц унтрааж зөвхөн аудио дуугаргах........................... 48
Арын суудлын дэлгэцний өнцөг тохируулах .............. 50
Арын суудлын энтертейнмент системд HDMI төхөөрөмж холбох (7 суудалтай) ......... 52
Арын суудлын энтертейнмент системд HDMI төхөөрөмж холбох (4 суудалтай) ......... 53
Арын суудлын энтертейнмент системийн эх үүсвэр солих.................................... 54
Арын суудлын энтертейнмент системийн дууны түвшин тохируулах........... 56

Арын суудлын энтертейнмент системийн аудио гаралт солих ..... 57
Чихэвч ашиглах (7 суудалтай загвар) ..... 58
Чихэвч ашиглах (4 суудалтай) ..... 59
Урд суудлын аудио системээс арын суудлын энтертейнмент систем удирдах ..... 60

**1-5. Дуу хоолойн удирдлагын систем**

Системийг дуу хоолойн удирдлагын системээр удирдах ..... 61
Дуу хоолойн удирдлага эхлүүлэх ..... 63
Дуу хоолойн команд хэлэх ..... 65
Дэлгэцний гар ашиглан мэдээлэл хайх ..... 69

## 2 Тохиргоо ба бүртгэл

**2-1. Мултимедиа системийн анхны тохиргоо**

Жолооч бүртгэх ..... 73

**2-2. Олон төрлийн тохиргоо**

Олон төрлийн тохиргоог өөрчлөх ..... 78

**2-3. Жолоочийн тохиргоо**

Жолооч бүртгэх, бүртгэл өөрчлөх ..... 80
Жолооч таних тохиргоо хийх ..... 83

**2-4. Ерөнхий тохиргоо**

Мултимедиа системийн ерөнхий тохиргоог өөрчлөх ..... 86

**2-5. Дэлгэцийн тохиргоо**

Дэлгэцийн тохиргоог өөрчлөх ..... 89

**2-6. Дуу хоолойн удирдлагын тохиргоо**

Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх ..... 91

**2-7. Автомашины тохиргоо**

Дилерийн мэдээлэл тохируулах ..... 93
Аюулгүй байдлын тохиргоо өөрчлөх ..... 94
Программ хангамжийн мэдээлэл шалгах, шинэчлэх ..... 98

**2-8. Навигацийн тохиргоо**

Навигацийн системийн тохиргоо ..... 101
Газрын зургийн дэлгэцийн тохиргоо өөрчлөх ..... 102
Маршрутын зааварчилгаа ..... 104
Зааварчилгааны тохиргоо ..... 107
Бусад тохиргоо ..... 109

**2-9. Дуу болон медиа тохиргоо**

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх ..... 115
Дэлгэцийн горим солих ..... 118
Дүрсний чанар тохируулах ..... 119
Эх үүсвэр тус бүрийн дууны түвшин тохируулах ..... 120

**2-10. Wi-Fi® тохиргоо**

Wi-Fi® тохиргоо өөрчлөх ..... 121

**2-11. Bluetooth® тохиргоо**

Bluetooth® төхөөрөмж тохируулах ........ 123

**2-12. Арын суудлын энтертейнмент системийн тохиргоо**

Арын суудлын энтертейнмент системийн дэлгэцийн тохиргоо өөрчлөх ........ 127

Арын суудлын энтертейнмент системээр гаргаж буй видео болон зургийн дүрсний чанар тохируулах ........ 128

Арын суудлын энтертейнмент системийн дэлгэцийн горим солих ........ 129

Арын суудлын энтертейнмент систем дээр арын суудлын HDMI тохиргоо өөрчлөх 130

Арын суудлын энтертейнмент системийн лицензийн мэдээлэл шалгах ........ 132

**3 Ухаалаг утас, эсвэл холбоо харилцааны төхөөрөмж холбох**

**3-1. Bluetooth® функц ашиглах**

Bluetooth® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга ........ 134

Bluetooth® техник үзүүлэлт ба дэмжих функцууд ........ 137

Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмж бүртгэх ........ 139

Бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмж устгах ........ 143

Bluetooth® төхөөрөмжтэй холбох ........ 144

Bluetooth® төхөөрөмжийг үндсэн төхөөрөмжөөр бүртгэх... 148

Хоёрдогч төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулах ........ 149

**3-2. Wi-Fi® сүлжээнд холбох**

Wi-Fi® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга ........ 150

Wi-Fi® ашиглан сүлжээнд холбох ........ 152

**3-3. Apple CarPlay болон Android Auto ашиглах**

Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга ........ 155

Бүртгэлгүй ухаалаг утсаар Apple CarPlay ашиглах ........ 158

Бүртгэгдсэн утсаар Apple CarPlay ашиглах ........ 161

Android Auto ашиглах ....... 164

Apple CarPlay, эсвэл Android Auto доголдсон үед ........ 166

**4 Навигаци**

**4-1. Навигацийн системийн тухай**

Wi-Fi®-р газрын зургийн мэдээлэл илгээх үйлчилгээний тухай ....... 172

Серверт холбогдсон навигаци (автомашинд

суурилагдсан навигацитай) .................. 174

4-2. Газрын зургийн тухай мэдээлэл

Тухайн цэгийн тухай мэдээлэл гаргах .............. 175

Газрын зургийн сонголтын дэлгэц........... 176

POI тэмдэг гаргах ............. 177

Газрын зургийн дэлгэцийн тохиргоо........ 178

Хурдны замын горимын тухай ................................ 182

4-3. Очих газраар тохируулах байршил хайх

Очих газар хайх................ 183

Очих газар хайх дэлгэц.... 184

Хайлтын үр дүнгийн жагсаалтын дэлгэц.......... 187

Замын цэг нэмэх............... 188

Ухаалаг утаснаас очих газар тохируулах............ 189

4-4. Очих газар тохируулах

Бүтэн маршрутын газрын зургийн дэлгэц................ 191

Маршрут зааварчилгааны демо үзэх................................... 192

Маршрутын сонголт өөрчлөх............................ 193

Маршрут өөрчлөх ............ 194

Маршрутаар дамжин өнгөрөх цэгүүдийг тохируулах....................... 195

Замын цэгүүдийг засварлах......................... 196

4-5. Маршрутын зааварчилгаа

Маршрут зааварчилгааны дэлгэц. 197

Замын эгнээ харуулах дэлгэц ............................... 198

Маршрут дахин хайх ........ 200

Ердийн дуут зааварчилгаа .................. 201

4-6. Газрын зураг шинэчлэх

Газрын зургийн мэдээллийн сангийн хувилбар ба хамрах хүрээ................................. 202

5 Аудио систем

5-1. Радио ажиллуулах

Радио сонсох ..................... 204

DAB сонсох......................... 206

Радио антеннтай харьцах ........................... 208

5-2. Интернет радио

Интернет радио ашиглах 209

5-3. USB флаш ашиглах

USB флаш тоглуулах үеийн анхааруулга ......... 210

USB флашнаас дуу тоглуулах.......................... 212

USB флашнаас видео файл тоглуулах ............... 214

5-4. iPod/iPhone ашиглах

iPod/iPhone тоглуулах үеийн анхааруулга ......... 217

iPod/iPhone тоглуулах ...... 218

5-5. Apple CarPlay ашиглах

Apple CarPlay тоглуулах үеийн анхааруулга.......... 220

Apple CarPlay тоглуулах ... 221

5-6. Android Auto-н ажиллагаа

Android Auto тоглуулах үеийн анхааруулга.......... 223

Android Auto тоглуулах..... 224

**5-7. Bluetooth® аудионы ажиллагаа**

Bluetooth® аудио тоглуулах анхааруулга .. 226

Bluetooth® аудио тоглуулах .......................... 228

**5-8. Miracast®-н ажиллагаа**

Miracast® тоглуулах үеийн анхааруулга ......... 231

Miracast® дэмждэг төхөөрөмж холбох ......... 232

Miracast® тоглуулах .......... 233

**6 Арын суудлын энтертейнмент систем**

**6-1. Арын суудлын энтертейнмент системээр радио удирдах**

Арын суудлын энтертейнмент системээр радио сонсох 236

Арын суудлын энтертейнмент системээр DAB сонсох .... 237

**6-2. Арын суудлын энтертейнмент системээс USB удирдах**

Арын суудлын энтертейнмент системээр USB флашны дуу тоглуулах.................... 239

Арын суудлын энтертейнмент системээр USB флашны видео файл тоглуулах .... 241

Арын суудлын энтертейнмент системээр iPod, эсвэл iPhone-н дуу тоглуулах ... 243

**6-3. Арын суудлын энтертейнмент системээс ухаалаг утасны дуу тоглуулах**

Арын суудлын энтертейнмент систем дээр Apple CarPlay-н хөгжим тоглуулах ............ 245

Арын суудлын энтертейнмент системээр Android Auto-н дуу тоглуулах ................ 247

**6-4. Арын суудлын энтертейнмент системээр Bluetooth® аудио удирдах**

Арын суудлын энтертейнмент системээс холбогдсонBluetooth® төхөөрөмжийн дуу тоглуулах.......................... 249

**6-5. Арын суудлын энтертейнмент холбогдсон HDMI удирдах**

Арын суудлын энтертейнмент системээр арын суудлын HDMI медиа тоглуулах.......................... 251

**6-6. Арын суудлын энтертейнмент системээс холбогдсон Miracast® төхөөрөмж удирдах**

Арын суудлын энтертейнмент системээр Miracast® тоглуулах.......................... 252

Арын суудлаас Miracast® ашиглах үеийн анхааруулга..................... 253

Арын суудлаас Miracast®-д холбогдох...................... 254

Арын суудлын энтертейнмент систем

дээр арын суудлын Miracast® тоглуулах ........ 255

Арын суудлаас Miracast® салгах................................ 256

7 Гарны оролцоогүй дуудлага

7-1. Гарны оролцоогүй дуудлага ашиглах үеийн анхааруулга

Гарны оролцоогүй дуудлага ашиглах үеийн анхааруулга..................... 258

Автомашинаа зарах, устгалд оруулах үеийн анхааруулга..................... 262

Гарны оролцоогүй дуудлагад доголдол үүсэх нөхцөл.................... 263

7-2. Жолооны хүрдний товчоор гарны оролцоогүй дуудлага удирдах

Жолооны хүрдний товчоор удирдах ............. 267

7-3. Дуудлага хийх

Дуудлагын түүхээс дуудлага хийх.................. 269

Тогтмол ашигладаг жагсаалтаас дуудлага хийх.................................. 270

Холбоо барих хаягнаас дуудлага хийх.................. 271

Дугаар оруулан дуудлага хийх.................................. 272

Хүлээх, эсвэл түр зогсоох сигнал ашиглан дуудлага хийх.................. 273

7-4. Дуудлага хүлээн авах

Дуудлагад хариулах .......... 274

Ирсэн дуудлага таслах...... 276

7-5. Дуудлагын явцад удирдах

Дуудлагын дэлгэцнээс үйлдэл хийх ..................... 277

Давхар дуудлагад хариулах........................... 279

Дуудлага дундуур өөр хүн рүү дуудлага хийх............ 280

Олон хүнтэй зэрэг утсаар ярих.................................. 281

Дуудлага дуусгах................ 282

7-6. Гарны оролцоогүй дуудлагын утас солих

Гарны оролцоогүй дуудлагын утас солих ..... 283

7-7. Холбоо барих хаяг засварлах

Холбоо барих хаяг дамжуулах........................ 284

Холбоо барих хаягт шинэ хаягийн дата нэмэх......... 288

Тогтмол ашигладаг хаяг бүртгэх.............................. 290

7-8. Мессежний функц ашиглах

Мессежний функц ашиглах үеийн анхааруулга..................... 291

Мессежний функцаас дуудлага хийх.................. 296

8 Холбоотой үйлчилгээ

8-1. Веб хөтөч (Интернет)

Веб хөтчийн функцийн тухай (интернет).............. 298

Веб хөтчийн дэлгэц гаргах................................ 299

Веб хөтчийн дэлгэц удирдах ............................ 300

## 9 Хавсралт

9-1. Хавсралт

Аудио системээр ашиглах боломжтой медиа болон датаны мэдээлэл . 306

Арын суудлын энтертейнмент системээр ашиглах боломжтой медиа болон датагийн мэдээлэл........................... 317

Сертификат болон барааны тэмдэгтийн мэдээлэл........................... 318

Индекс....................................... 320

# Таньд хэрэгтэй мэдээлэл

## Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага

- Тус гарын авлага нь мултимедиа системийн ажиллагааг тайлбарладаг. Зөв ашиглах үүднээс тус гарын авлага болон "Owner's Manual"-тай сайтар уншиж танилцана.
- Программ хангамжийн шинэчлэл, техник үзүүлэлтийн өөрчлөлтөөс хамаарч тус гарын авлагын мэдээлэл бодит системээс зарим нөхцөлд өөр байж болно.
- Тус гарын авлага нь системийн программ хангамжийн Ver.1065 хүртэлх хувилбарыг агуулдаг. Шинэчлэгдсэн мэдээллийг дараах холбоосоос авна уу. Тус системийг ашиглахаас өмнө программ хангамжийн сүүлийн хувилбарын мэдээллийг шалгана уу.

  Зарим улс, бүс нутагт программ шинэчлэх боломжгүй байж болно.

  - URL:

    https://lexusmanuals.com.au/owners-manual-and-navigation-manual-updates/replace.html?param=om60s96e.lx.2112.cv.mm
  - QR код:

- Тус гарын авлага дахь дэлгэц нь ашиглах боломжтой функц, үйлчилгээнд хамрагдсан байдал, газрын зургийн дата мэдээлийн агуулга зэргээс хамаарч бодит дэлгэцнээс өөр байж болно.
- Тус гарын авлага дахь компанийн болон бүтээгдэхүүний нэр нь эдгээр компаниудад бүртгэлтэй барааны тэмдэгт болно.

## Дата өгөгдлийн нөхөн олговрын талаархи мэдэгдэл

Тус систем нь датаг дотоод санах ойдоо хадгалдаг. Санах ойд хадгалагдсан дата нь системийн алдаа, засвар, доголдол, программын алдаа болон бусад шалтгаанаас шалтгаалж дата өөрчлөгдөх, устаж болзошгүй.

Тоёота нь шууд ба/эсвэл шууд бус гэмтэлд ямар ч хариуцлага хүлээхгүй бөгөөд дотоод санах ойд хадгалагдсан өгөгдлийг зохих

ёсоор хадгалж чадаагүй тохиолдолд өгөгдөлд нөхөн төлбөр өгөхгүй гэдгийг анхаарна уу.

## Аккумулятор салах тухай

Асаах товчийг унтраах бүрт мултимедиа систем нь олон төрлийн датаг хадгалдаг. Дата бүрэн хадгалагдахаас өмнө аккумулятор салгасан үед дата зөв хадгалагдахгүй байж болно.

## Австрали улсын хэрэглэгчдэд

Lexus группын хувийн мэдээллийн нууцлал болон кредит мэдээллийн бодлогыг http://www.lexus.com.au/privacy-с харна уу.

## Ашиглалтын аюулгүй байдал

Тус системийг аюулгүй ашиглах үүднээс дараах бүх аюулгүйн зөвлөгөөг дагана.

Тус систем нь зөв ашигласан үед зорьсон газартаа хүрэхэд туслах зорилготой. Жолооч нь тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагаа, зорчигчдын аюулгүй байдлыг дангаараа хариуцна. Тус системийн аливаа функцийг анхаарал болгоомжгүй жолоодлого, аюулгүй байдлыг хангаагүй жолоодлогод ашиглаж болохгүй. Жолоодлогын үед нэн түрүүнд анхаарах зүйл бол тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагаа байх ёстой. Жолоодлогын үед замын хөдөлгөөний бүх дүрмийг дагаж мөрдөнө. Хэрэв замын хөдөлгөөний тэмдгийг өөрчилсөн бол нэг чигийн хөдөлгөөн зэрэг шинэчлэгдсэн мэдээлэл байхгүй байж болно..

Аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх байдлаар ашиглаж болохгүй. Жолоодлогын үед замын хөдөлгөөний дүрмийг цаг ямагт мөрдөн аюулгүй жолоодно.

Жолоодлогын үед аль болох дуут зааварчилгааг түлхүү сонсох ба зөвхөн аюулгүй үед дэлгэц рүү богино харна. Нөгөөтэйгүүр дуут зааварчилгаанд хэт даатгаж болохгүй. Зөвхөн мэдээллийн журмаар ашиглана. Систем одоогийн байршлыг зөв тогтоож чадахгүй үед зааварчилгаа буруу, эсвэл оройтож өгөх, эсвэл дуут зааварчилгаа огт өгөхгүй байж болно.

Нөхцөл байдлаас хамаарч дата өгөгдөл дутуу байж болно. Баруун зүүн эргэх, зам хаах зэрэг замын хөдөлгөөний мэдээлэл тогтмол өөрчлөгдөж болно. Тиймээс системийн зааврыг дагахаас өмнө зааврыг аюулгүй бөгөөд хууль дүрмийн дагуу хийх боломжтой эсэхийг нягтлана.

**⚠ АЮУЛТАЙ**

- Аюулгүйн үүднээс жолооч жолоодлого хийх үедээ системийг удирдаж болохгүй. Зам болон замын хөдөлгөөний нөхцөлд анхаарал дутуу хандуулах нь осолд хүргэх аюултай.
- Жолоодлогын үед замын хөдөлгөөний дүрмийг баримтлах ба замын нөхцөл байдлыг мэдэх шаардлагатай.

# Гарын авлагын тэмдэг

Тус гарын авлагад ашиглагдсан тэмдгийг утга тайлбарлана.

## Гарын авлагын тэмдэг

| Тэмдэг | Утга |
|---|---|
|  | АЮУЛТАЙ : Дагаж мөрдөөгүй тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах зүйлсийг тайлбарлана. |
|  | АНХААР : Дагаж мөрдөөгүй тохиолдолд автомашин болон түүний эд ангид гэмтэл учруулах зүйлсийг тайлбарлана. |
| 1 2 3... | Үйлдлийн, эсвэл ажиллагааны дарааллыг илгэнэ. |
|  | Мэдээлэл : Ажиллуулах арга, функцаас бусад мэдүүштэй зүйлсийг тайлбарлана. |

## Зураг дахь тэмдэг



| Тэмдэг | Утга |
|---|---|
|  | Товч болон төхөөрөмжийг ажиллуулах үеийн үйлдэл (дарах, эргүүлэх г.м.)-г тайлбарлана. |



| Тэмдэг | Утга |
|---|---|
|  | Тайлбарлаж буй эд анги, түүний байрлалыг заана. |

# Зурган индекс

## Урд талын удирдлагын самбар

Дараах зурагт зүүн жолооны хүрдтэй автомашиныг харуулав.





A Микрофон ........ Х.62

B Жолооны хүрдний товч

Аудио удирдах ........ Х.37

Дуут команд ашиглах ........ Х.63

Дуудлага хийх ........ Х.267

C Дэлгэц ........ Х.17

D [PWR･VOL] товч ........ Х.36

E USB порт ........ Х.40

F SOS товч*1


*1 : Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

# 1 Үндсэн ажиллагаа

1-1. Мултимедиа системийн үндсэн ажиллагаа

Дэлгэц ба удирдлага ........... 17

Мултимедиа системийн ерөнхий мэдээлэл ............ 19

Үндсэн цэс ............................ 20

Статусын тэмдэг.................. 22

Мэдрэгчтэй дэлгэц удирдах .............................. 24

Дэлгэцийн үндсэн функц ... 27

Тоо ба үсэг бичих................ 29

1-2. Газрын зургийн үндсэн ажиллагаа

Газрын зургийн дэлгэц....... 30

Автомашины одоогийн байршлыг дэлгэц дээр гаргах................................. 32

Газрын зургийн масштаб өөрчлөх .............................. 33

Газрын зургийн чиглэл өөрчлөх .............................. 34

Газрын зураг хөдөлгөх ....... 35

1-3. Аудио системийн үндсэн ажиллагаа

Аудио систем асаах унтраах, дууны түвшин тохируулах......................... 36

Аудио эх үүсвэр солих ........ 37

Эх сурвалж сонгох дэлгэц дээрх жагсаалтын байршлыг өөрчлөх........... 39

USB портод холбох............. 40

1-4. Арын суудлын энтертейнмент системийн үндсэн ажиллагаа

Арын суудлын энтертейнмент системийн функц ба ажиллагаа.......................... 41

Арын суудлын энтертейнмент систем ажиллуулах........................ 44

Арын олон үйлдэлт удирдлагын самбараар арын суудлын энтертейнмент систем ажиллуулах........................ 45

Арын суудлын энтертейнмент систем асааж унтраах ................... 47

Арын суудлын энтертейнмент системийн дэлгэц унтрааж зөвхөн аудио дуугаргах............................ 48

Арын суудлын дэлгэцний өнцөг тохируулах ............. 50

Арын суудлын энтертейнмент системд HDMI төхөөрөмж холбох (7 суудалтай)...................... 52

Арын суудлын энтертейнмент системд HDMI төхөөрөмж холбох (4 суудалтай)...................... 53

Арын суудлын энтертейнмент системийн эх үүсвэр солих.................................. 54

Арын суудлын энтертейнмент системийн дууны түвшин тохируулах........... 56

Арын суудлын энтертейнмент системийн аудио гаралт солих................................... 57

Чихэвч ашиглах (7 суудалтай загвар).............. 58

Чихэвч ашиглах (4 суудалтай)........................... 59

Урд суудлын аудио системээс арын суудлын энтертейнмент систем удирдах .............................. 60

**1-5. Дуу хоолойн удирдлагын систем**

Системийг дуу хоолойн удирдлагын системээр удирдах .............................. 61

Дуу хоолойн удирдлага эхлүүлэх.............................. 63

Дуу хоолойн команд хэлэх.................................... 65

Дэлгэцний гар ашиглан мэдээлэл хайх .................... 69

## Дэлгэц ба удирдлага




A Дэлгэц

Мэдрэгчтэй дэлгэц дээр шууд даран удирдана.

B [**PWR･VOL**] товч

Аудио асааж унтраах, дууны түвшинг тохируулна.

### МЭДЭЭЛЭЛ

- Хүрээлэн байгаа орчин, эсвэл харж буй өнцгөөс хамаарч LCD дэлгэц цайрах, эсвэл харлаж харагдаж болно.
- Нарны гэрэл, эсвэл бусад дэлгэц дээр тусч буй гэрлээс шалтгаалж дэлгэц сайн харагдахгүй байж болно.
- Хэрэв та туйлширсан нарны шил зүүсэн бол дэлгэц нь бараан эсвэл харагдахад хэцүү байж болно.

### ⚠ АЮУЛТАЙ

Аюулгүйн үүднээс жолооч жолоо барихдаа дэлгэцийг аль болох бага удирдах ба удирдах үедээ автомашинаа зогсоох нь зүйтэй. Жолоодлогын үед дэлгэц удирдах нь жолоогоо буруу эргүүлэх, мөн бусад гэнэтийн осол зэрэг аюултай. Автомашин жолоодох үед дэлгэцийг зөвхөн шаардлагатай бөгөөд аль болох богино хугацаанд харна.

### ⚠ АНХААР

Хөдөлгүүр унтраастай үед удаан хугацаанд ашиглаж болохгүй. Аккумуляторын цэнэг суулгах аюултай.

## Систем дахин асаах

Системийн хариу үйлдэл хэт удан үед систем дахин асаах боломжтой.

● **[PWR·VOL] товчийг 3 секундээс удаан дарна.**



## Мултимедиа системийн ерөнхий мэдээлэл




**A** Үндсэн цэс

Тэмдэг дээр дарж дэлгэц дэх функцийг өөрчлөх боломжтой.

**B** Микрофоны товч

Дуут удирдлагын дэлгэц гаргах, навигаци болон аудио зэрэг олон төрлийн функцийг дуу хоолойгоор удирдах боломж бүрдүүлдэг.

**C** Статусын тэмдэг

Цаг, холболтын статус зэрэг мэдээллийн дүрс тэмдэг харагдана.

### МЭДЭЭЛЭЛ

[  ] нь тус автомашин дээр гарахгүй.

### Холбоотой холбоосууд

Үндсэн цэс(Х. 20)

Дуу хоолойн удирдлага эхлүүлэх(Х. 63)

Статусын тэмдэг(Х. 22)

## Үндсэн цэс

Дэлгэц дээр гарах функцийг тэмдэг даран өөрчлөх боломжтой.




: Apple CarPlay®

Apple CarPlay-н дэлгэц гаргана.

: Android Auto™

Android Auto-н дэлгэц гаргана.

: Navigation system

Газрын зургийн дэлгэц гаргана. Навигацийн систем ашиглан маршрут хайх, эсвэл бусад навигацитай холбоотой үйлдэл хийх боломжтой.

: Audio

Аудио удирдлагын дэлгэц гаргана. Тоглуулах аудио эх үүсвэр сонгоно.

: Phone

Гар утасны дэлгэц гаргана. Bluetooth®-р холбосон гар утсыг гарны оролцоогүй утсаар ашиглах боломжтой.

: Vehicle information[*1]

Автомашины мэдээллийн дэлгэц гаргана. Шатахуун зарцуулалт зэрэг автомашины мэдээлэл, мөн автомашины төхөөрөмжийн тохиргоо хийх боломжтой.

: Connected

Аппликейшны дэлгэц гаргана.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй. Дэлгэрэнгүйг (үйлчилгээ ашиглах боломжтой улс, ажиллагаа, тохиргоо зэрэг) та өөрийн Lexus дилерээс тодруулна уу.

: Settings

Тохиргооны дэлгэц гаргана. Мултимедиа систем болон автомашины тохиргоог өөрчлөх боломжтой.

### МЭДЭЭЛЭЛ

Дэмжигддэг төхөөрөмж системд холбосон ба холбогдох функцийг идэвхжүүлэх үед Apple CarPlay/Android Auto-н тэмдэг дэлгэцээр гарна.

*1 : Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

## Статусын тэмдэг

Дэлгэцийн дээд хэсэгт цаг болон холболтын статусыг харуулах тэмдэг гардаг.




4:12

Одоогийн цаг заана. Цаг дээр товшиж цаг болон огноо тохируулах дэлгэцэнд шилжинэ.



Bluetooth®-р холбосон гар утасны холболтын статус харуулна. Тэмдэг дээр товшиж Bluetooth® тохиргооны дэлгэцэнд шилжинэ.



Холбогдсон гар утасны сүлжээ хүлээн авалтын түвшинг харуулна.



Холбогдсон гар утасны зайны цэнэгийг харуулна.




Дата дамжуулалтын модуль (DCM)-н сүлжээний түвшинг заана. (Тус функцийг зарим улсад ашиглах боломжгүй.)



Wi-Fi® сүлжээний дохионы түвшинг харуулна.



Intuitive parking assist систем ажиллах үед гарна.



Утасны дэлгэцээс бусад дэлгэц гарч байгаа үед гарны оролцоогүй дуудлага хийгдсэн үед гарна.



Интернет радио тоглуулах үед гарна. (Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.)

Утасгүй цэнэглэгч ассан үед гарна.*1

### МЭДЭЭЛЭЛ

- Систем болон гар утасны дэлгэц дэх гар утасны зайны цэнэгийн хэмжээ өөр байж болно. Мөн гар утасны загвараас хамаарч дэлгэцээр зайны цэнэгийн хэмжээ гарахгүй байж болно.
- Долгионы хүч сул үед Wi-Fi® хүлээн авах боломжгүй байж болно.
- Гар утас дараах байрлалд байгаа үед Bluetooth® функц ашиглах боломжгүй байж болно:
  - Гар утас суудлын ард болон доод тал, эсвэл урд хайрцаг, голын хайрцагт байгаа үед
  - Гар утас металл зүйлд хүрсэн, эсвэл халхлагдсан
- Гар утас зайны цэнэг хэмнэх горимд байгаа үед Bluetooth® холболт автоматаар салгагдаж болно. Энэ үед зайны цэнэг хэмнэх горимыг унтраана.

### Холбоотой холбоосууд

Мултимедиа системийн ерөнхий тохиргоог өөрчлөх(Х. 86)

Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 123)

*1 : Тоноглогдсон автомашинд

## Мэдрэгчтэй дэлгэц удирдах

Мэдрэгчтэй дэлгэцийг хуруугаараа шууд товши удирдана.

### ■ Товших

Дэлгэцийг зөөлөн товшино. Тус үйлдлээр дэлгэц дээрээс сонголт хийх боломжтой.



### ■ Чирэх

Дэлгэц дээр хуруугаараа дарангаа хуруугаа хөдөлгөнө. Тус үйлдлээр жагсаалт болон газрын зургийг гүйлгэх боломжтой.



### ■ Товшингоо хуруугаа хурдан шилжүүлэх

Дэлгэц товшсон хуруугаа хурдан шилжүүлнэ. Тус үйлдлээр жагсаалт болон газрын зургийг гүйлгэх боломжтой.



### ■ Чимхэж ойртуулах/холдуулах

Дэлгэц дээр 2 хуруугаараа дарангаа хуруугаа хөдөлгөнө. Тус үйлдлээр газрын зураг томруулах, жижигрүүлэх боломжтой.



### МЭДЭЭЛЭЛ

- Зарим функцийг ажиллуулах үед дэлгэцийг товшоод удаан дарах, эсвэл 2 удаа товших шаардлагатай.
- Дэлгэц дээр товших үеийн дэлгэцийн мэдрэг байдлыг өөрчлөх боломжтой.
- Дэлгэц дээр товших үеийн хариу дууг ON/OFF-р тохируулах боломжтой.
- Өндөр газар хуруугаараа товшоод шилжүүлэх үйлдэл сайн ажиллахгүй байж болно.
- Жолоодлогын үед дэлгэц удирдах үйлдлэл хязгаарлагддаг.

### Холбоотой холбоосууд

Мултимедиа системийн ерөнхий тохиргоог өөрчлөх(Х. 86)

## Мэдрэгчтэй дэлгэц ашиглах үеийн анхааруулга

### МЭДЭЭЛЭЛ

- Дэлгэцний товч хариу үйлдэл үзүүлэхгүй үед дэлгэцнээс гараа аваад дахин хийнэ.
- Дараах нөхцлүүдэд дэлгэцний товч хариу үйлдэл үзүүлэхгүй, эсвэл доголдоно:
  - Бээлий өмссөн
  - Дэлгэц дээр хумсаараа товшсон
  - Дэлгэц дээр товших үед өөр хуруу, эсвэл гарын алга дэлгэцэнд зэрэг хүрсэн
  - Дэлгэц бохирдсон, эсвэл дэлгэц дээр ус тогтсон
  - Дэлгэц дээр хуванцар хуулга, наалт наасан

- Автомашин телевизийн цамхаг, цахилгаан станц, ШТС, радио станц, том дэлгэц, нисэх буудал, эсвэл бусад хүчтэй радио долгион, шуугиан үүсгэдэг газрын ойр орчимд байгаа
- Радио, гар утас зэрэг утасгүй харилцаа холбооны төхөөрөмж автомашинд авч орсон, эсвэл цэнэглэж байгаа үед

● Мэдрэгчтэй дэлгэцийг дараах металл эд зүйлээр дарсан, халхалсан үед товч хариу үйлдэл үзүүлэхгүй, эсвэл доголдоно:

- Хөнгөн цагаан ялтас зэрэг металлаар бүрхэгдсэн карт
- Хөнгөн цагаан ялтастай тамхины хайрцаг
- Металл эд ангитай түрийвч, цүнх зэрэг
- Зоос
- CD, DVD зэрэг медиа болон USB холбогч зэрэг.

● Систем асч байх үед дэлгэц дээр хуруугаараа дарж байсан нөхцөлд дэлгэц товших үйлдэлд хариу үзүүлэхгүй байж болно. Дэлгэцнээс гараа аваад дахин товшино. Хэрэв тус үйлдлийг хийсэн ч дэлгэц хариу үйлдэл үзүүлэхгүй байгаа нөхцөлд хөдөлгүүр асаах товч унтрааж системийг дахин асаана.

● Apple CarPlay-н газрын зургийн апп нь 2 хуруугаар чимхэж ойртуулах, холдуулах үйлдлийг дэмждэггүй.

## ⚠ АНХААР

● Дэлгэц хамгаалах үүднээс дэлгэцтэй харьцах үед хуруугаараа зөөлөн товшино.

● Хуруунаас өөр зүйлээр дэлгэц удирдаж болохгүй.

● Нүдний шилний алчуур, эсвэл түүнтэй адил зөөлөн даавуугаар дэлгэцийг зөөлөн арчиж цэвэрлэнэ. Дэлгэц дээр хуруугаараа хүчтэй товших, эсвэл хатуу зүйлээр хүчтэй арчсан нөхцөлд дэлгэц дээр зураас үүсэх аюултай.

● Бензин, эсвэл бусад шүлтлэг шингэнээр дэлгэц цэвэрлэж болохгүй. Дэлгэц гэмтээх аюултай.

● Тодорхой нөхцлүүдэд дэлгэц халсан гэж мэдрэгдэж болно. Хөнгөн түлэгдэл үүсгэж болзошгүй тул дэлгэцийн удаан дарахаас зайлсхийнэ.

## Дэлгэцийн үндсэн функц

Тохиргоо болон аудио зэрэг олон сонгох сонголтууд байгаа үед жагсаалт дэлгэцээр гарна. Дэлгэцийг гүйлгэж сонголт хийнэ.




A Үндсэн цэс

Тэмдэг дарж дэлгэцээр гарах функцийг өөрчлөнө.

B Дэд цэс

Жагсаалт дахь зүйлсийг харуулна. Дэлгэцийг хуруугаар доош дарах, чирж жагсаалтыг гүйлгэнэ.

C Тайлбарын хэсэг

Дэд цэсэн дээр сонгосон зүйлийн дэлгэрэнгүй мэдээллийг гаргана.

D Түвшний дараалын жагсаалт

Дэлгэцийн нэрийг түвшний дарааллаар харуулна. [<]-г дарж нэг дээд түвшинд шилжинэ.

**МЭДЭЭЛЭЛ**

Жолоодлогын үед дэлгэц удирдах үйлдэл хязгаарлагддаг.

### ■ Жагсаалт хайх

Индекс дэх текстийг дарж жагсаалтаас сонгосон зүйлээ дэлгэц дээр гаргана.



## ■ Тохиргоог асаах, унтраах

Дарж тухайн тохиргоог асааж унтраана.

 : ON

 : OFF




## ■ Олон тохиргооны сонголт

[ ⋮ ] тэмдэгтэй зүйлийг товшиж олон сонголтоос сонголт хийх боломжийг идэвхжүүлдэг.




## ■ Түвшин тохируулах

Дээш доош гүйлгэн түвшний тохиргоо хийх боломжтой.




### Холбоотой холбоосууд

Үндсэн цэс(Х. 20)

## Тоо ба үсэг бичих

Дэлгэцийн гар ашиглан тоо ба үсэг бичих боломжтой. Үсэг бичих үед санал болгох үгийн хувилбарууд гарна.

▶ Дэлгэцийн жишээ




: Дэлгэцийн гар хааж өмнөх дэлгэцэнд буцна.

: Курсор хөдөлгөнө.

: Тухайн бичсэн текст дээр үндэслэн санал болгох үгийг харуулна.

: Нэг үсэг арилгана.

: Дэлгэцийн гар солино.*1

: Том жижиг үсгээр солино.

[**Go**] : Бичсэн текст дээр үндэслэн хайлт хийнэ.

: Дэлгэцийн гар хаана.

123 : Тоо болон тэмдэгт бичих горимд солино.

ABC : Үсэг бичих горимд шилжүүлнэ.

### МЭДЭЭЛЭЛ

- Функцаас хамаарч гарны төрөл өөр байна.
- [ ]-г удаан дарж дэлгэцийн гарны төрөл сонгоно.*1
- [ ]-г 2 товшиж үсгийг том үсэг болгон засна.

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

## Газрын зургийн дэлгэц

Газрын зургийн дэлгэцээр дараах ашиглалт бүхий мэдээлэл гарна.

Үндсэн цэсний [ ]-г дарна.




A Одоогийн байршлын тэмдэг

Автомашины одоогийн байршил болон чиглэл харуулна.

B Эгнээний мэдээллийн дэлгэц

Уулзвар дээр эргэх, шулуун явах эгнээг харуулна.(Зөвхөн газрын зургийн дата мэдээлэлтэй уулзвар дээр ашиглах боломжтой)

Маршрутын зааварчилгааны үед систем явахыг зөвлөж буй эгнээг тодруулж харуулна.

C Нэрийн дэлгэц

Нөхцөл байдлаас хамаарч дараах зүйлс гарч болно: (Зөвхөн газрын зургийн дата мэдээлэлтэй цэгүүдэд хамаарна)

- Явж буй замын нэр

D Масштабын дэлгэц

Газрын зургийн масштаб гаргана.

E Зүг чигийн тэмдэг

Газрын зургийн зүг чигийг заана. Өөрчлөх үед товшино.

Газрын зургийн зүг чиг өөрчлөх тухай дэлгэрэнгүй мэдээллийг газрын зургийн зүг чиг хэсгээс харна уу.

F Томруулах/жижигрүүлэх товч

Газрын зураг томруулах буюу жижигрүүлнэ.

G Дэлгэцийн тохиргооны товч

Дэлгэцийн тохиргооны дэлгэц гарган ойр байрлах POI дэлгэцийн тохиргоо зэргийг өөрчлөнө.

H Очих газрын товч

Очих газар хайх дэлгэц гаргана.

I Микрофоны товч

Дуу хоолой таних дэлгэц гаргана.

### Холбоотой холбоосууд

Автомашины одоогийн байршлыг дэлгэц дээр гаргах(Х. 32)
Газрын зургийн чиглэл өөрчлөх(Х. 34)
Газрын зургийн дэлгэцийн тохиргоо(Х. 178)
Очих газар хайх(Х. 183)
Системийг дуу хоолойн удирдлагын системээр удирдах(Х. 61)

## Автомашины одоогийн байршлыг дэлгэц дээр гаргах

Автомашины одоогийн байршлыг [ ] тэмдгээр илэрхийлдэг.



Газрын зургийн дэлгэцийг гүйлгэсэн үед үндсэн цэсний [ ], эсвэл [ ]-г дарж газрын зургийг автомашины одоогийн байршилд буцаана.

### МЭДЭЭЛЭЛ

- Автомашин шинэ үед, эсвэл аккумуляторын шон салгаад дахин залгасан үед автомашины байршлын тэмдэг [ ] автомашины бодит байршлаас (автомашины байршлын тэмдэг [ ] буруу заах) өөр байж болно. Нөгөөтэйгүүр автомашины байршлын тэмдэг [ ] буруу зааж байгаа ч тодорхой хугацаанд жолоодсоны дараа GPS мэдээлэл ашиглан автоматаар одоогийн бодит байрлалыг зөв заана. (Зарим нөхцөлд хэдэн минут шаардагдаж болно.) GPS-н мэдээлэл ашиглаагүй, эсвэл байршил автоматаар засагдахгүй үед автомашиныг аюулгүй газар зогсоон одоогийн байршлыг засна.
- Газрын зургийн өнгөнөөс хамаарч автомашины байршлын тэмдгийн [ ] хэлбэр өөрчлөгдөнө.

### Холбоотой холбоосууд

Газрын зургийн дэлгэцийг өөрийн хүссэнээр тохируулах(Х. 103)
Байршил/Чиглэлийн тохиргоо(Х. 113)

## Газрын зургийн масштаб өөрчлөх

Газрын зургийн дэлгэцийг томруулах/жижигрүүлэх боломжтой.

Газрын зургийн дэлгэцний [+], эсвэл [−]-г дарна.



- Дэлгэц дээр 2 хуруугаараа чимхэж ойртуулах, холдуулах болон бусад тусгай товших үйлдлээр масштаб мөн өөрчлөх боломжтой.
  - 2 товшиж ойртуулах: Дэлгэцийг хурдан 2 удаа товшино
  - Товшиж жижигрүүлэх: Дэлгэцийг 2 хуруугаараа товшино
- [+]/[−]-г удаан дарж масштаб үргэлжлүүлэн өөрчилнө.

### Хотын газрын зураг

Газрын зургийг бүтэн томруулсан үед хотын газрын зураг харуулах боломжтой.

Газрын зургийн 50 м (150 фут) масштаб сонгосон үед [+]-г дарна.

Хотын газрын зураг цуцлах үед [−]-г дарах, эсвэл дэлгэцийг 2 хуруугаар чимхэн холдуулна.

**МЭДЭЭЛЭЛ**

- Тухайн газар нутаг нь газрын зургийн датад ороогүй үед хотын газрын зураг гаргах боломжгүй.
- Хотын газрын зургийн мэдээлэлгүй газар луу автомашин орсон үед хотын газрын зураг автоматаар цуцлагдана.

## Газрын зургийн чиглэл өөрчлөх

Газрын зургийн чиглэлийн хөдөлгөөнгүйгээр тохируулах, эсвэл автомашины чиглэл даган өөрчлөгдөхөөр тохируулах боломжтой.

Газрын зургийн дэлгэцний []-г дарах бүрт чиглэл хойд зүг дээд талд, явж буй чиглэл дээд талд болон 3D дэлгэцийн горимд өөрчлөгдөнө.

● Хойд зүг дээд талд []

Автомашины чиглэлээс үл хамааран ямагт хойд зүгийг дээд талд харуулна.

● Явж буй чиглэлийг дээд талд []

Тус газрын зураг нь автомашины явж буй чиглэлийг ямагт дээд талд гаргана.

● 3D газрын зураг []

3D газрын зураг гаргана. 3D газрын зураг дээр товшсон үед автомашины явж буй чиглэлийг ямагт дээд талд харуулна.

### МЭДЭЭЛЭЛ

- 3D газрын зургийн дэлгэцийн өнцгийг өөрчлөх боломжтой.
- Газрын зургийн чиглэл явж буй чиглэлийг дээд талд, эсвэл 3D газрын зургаар тохируулсан үед дэлгэцийг одоогийн байрлалын дэлгэцнээс бусад дэлгэцэнд (очих газар тохируулах дэлгэц, маршрутын бүтэн газрын зургийн дэлгэц зэрэг) шилжүүлсэн үед хойд зүгийг дээд талд харуулах дэлгэцэнд шилжинэ. Одоогийн байршлын дэлгэцэнд буцах үед явж буй чиглэлийг дээд талд, эсвэл 3D газрын зургийн дэлгэцэнд буцна.

### Холбоотой холбоосууд

Дэлгэцийн өнцгийн тохиргоо(Х. 103)

## Газрын зураг хөдөлгөх

Газрын зургийг хөдөлгөж товшсон цэгийг газрын зургийн дэлгэцний төв болгох боломжтой.

Газрын зураг дахь дурын цэг дээр товшино.

● Газрын зургийн дэлгэцний төв тухайн товшсон цэг рүү шилжинэ.



● Газрын зураг шилжүүлсэн тухайн байршил, эсвэл POI-г очих газраар тохируулах, тогтмол ашигладаг хаягаар бүртгэх боломжтой. Мөн тухайн POI-н мэдээлэл байгаа үед дэлгэцээр гаргах боломжтой.

● Газрын зураг хөдөлгөөд [ ]-г дарж тухайн цэгийг шинэ очих газар, эсвэл замын цэгээр тохируулах боломжтой.

● [ ], эсвэл [ ]-г дарж автомашины одоогийн байрлалд буцаана.

### МЭДЭЭЛЭЛ

Газрын зургийг дэлгэц дээр товших, чирэх, 2 хуруугаараа удирдах үйлдлээр шилжүүлэх боломжтой.

### Холбоотой холбоосууд

Мэдрэгчтэй дэлгэц удирдах(Х. 24)

Газрын зургийн чиглэл өөрчлөх(Х. 34)

Тухайн цэгийн тухай мэдээлэл гаргах(Х. 175)

## Аудио систем асааж унтраах, дууны түвшин тохируулах

Ашиглаагүй үед аудио систем унтраах, мөн тохирох түвшинд дууны түвшинг тааруулах боломжтой.

Асаах товчны ACC, эсвэл ON горимд систем ашиглах боломжтой.

**⚠ АНХААР**

- Хөдөлгүүр асаагүй үед аудио системийг удаан ашиглаж болохгүй. Аккумуляторын цэнэг сууна.
- Аюулгүй жолоодлогод саад болохгүй тохиромжтой дууны түвшин сонгоно.

### ■ Аудио удирдлагын товчоор удирдах

**[PWR·VOL] товч**

Товч дарах бүрт асааж унтраана. Эргүүлж дууны түвшин тохируулна.



### ■ Жолооны хүрдний товчоор удирдах

**[+] товч**

Дууны түвшинг нэмнэ.

Удаан дарж үргэлжлүүлэн өөрчилнө.

**[-] товч**

Дууны түвшинг багасгана.

Удаан дарж үргэлжлүүлэн өөрчилнө.



## Аудио эх үүсвэр солих

Радио, USB зэрэг эх үүсвэр сонгох боломжтой.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 [Sources]-г дарна.**

**3 Сонгох эх үүсвэр дээр дарна.**




### МЭДЭЭЛЭЛ

- Хэрэв гар утсыг аудио сонсох үедээ автомашин дотор, эсвэл хөгжимд ойр байлгасан нөхцөлд аудио спикерээс шуугиан үүсч болно.
- Apple CarPlay-г хэрхэн холбосноос хамаарч дараах функцийг ашиглах боломжгүй.
  - iPod
  - USB аудио, эсвэл USB видео
  - Bluetooth® аудио
  - Miracast®
  - Android Auto
- Android Auto холбосон үед дараах функцийг ашиглах боломжгүй.
  - iPod
  - USB аудио, эсвэл USB видео
  - Apple CarPlay

## Жолооны хүрдний товчоор эх үүсвэр солих

Жолооны хүрдний товчоор эх үүсвэр солих боломжтой.



**[MODE] товч**

Эх үүсвэр дарааллын дагуу солигдоно.

Удаан дарж түр зогсоох, эсвэл дууг түр хаана. Дахин удаан дарж цуцлана.

Эх үүсвэр сонгох дэлгэцний товчны байрлал солисон үед солих дараалал мөн өөрчлөгдөнө.

## Эх сурвалж сонгох дэлгэц дээрх жагсаалтын байршлыг өөрчлөх

Илүү хялбараар удирдах боломж бүрдүүлэн жагсаалтын байршлыг өөрчлөх боломжтой.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Sources]-г дарна.**

3 **Жагсаалтын байршлыг тухайн байршлыг өөрчлөх гэж буй эх үүсвэрийн баруун талын [ ]-г чирж өөрчилнө.**



## USB портод холбох

Ухаалаг утас, зөөврийн төхөөрөмж зэрэг төхөөрөмж холбоно.

● **USB холбогчийг портод холбоно.**



USB флаш холбох үед шууд USB портод холбоно.

### МЭДЭЭЛЭЛ

- Төхөөрөмжөөс хамаарч файл үзэх боломжгүй байж болно.
- Дэлгэрэнгүй мэдээллийг холбох гэж буй USB холбогч, төхөөөрөмжийн заавраас харна уу.
- Батерей зэрэг холбогдсон төхөөрөмжийг цахилгааны эх үүсвэрийг ашиглана. Автомашины цахилгааны залгуур ашиглах нь шуугиан үүсгэж болно. (Цахилгааны залгуурын тухай дэлгэрэнгүй "Owner's Manual"-с харна уу.)

### АНХААР

- Холбогдсон төхөөрөмжийг доош дарах, хөндлөн хөшиж болохгүй. Төхөөрөмж болон порт гэмтээх аюултай.
- Портод гадны зүйл орохоос сэргийлнэ. Төхөөрөмж болон порт гэмтээх аюултай.

## Арын суудлын энтертейнмент системийн функц ба ажиллагаа*1

Арын суудлын энтертейнмент систем нь урд суудлын аудио системтэй адил, эсвэл арын суудалд өөр эх үүсвэрийг үзэх, сонсох боломж бүрдүүлдэг. Баруун болон зүүн арын суудлын дэлгэцний эх үүсвэр сонгоно.

### ■ 7 суудалтай




A Арын суудлын дэлгэц
B Урд суудлын аудио систем
C HDMI порт
D Чихэвчний залгуур

## ■ 4 суудалтай




A Чихэвчний залгуур
B Арын суудлын дэлгэц
C Урд суудлын аудио систем
D HDMI порт
E Арын олон үйлдэлт удирдлагын самбар

### МЭДЭЭЛЭЛ

- Арын суудлын энтертейнмент системийг асаах товчны ACC, эсвэл ON горимд ашиглах боломжтой.
- Систем асах үед тодорхой хугацаанд дэлгэц ашиглалттай холбоотой анхааруулга гарна.

### ⚠ АНХААР

Дэлгэцийн бохирдлыг зөөлөн хуурай даавуугаар зөөлөн арчиж цэвэрлэнэ.

Гараар хүчтэй дарах, хатуу даавуугаар арчих зэрэг нөхцөлд дэлгэцэнд хортон зураас үүснэ.

## ■ Текстэн мэдээллийн дэлгэцийн тухай мэдээлэл

Дэлгэц тус бүр дээр гаргах боломжтой текстийн тэмдэгтийн тоо хязгаартай байдаг. Систем бүх мэдээллийг гаргаж чадахгүй байж

*1 : Тоноглогдсон автомашинд

болно. Мөн хадгалагдсан контентоос хамаарч мэдээлэл зөв гарахгүй байх тохиолдлууд байдаг.

## Арын суудлын энтертейнмент систем ажиллуулах

Арын суудлын энтертейнмент системийг дараах үйлдлээр ажиллуулна.

**Мэдрэгчтэй удирдлагын самбар**

Самбар дээр товшин ажиллуулна.

**Арын олон үйлдэлт удирдлагын самбар*1**

Арын суудлын гарны түшлэг дэх арын олон үйлдэлт удирдлагын самбараар удирдана.

### Холбоотой холбоосууд

Арын олон үйлдэлт удирдлагын самбараар арын суудлын энтертейнмент систем ажиллуулах(Х. 45)

*1 : Тоноглогдсон автомашинд

## Арын олон үйлдэлт удирдлагын самбараар арын суудлын энтертейнмент систем ажиллуулах*1

Арын гарын түшлэгт байрлах арын олон үйлдэлт удирдлагын самбараар арын суудлын энтертейнмент систем удирдана.

**1 Арын гарын түшлэгний [ ]-г дарна.**

Арын олон үйлдэлт удирдлагын самбарын үндсэн дэлгэц гарч ирнэ.

**2 [Audio]-г сонгоно.**

**3 [Left], эсвэл [Right]-г дарж удирдах дэлгэцээ сонгоно.**

Арын суудлын энтертейнмент системийн удирдлагын дэлгэц гарна.

Сонгосо эх үүсвэрээс хамаарч дэлгэцээр гарах товч өөр байна.

**4 Арын суудлын энтертейнмент системийг удирдаж ажиллуулна.**




[**Front**] : Урд суудлын аудио системийн удирдлагын дэлгэц гаргана.

[**Left**]/[**Right**] : Удирдах дэлгэц сонгоно.

[ ] : Арын суудлын энтертейнмент системийг асааж унтраана.

[**Дэлгэц**] [**On/Off**] : Арын суудлын дэлгэц асааж унтраана.

[**Advanced**] : Арын суудлын энтертейнмент системийг "Advanced" удирдлагын дэлгэцэнд шилжүүлнэ.

[**Sources**] : Эх үүсвэр сонгоно.

Сонгох гэж буй эх үүсвэр дэлгэц дээр гарахгүй үед [**Other**]-г дарж аудио эх үүсвэр сонгох дэлгэц дээр гаргана.

Улс, бүс нутгаас хамаарч дэлгэцээр гарах эх үүсвэр өөр байна.

[**Display tilt**] *2 : Арын суудлын дэлгэцийн өнцөг тохируулна.

[**Vol**] : Спикерийн дууны түвшинг [**+**] болон [**-**] товчоор тохируулна.

Аудио дуугаралтын горимыг арын суудлуудад өөрөөр тохируулсан үед тус функц нь чихэвч тус бүрийн дууг тохируулна.*3

Аудио (дараах зэрэг [ ], [ ], [ ]) : Аудио эх үүсвэрийг удирдана.

Аудио эх үүсвэрээс хамаарч дэлгэцээр гарах товч өөр байна.

Аудио удирдлагын товчны тухай дэлгэрэнгүйг эх үүсвэр тус бүрийн ажиллагааны гарын авлагаас харна уу.

[ ] : Үндсэн дэлгэцэнд буцна.

## Advanced үйлдлийн дэлгэцнээс арын суудлын энтертейнмент систем удирдах

**1 Арын суудлын энтертейнмент системийн удирдлагын дэлгэцнээс [Advanced]-г сонгоно.**

Арын суудлын энтертейнмент системийн Advanced үйлдлийн дэлгэц гарна.

**2 Арын суудлын энтертейнмент системийг удирдана.**




[**Sources**] : Аудио эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.

[ ] : Арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэц гарна.

[**Audio output**] : Аудио эх үүсвэрийн горим солино.

[ ] : Аудио удирдлагын дэлгэц гаргана.*4

[ ]/[ ]*5 : Курсор түлхүүрийн дэлгэц гаргана.*4

Арын суудлын дэлгэц дээр гарах товч удирдах үед ашиглана.

[ ] : Удирдлагын дэлгэц дээр тоо оруулах гар, эсвэл 12 түлхүүртэй гар гаргана.*4

Контентоос хамаарч тоо оруулах үед ашиглана.

*1 : Тоноглогдсон автомашинд

*2 : Зөвхөн зорчигчийн талаас удирдах боломжтой.

*3 : Аудио дуугаралтын горимыг суудал тус бүрээр тохируулсан үед дэлгэц дээр гарна.

*4 : Сонгосон эх үүсвэрээс хамаарч дэлгэцээр гарах товч өөр байна.

*5 : Арын суудлын энтертейнмент систем ашиглан удирдах боломжтой эх үүсвэрээс хамаарч тэмдэг өөр байна.

## Арын суудлын энтертейнмент систем асааж унтраах

Арын суудлын энтертейнмент системийг урд болон арын суудлаас асааж унтраах боломжтой.

### ● Урд суудлын аудио системээс үйлдэл хийх

1 Аудио эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.

2 [**Rear**]-г сонгоно.

Арын суудлын энтертейнмент системийн удирдлагын дэлгэц гарч ирнэ.

3 [**Power**]-г сонгоно.

4 ON/OFF товч дарна.

### ● Арын суудлын дэлгэцнээс үйлдэх хийх

1 Дэлгэцэн дэх power товч дарна.

Товч дарах бүрт асч унтарна.

### ● Арын олон үйлдэлт удирдлагын самбараас үйлдэл хийх*1

1 Арын олон үйлдэлт удирдлагын самбар дээр арын суудлын энтертейнмент системийн удирдлагын дэлгэц гаргана.

2 [**Left**], эсвэл [**Right**]-г дарж удирдах дэлгэцээ сонгоно.

3 [⏻]-г сонгоно.

Товч дарах бүрт асч унтарна.

### Холбоотой холбоосууд

Аудио эх үүсвэр солих(Х. 37)

*1 : Тоноглогдсон автомашинд

## Арын суудлын энтертейнмент системийн дэлгэц унтрааж зөвхөн аудио дуугаргах

Арын суудлын энтертейнмент системийн дэлгэцийг унтраан зөвхөн аудио ашиглах боломжтой.

**1 Дараах аль нэг үйлдлээр арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын олон үйлдэлт удирдлагын самбарын арын суудлын энтертейнмент системийн "Advanced" удирдлагын дэлгэцнээс [ ]-г сонгоно.

Арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэц гарна.




**2 Дэд цэснээс [Screen off]-г дарна.**

**3 Үндсэн хэсгээс [Screen off]-г дарна.**

Арын суудлын энтертейнмент системийн дэлгэц унтрах ба аудио дуу үргэлжлэн дуугарна.

Дэлгэц асаах үед дараах аль нэг үйлдлийг хийнэ.

- Дэлгэцний дурын хэсэг дээр товшино.
- Арын суудлын дэлгэцний [**SOURCE**]-г дарна.
- Арын олон үйлдэлт удирдлагын самбар дахь арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэцний [ ]-г дарна.

### Арын олон үйлдэлт удирдлагын самбараас арын суудлын дэлгэц унтраах*1




**1 Арын олон үйлдэлт удирдлагын самбар дээр арын суудлын энтертейнмент системийн удирдлагын дэлгэц гаргана.**

**2 [Left], эсвэл [Right]-г дарж удирдах дэлгэц сонгоно.**

**3 [Screen][On/Off]-г сонгоно.**

Аудио дуу гаргангаа арын суудлын энтертейнмент системийн дэлгэц унтарна.

Дэлгэцийг гаргах үед [**Screen**][**On/Off**]-г дахин дарна.

*1 : Тоноглогдсон автомашинд

## Арын суудлын дэлгэцний өнцөг тохируулах

Үзэхэд хүндрэлтэй үед арын суудлын дэлгэцний өнцөг тохируулах боломжтой.

**⚠ АЮУЛТАЙ**

- Дэлгэцийн өнцөг тохируулах үед гараа хавчуулахаас сэргийлнэ. Энэ нь гар гэмтээх, эсвэл дэлгэцэнд доголдол үүсгэх аюултай.
- Хэт халуун хэмд удаан зогсоосон үед дэлгэц халж дэлгэцний өнцөг тохируулах үед түлэх аюултай.*1

**⚠ АНХААР**

Арын суудлын дэлгэцийг гараар хөдөлгөж болохгүй. Арын суудлын дэлгэц гэмтээх аюултай.*2

### ● Тохиргоог гараар хийх*1

1 Дэлгэцийг гараар хөдөлгөж өнцөг тохируулна.

### ● Арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэцнээс тохируулах*2

1 Дараах аль нэг үйлдлээр арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэц гаргана.

- Үндсэн цэсний [⚙]-г сонгоно.
- Арын олон үйлдэлт удирдлагын самбарын арын суудлын энтертейнмент системийн "Advanced" удирдлагын дэлгэцнээс [⚙]-г сонгоно.

Арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэц гарна.

2 [**Display tilt**]-г сонгоно.

Дэлгэцийн өнцөг тохируулах дэлгэц гарч ирнэ.

3 [ ↶ ], эсвэл [ ↷ ]-г даргж дэлгэцийн өнцөг тохируулна.

### ● Арын олон үйлдэлт удирдлагын самбараас тохируулах*2

1 Арын олон үйлдэлт удирдлагын самбар дээр арын суудлын энтертейнмент системийн удирдлагын дэлгэц гаргана.

2 Зорчигчийн суудлын дэлгэц сонгоно.

3 [**Display tilt**]-г сонгоно.

4 [ ], эсвэл [ ]-г сонгож дэлгэцийн өнцөг тохируулна.

## МЭДЭЭЛЭЛ

- Зорчигчийн суудлын дэлгэц ашиглагдаагүй байгаа ба зорчигчийн суудлыг хамгийн урагш тохируулан []-г сонгосон үед *3 урд талын харагдах байдлыг сайжруулах үүднээс арын суудлын дэлгэц хавтгай байрлалд эвхэгдэнэ.

  Анхны байрлалд буцаах үед []-г дахин дарах, эсвэл зорчигчийн суудлыг хамгийн урагш байрлалаас *3 буцаана.

*1 : 7 суудалтай загвар, эсвэл 4 суудалтай загварын зөвхөн жолооч тал

*2 : 4 суудалтай загварын зөвхөн зорчигчийн тал

*3 : Суудлын байрлал тохируулах тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

## Арын суудлын энтертейнмент системд HDMI төхөөрөмж холбох (7 суудалтай)

Арын суудлын энтертейнмент системд HDMI дэмждэг төхөөрөмж холбоно.

1 **Урд голын хайрцагны ард талын таг нээнэ.**



2 **HDMI портод HDMI холбогч залгана.**



### МЭДЭЭЛЭЛ

Холбогдсон төхөөрөмжтэй хамт нийлүүлэгдсэн батерей зэрэг цахилгааны эх үүсвэр ашиглана. Автомашины цахилгааны залгуур ашигласан нөхцөлд шуугиан үүсч болно.

(Цахилгааны залгуурын тухай дэлгэрэнгүй мэдээллийг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

### Холбоотой холбоосууд

Арын суудлын энтертейнмент системээр арын суудлын HDMI медиа тоглуулах(Х. 251)

## Арын суудлын энтертейнмент системд HDMI төхөөрөмж холбох (4 суудалтай)

HDMI гаралт дэмждэг төхөөрөмж арын суудлын энтертейнмент системд холбоно.

**1 Арын туслах хайрцагны тагийг нээнэ.**



**2 HDMI портод HDMI холбогч хийнэ.**



### МЭДЭЭЛЭЛ

Холбогдсон төхөөрөмжинд дагалдах батерей зэрэг цахилгааны эх үүсвэр ашиглана. Автомашины цахилгааны залгуур ашиглах нь шуугион үүсгэж болно.

(Цахилгааны залгуурын тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

### Холбоотой холбоосууд

Арын суудлын энтертейнмент системээр арын суудлын HDMI медиа тоглуулах(Х. 251)

## Арын суудлын энтертейнмент системийн эх үүсвэр солих

Радио, USB зэрэг арын суудлаас үзэх, сонсох эх үүсвэр сонгоно.

**1 Дараах аль нэг үйлдлээр эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын суудлын дэлгэцний [**SOURCE**]-г дарна.

Эх үүсвэрийн дэлгэц гарна.

**2 Эх үүсвэр сонгоно.**

Сонгосон эх үүсвэрийн дэлгэц гарна.

Тухайн улс, бүс нутгаас хамаар дэлгэцээр гарах эх үүсвэр өөр байна.




### МЭДЭЭЛЭЛ

- Wi-Fi® холболт болон Bluetooth® нь 2.4 GHz-н радио давтамж ашиглан холболт үүсгэдэг. Ашиглалтын нөхцлөөс хамаарч радио долгионы нөлөөлөл үүсэх, улмаар дүрс хэлбэрээ алдах, аудио дуугаралтад царгиа үүсч болно.
- Арын баруун болон зүүн дэлгэц дээр нэг эх үүсвэр сонгосон үед түр зогсоох, хурдан гүйлгэх зэрэг үйлдлүүд баруун зүүн дэлгэцэнд зэрэг хийгдэнэ.

## Арын суудлын энтертейнмент системийн эх үүсвэрийн тэмдэгний байрлал солих

Үйлдлийг хялбар болгох үүднээс эх үүсвэрийн тэмдэгний байрлал солих боломжтой.

**1 Үндсэн цэсний [ ]-г сонгоно.**

Эх үүсвэр сонгох дэлгэц гарна.

**2 [Reorder]-г сонгоно.**

**3 Байрлал өөрчлөх тэмдгийг товшоод чирэн байрлал солиод суллана.**

Эх үүсвэр сонгох дэлгэц олон хуудастай үед тэмдгийг өмнөх болон дараах хуудсан шилжүүлэх үед [ ]/[ ]-г дэлгэцний захад байрлуулна.

**4 Байрлал солиж дууссан үед [OK]-г дарна.**

Дэлгэц эх үүсвэр сонгох дэлгэцэнд буцна.

## Арын олон үйлдэлт удирдлагын самбар дахь эх үүсвэрийн тэмдэгний байрлал өөрчлөх*1

1 **Арын суудлын дэлгэцний үндсэн цэснээс [ ]-г сонгоно.**

Эх үүсвэр сонгох дэлгэц гарна.

2 **Курсор түлхүүр ашиглан [Reorder]-г сонгоно.**

3 **Байрлал өөрчлөх эх үүсвэрийн тэмдэг сонгоно.**

4 **Курсор түлхүүр ашиглан тэмдгийг зөөнө.**

5 **[Enter]-г сонгоно.**

6 **Байрлал солиж дууссан үед [OK]-г дарна.**

Дэлгэц эх үүсвэр сонгох дэлгэцэнд буцна.

*1 : Тоноглогдсон автомашинд

## Арын суудлын энтертейнмент системийн дууны түвшин тохируулах

Арын суудлын энтертейнмент системийн дууны түвшин тохируулах үед аудио дуугаралтын горимыг үл хамаарах горимд шилжүүлнэ. Холбоотой горим сонгогдсон үед дууны түвшин өөрчилсөн нөхцөлд бүх спикерийн дуу өөрчлөгдөнө.

**⚠ АНХААР**

Аюулгүй жолоодлогод саад учруулахгүй тохиромжтой түвшинд тохируулна.

- **Дараах аль нэг үйлдлээр дууны түвшин тохируулна.**
  - [**+**], эсвэл [**-**] товчийг арын суудлын дэлгэцний [**VOL**]-с дарна.
  - [**+**], эсвэл [**-**]-г арын олон үйлдэлт удирдлагын самбарны [ ][*1]-с дарж тохируулна.

**⚠ АЮУЛТАЙ**

- Эх сурвалж солихдоо дууны түвшинг анхаарна уу. Ялангуяа видео контент дээр илүү хүчтэй дууны эффект гаргах үүднээс зарим хэвийн харилцан яриаг сул дуутай бичдэг. Эдгээр харилцан ярианы үед дууны түвшинг тохируулсан нөхцөлд дууны эффекттэй хэсэгт шилжих, эсвэл өөр эх үүсвэрт шилжүүлэх үед хэт чанга дуу гарч болно.
- Чихэвч ашиглах үедээ чихэвчээ холбон дууны түвшинг тохируулна. Дууны түвшинг хэт чанга тохируулах нь сонсголд сөрөг нөлөөтэй.

### Холбоотой холбоосууд

Чихэвч ашиглах (7 суудалтай загвар)(Х. 58)

Чихэвч ашиглах (4 суудалтай)(Х. 59)

*1 : Аудио дуугаралтыг холбоотой горимд шилжүүлсэн үед дэлгэц дээр [**Vol**] гарна.

## Арын суудлын энтертейнмент системийн аудио гаралт солих

Арын суудлын энтертейнмент систем нь 2 аудио гаралтын горимтой: урд суудлын аудио системтэй адил эх үүсвэр ашиглах холбоотой горим болон өөр эх үүсвэр ашиглах тусдаа горимтой.

**Холбоотой (linked) горим**

Урд суудлын аудио системээс аудиог удирдах боломж бүрдүүлнэ.

Аудио дуугаралт спикерээс гарна.

**Тусдаа (Independent) горим**

Урд суудлын аудио системээс өөр эх үүсвэр ашиглах боломж бүрдүүлнэ.

Жишээлбэл урд суудлын аудио системээр радио сонгосон үед арын суудлын зорчигч Bluetooth® аудио сонсох боломжтой.

Арын суудлын энтертейнмент системийн аудио чихэвчээр дуугарна.

### МЭДЭЭЛЭЛ

Урд болон арын суудалд нэг эх үүсвэр сонгосон үед түр зогсоох, хурдан гүйлгэх зэрэг аудио үйлдлийг урд болон арын суудлаас хийх боломжтой.

**1 Дэлгэцийн дээд хэсгээс [Audio:], [Synchronise], эсвэл [Separate]-н аль нэгийг сонгоно.**

Дэлгэцээр [**Audio:**] гараагүй үед [ ]-г сонгож гаргана.

**2 [Separate], эсвэл [Synchronise]-г сонгоно.**




### Холбоотой холбоосууд

Арын суудлын энтертейнмент системийн эх үүсвэр солих(Х. 54)
Чихэвч ашиглах (7 суудалтай загвар)(Х. 58)
Чихэвч ашиглах (4 суудалтай)(Х. 59)

## Чихэвч ашиглах (7 суудалтай загвар)

Энгийн чихэвч ашиглан арын суудлаас аудио сонсох.

Урд суудлаас өөр эх үүсвэр сонгосон үед арын суудлын аудиог зөвхөн чихэвчээр сонсох боломжтой.

Чихэвчний залгуурт чихэвч залган ашиглана.

**⚠ АЮУЛТАЙ**

Чихэвч ашиглах үед чихэвчний дууны түвшинг тохируулна.
Дууны түвшинг хэт өндөр тохируулсан үед сонсгол гэмтээх аюултай.

**1 Урд голын хайрцагны ард талын хайрцагны таг нээнэ.**



**2 Чихэвчийг чихэвчний залгуурт хийнэ.**



### Холбоотой холбоосууд

Арын суудлын энтертейнмент системийн дууны түвшин тохируулах(Х. 56)

Арын суудлын энтертейнмент системийн аудио гаралт солих(Х. 57)

Чихэвч ашиглах (4 суудалтай)(Х. 59)

## Чихэвч ашиглах (4 суудалтай)

Энгийн чихэвч ашиглан арын суудлаас аудио сонсох.

Урд суудлаас өөр эх үүсвэр сонгосон үед арын суудлын аудиог зөвхөн чихэвчээр сонсох боломжтой.

Чихэвчний залгуурт чихэвч залган ашиглана.

**⚠ АЮУЛТАЙ**

Чихэвч ашиглах үед чихэвчний дууны түвшинг тохируулна.

Дууны түвшинг хэт өндөр тохируулсан үед сонсгол гэмтээх аюултай.

**1 Арын голын хайрцагны таг нээнэ.**



**2 Чихэвчийг чихэвчний залгуурт хийнэ.**



### Холбоотой холбоосууд

Арын суудлын энтертейнмент системийн дууны түвшин тохируулах(Х. 56)

Арын суудлын энтертейнмент системийн аудио гаралт солих(Х. 57)

Чихэвч ашиглах (7 суудалтай загвар)(Х. 58)

## Урд суудлын аудио системээс арын суудлын энтертейнмент систем удирдах

1 **Урд суудлын аудио систем дээр аудио эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.**

2 **[Rear]-г сонгоно.**

Арын суудлын энтертейнмент системийн удирдлагын дэлгэц гарна.

3 


**Арын суудлын энтертейнмент системийг удирдана.**

[**Power**] : Арын суудлын энтертейнмент системийг асааж унтраана.

[**Rear system lock**] : Арын суудлаас удирдах болон удирдахгүй тохиргоонд хийнэ.

[**Separate**] : Аудио гаралтыг хувийн горимд тохируулна.

[**Synchronise**] : Аудио дуугаралтыг "linked" горимд шилжүүлнэ.

Зүүн болон баруун суудалтай холбох үед [**Left**], эсвэл [**Right**]-г сонгоно.

### Холбоотой холбоосууд

Аудио эх үүсвэр солих(Х. 37)

## Системийг дуу хоолойн удирдлагын системээр удирдах

Навигаци, аудио, гарны оролцоогүй дуудлага зэрэг олон функцийг дуу хоолойн командаар удирдах боломжтой. Lexus Connect*1-г ашиглаж байгаа үед үүлэн санах ойноос контент ашиглан мэдээлэл хайх боломжтой.




A Дуу хоолой таних статусыг харуулна.

[]/[] : Ярихыг хүлээнэ

[] : Сонсож байгаа

[] : Танисан дуу хоолойг боловсруулж байгаа

B Системийн хариу үйлдэл болон танисан үр дүнг текстээр харуулна.

C Дэлгэц дээр гар гаргана.

Гар ашиглан олон төрлийн мэдээлэл хайх боломж бүрдүүлнэ.

D Дуут командын жишээг жагсаалтаар харуулна.

Тухайн үйлдлээр нь олон ашиглагддаг командын жишээг харах боломжтой.

E Дуу хоолой таних дэлгэц хаана.

### МЭДЭЭЛЭЛ

- Lexus Connect*1-н холболтын статусыг дэлгэцээр харуулж болно.

  [**No online service**] : Хамрагдсан үйлчилгээ байхгүйг илэрхийлнэ.

  [**No internet connection**] : Интернетэд холбогдоогүйг илтгэнэ.
- Жолоодлогын үед дуу хоолой таних дэлгэц урт нарийн байдлаар гарна.

**Холбоотой холбоосууд**

Дэлгэцний гар ашиглан мэдээлэл хайх(Х. 69)

## Микрофон

Жолооч болон зорчигчийн талд тус бүр микрофон суурилагдсан байдаг.



### МЭДЭЭЛЭЛ

- Дуу хоолойн удирдлагын системийг сэрээх үгээр идэвхжүүлсэн жолооч, эсвэл зорчигчийн суудлаас дуут команд өгч болно. Энэ нөхцөлд системийг идэвхжүүлсэн суудлаас бусад суудлын дуут командыг танихгүй.
- Нөгөөтэйгүүр зарим функцийг зорчигчийн суудлаас дуут команд өгч удирдах боломжгүй.

## Дэмждэг хэл

Тус функц нь дараах хэл дэмждэг:

### ■ Номхон далайн орнууд

Англи

### ■ Зүүн Өмнөд Ази

Англи, Тайланд, Индонези

### ■ Ойрхи Дорнод

Англи, Араб

### ■ Өмнөд болон Төв Америк

Англи, Испани, Бразилийн Португал

### ■ ӨАБНУ

Англи, Франц

### ■ Энэтхэг

Англи

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

## Дуу хоолойн удирдлага эхлүүлэх

Дараах аль нэг үйлдлээр дуу хоолойн удирдлага эхлүүлэх боломжтой:

### ■ Дуудлага хийх, яриаг дуусгах товч дарах

Жолооны хүрдний [ ] товч дарна.



### ■ Сэрээх үг хэлэх

"Hey Lexus" гэж хэлнэ.

- Тохиргооны дэлгэцнээс сэрээх үгийг өөрчлөх боломжтой.
- Сэрээх үгийг хэлсэн даруйдаа дуу хоолойн команд өгөх боломжтой.

  Жишээ: "Hey Lexus""Go to nearby coffee shop"



### ■ Микрофоны товч дарах

Дэлгэцний [ ]-г дарна.



### МЭДЭЭЛЭЛ

- Дуу хоолойн удирдлагын системийг сэрээх үгээр сэрээж жолооч, зорчигчийн суудлаас дуу хоолойн үйлдэл хийх боломжтой. Энэ нөхцөлд систем идэвхжүүлсэн суудлаас бусад суудлаас өгсөн командыг систем танихгүй.

- Жолооны хүрдний [ ] товч, эсвэл микрофоны товчоор дуу хоолойн системийг идэвхжүүлсэн үед зорчигчийн суудлаас дуу хоолойн команд өгөх боломжгүй.
- Тод хэлээгүй үед систем дуу хоолойн командыг танихгүй байж болно. Систем ашиглах үед дараах зүйлсэд анхаарна:
  - Тод дуугаар ярина.
  - Шуугианаас (салхины болон гадна дуу чимээ) шалтгаалж командыг зөв танихгүй байж болох тул цонх хаана.
  - Агааржуулалтын систем хүчтэй ажиллаж байгаа үед команд зөв танигдахгүй байж болох тул агаарын хэмжээг бууруулна.
  - Команд өгөх аудио системийн дуу чанга тоглож байгаа үед команд зөв танигдахгүй байж болох тул дууны түвшинг бууруулна.
  - Нэгэн зэрэг олон хүн яриж байгаа үед команд зөв танигдахгүй байж болно.
- Дуут зөвлөгөө систем өгөх үед дуу хоолойн командаар цуцлах боломжтой.
- Тохиргооны дэлгэцнээс дуут зөвлөмжийг асаах болон унтраах боломжтой.
- Тохиргооны дэлгэцнээс системийн дууны түвшинг тохируулах боломжтой.

### Холбоотой холбоосууд

Дуу хоолойн удирдлагын систем асаах сэрээх үг солих(Х. 91)

Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх(Х. 91)

## Дуу хоолойн удирдлага цуцлах

Дараах аль нэг үйлдлээр дуут команд дуусгана:

- **"Cancel" гэж хэлнэ.**
- **Дуу хоолой таних дэлгэцний [ ]-г дарна.**
- **Жолооны хүрдний [ ] товчийг удаан дарна.**

## Дуу хоолойн команд хэлэх

Дуу хоолойн командын дэлгэц гарсан үед команд хэлнэ. Систем энгийнээр ярих үед танидаг.*1



### МЭДЭЭЛЭЛ

- Аялгатай хэлсэн, эсвэл стандарт бус хэллэгээр хүлсэн дуут командыг танихгүй байж болно.
- Дуу хоолойн удирдлагын систем нь газрын нэр, байгууламжийг хайхдаа нэр, товчлолыг танихгүй бол албан ёсны нэрийг хэлнэ.
- Хийхийг хүссэн зүйлээ оруулан ярих нь дуут хоолойн удирдлагын системд таны командыг танихад хялбар болгоно. Жишээлбэл очих газар хайх үед зөвхөн газрын нэр хэлж болохгүй. Үүний оронд "Go to nearby coffee shop" зэргээр үйл үг оруулан хэлнэ.

## Ажиллагааны жагсаалт

Дуу хоолойн командын жишээ болон дуут командаар ажиллуулах боломжтой ажиллагааг харуулав.

Автомашин болон системээс хамаарч ашиглах боломжтой ажиллагаа өөр байж болно.

### ■ Нийтлэг командууд

| Үйлдэл | Дуут командын жишээ |
|---|---|
| Эхнээс нь эхлэх | "Start Over" |
| Дуут команд цуцлах | "Cancel" |
| Дуут командын санаа өгөх | "Help" |
| Өмнөх дэлгэц рүү буцах | "Go Back" |
| Жагсаалтын тоо сонгох | "Number one" |
| Жагсаалтын хуудас солих | "Next Page" "Previous Page" |

*1 : Тоноглогдсон автомашинд

## Очих газрын хайлт*2

Нэр, төрөл, байгууламжийн хаягаар очих газрыг тохируулах боломжтой.

| Үйлдэл | Дуут командын жишээ |
|---|---|
| Байгууламж хайх | "Find a <POI category/POI name>" "Go to nearby coffee shop" |
| Хаяг хайх | "Get directions to <address>" |
| Гэр лүүгээ харих | "Take me Home" |

## Навигацийн ажиллагаа*2

Газрын зураг ашиглах, мөн очих газрыг устгах боломжтой.

| Үйлдэл | Дуут командын жишээ |
|---|---|
| Газрын зургийн төрөл солих | "Change Map to 3D" |
| Газрын зургийн масштаб солих | "Zooming in" "Zooming out" |
| Газрын зургийн дэлгэц гаргах | "Show map" |
| Маршрутын мэдээлэл шалгах | "What's my ETA?" |
| Очих газрыг устгах | "Delete destination" |
| Очих газрын түүх харуулах | "Show Recent Destinations" |

## Аудио ажиллагаа

Радио, USB санах ой, Bluetooth® аудио зэрэг аудио ажиллагааг удирдах боломжтой.

Медиад хадгалагдсан дуучин, цомог, дууны нэрийг заах боломжтой.

Радио станцийн нэрнээс мөн заах боломжтой.

| Үйлдэл | Дуут командын жишээ |
|---|---|
| Дууны түвшин тохируулах | "Volume up" "Volume down" |
| Дуу хаах | "Mute audio" |
| Дараагийн/өмнөх дууг тоглуулах | "Next Song" "Previous Song" |
| Тоглуулах дууг заах*3 | "Play <Artist>" "Play <Album>" "Play <Song>" |
| Радио станц сонгох | "Tune to <fm frequency>" "Tune to <fm station name>" |
| Аудио эх үүсвэр солих | "Change to <audio source>" |

## ■ Гарны оролцоогүй утасны ажиллагаа*4

Автомашинд холбогдсон Bluetooth® гар утсаар дуудлага хийх боломжтой.

Холбоо барих хаягт бүртгэгдсэн нэр, утасны төрлийг зааж утасны дугаар луу залгах боломжтой.

| Үйлдэл | Дуут командын жишээ |
|---|---|
| Хаягийн жагсаалтад байгаа дугаар луу дуудлага хийх | "Call <contacts>" |
| Утасны дугаар луу дуудлага хийх | "Call <phone number>" |
| Дуудлагын түүх харуулах | "Show recent calls" |
| Мессеж илгээх*2*6 | "Send Message to <contact name>" |
| Мессежийг дуудаж унших *2 | "Read message" |
| Bluetooth® холболтын дэлгэц гаргах | "Show Bluetooth Settings" |

## ■ Мэдээлэл хайх үйлчилгээ*2*5

Онлайн үйлчилгээ ашиглан мэдээлэл хайх боломжтой.

| Үйлдэл | Дуут командын жишээ |
|---|---|
| Цаг агаарын мэдээлэл шалгах | "Tell me the weather today" |

## ■ Цаг агаарын удирдлага

Агааржуулалтын системийн хэм, сэнсний хурдыг удирдах боломжтой.

| Үйлдэл | Дуут командын жишээ |
|---|---|
| Агааржуулалтын систем асаах, унтраах | "Turn on the air conditioner" "Turn off the air conditioner" |
| Агааржуулалтын системийн хэм тохируулах | "Turn up the temperature" "Turn down the temperature" "Set the temperate to 25 degrees" |
| Агааржуулалтын системийн сэнсний хурд тохируулах | "Turn the fan speed up" "Turn the fan speed down" "Set the fan speed to 3" |

## ■ Автомашины төхөөрөмжийн ажиллагаа*2*5

Цонх нээх хаах зэрэг автомашины функцийг удирдах боломжтой.

| Үйлдэл | Дуут командын жишээ |
|---|---|
| Цонх нээх ба хаах*4 | "Open all windows" "Close all windows" "Open driver side window" "Close driver side window" |
| Дээврийн нээлхий нээх, хаах*2 | "Open moon roof" "Close moon roof" |
| Салхины шил арчигч нэг удаа ажиллуулах*4 | "Turn on the front wiper" |
| Байрлал санах тохиргоог дахин дуудах/бүртгэх*2*4 | "Set seat position number 1" "Save seat position number 1" |
| Гэрэлтүүлгийн өнгө өөрчлөх*2 | "Set the illumination to red" |

## ■ Автомашины мэдээлэл

Шатахуун зарцуулалт, туулах боломжтой зай зэрэг автомашины мэдээлэл шалгах боломжтой.

| Үйлдэл | Дуут командын жишээ |
|---|---|
| Шатахууны хэмнэлт шалгах | "What's my fuel consumption?" |
| Туулах боломжтой зайг шалгах | "What's my cruising range?" |
| Дундаж хурд шалгах | "What's my average speed?" |

## ■ Дэлгэцээр гарсан мэдэгдэлд дуу хоолойгоор хариу үйлдэл хийх

Дуудлага ирэх, бусад мэдэгдэлд дуу хоолойгоор хариу үйлдэл хийх боломжтой. Дуу хоолойгоор хариу үйлдэл үзүүлэх тохиргоог дуу хоолойн тохиргооны дэлгэц дээр өөрчлөх боломжтой.

## Холбоотой холбоосууд

Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх(Х. 91)

*2 : Тоноглогдсон автомашинд

*3 : USB-р холбогдсон төхөөрөмжинд хадгалсан дууг тоглуулах боломжтой.

*4 : Зорчигчийн суудлаас дуут команд өгөх боломжгүй.

*5 : Lexus Connect-н үйлчилгээнд хамрагдсан байх шаардлагатай.

*6 : Шинэ мессежний функцийг зөвхөн SMS-д ашиглах боломжтой.
Мессежинд хариу бичих функц SMS болон MMS-д ашиглах боломжтой.

## Дэлгэцний гар ашиглан мэдээлэл хайх

Дэлгэцний гар ашиглан мэдээлэл хайх боломжтой.

**1 [ ]-г дарна.**

Хайлтын түүх байгаа үед хайлтын дэлгэц гарч хайлтын түүхээс хайх боломж бүрдүүлдэг.



**2 Хайх категорио сонгоно.**




[**Navigation**] : Хаяг, байгууламжийн нэр, утасны дугаар, бүс, замын нэр, уулзвар зэргийг оруулна.

[**Audio**] : Цомог, дуучин, дууны нэр, тоглуулах жагсаалт, төрөл, радио станц зэргийг оруулна.

[**Phone**] : Нэр, утасны дугаар, эсвэл утасны хаягт бүртгэсэн бусад мэдээллийг оруулна.

[**Vehicle**] : Шатахууны зарцуулалт, эсвэл автомашины дэлгэцээр гаргах бусад мэдээллийг оруулна.

[**Settings**] : Аудио, утас, агааржуулалтын систем зэрэг өөрчлөх тохиргоог оруулна.

**3 Хайлтын түлхүүр үг оруулаад [Go]-г дарна.**




**4 Хайлтын үр дүнгийн жагсаалт гарсан үед хүссэн үр дүнг дарж сонгоно.**

### МЭДЭЭЛЭЛ

- Автомашин явж байгаа үед дэлгэц удирдах ажиллагаа хязгаарлагддаг.

- Apple CarPlay/Android Auto-д холбогдсон үед хайлт хийх боломжгүй.

# 2 Тохиргоо ба бүртгэл


**2-1. Мултимедиа системийн анхны тохиргоо**

Жолооч бүртгэх .................. 73

**2-2. Олон төрлийн тохиргоо**

Олон төрлийн тохиргоог өөрчлөх .............................. 78

**2-3. Жолоочийн тохиргоо**

Жолооч бүртгэх, бүртгэл өөрчлөх ............................. 80

Жолооч таних тохиргоо хийх.................................... 83

**2-4. Ерөнхий тохиргоо**

Мултимедиа системийн ерөнхий тохиргоог өөрчлөх .............................. 86

**2-5. Дэлгэцийн тохиргоо**

Дэлгэцийн тохиргоог өөрчлөх .............................. 89

**2-6. Дуу хоолойн удирдлагын тохиргоо**

Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх ............ 91

**2-7. Автомашины тохиргоо**

Дилерийн мэдээлэл тохируулах ........................ 93

Аюулгүй байдлын тохиргоо өөрчлөх ............ 94

Программ хангамжийн мэдээлэл шалгах, шинэчлэх ........................... 98

**2-8. Навигацийн тохиргоо**

Навигацийн системийн тохиргоо........................... 101

Газрын зургийн дэлгэцийн тохиргоо өөрчлөх............................ 102

Маршрутын зааварчилгаа .................. 104

Зааварчилгааны тохиргоо........................... 107

Бусад тохиргоо.................. 109

**2-9. Дуу болон медиа тохиргоо**

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх .......... 115

Дэлгэцийн горим солих .. 118

Дүрсний чанар тохируулах ...................... 119

Эх үүсвэр тус бүрийн дууны түвшин тохируулах ...................... 120

**2-10. Wi-Fi® тохиргоо**

Wi-Fi® тохиргоо өөрчлөх.. 121

**2-11. Bluetooth® тохиргоо**

Bluetooth® төхөөрөмж тохируулах....................... 123

**2-12. Арын суудлын энтертейнмент системийн тохиргоо**

Арын суудлын энтертейнмент системийн дэлгэцийн тохиргоо өөрчлөх ........... 127

Арын суудлын энтертейнмент системээр гаргаж буй видео болон зургийн дүрсний чанар тохируулах....................... 128

Арын суудлын
энтертейнмент
системийн дэлгэцийн
горим солих...................... 129

Арын суудлын
энтертейнмент систем
дээр арын суудлын
HDMI тохиргоо өөрчлөх 130

Арын суудлын
энтертейнмент
системийн лицензийн
мэдээлэл шалгах ............. 132

## Жолооч бүртгэх

Мултимедиа системийн анхны тохиргоо болгон үндсэн хэрэглэгчийн хэрэглэгчийн профайл бүртгэнэ.

Хэрэглэгчийн профайлыг бүртгэснээр жолоодлогын байрлал, мултимедиа болон бусад тохиргоог жолооч бүрийн профайл болгон хадгалах боломжтой. Таны найз нөхөд, гэр бүлийнхэн зэрэг олон жолооч автомашин жолоодсон үед та бусад жолоочийн тохиргоог өөрчлөлгүйгээр жолоодох боломжтой.

Хэрэглэгчийн профайл ашиглахгүй үед зочны горимоор жолоодож болно.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

### Миний тохиргоо

Жолоодлогын байрлал, мултимедиа тохиргоо болон автомашины бусад тохиргоог жолооч тус бүр дээр сануулж жолоодлого хийх үед дуудах боломжтой.

- 3 хүртэлх миний тохиргоог сануулах боломжтой.
- Дараах тохиргооны мэдээллийг миний тохиргоонд сануулах боломжтой:
    - Зарим мултимедиа тохиргоо : Дууны түвшин, навигаци, аудио
    - Автомашины зарим тохиргоо : Жолоодлогын байрлал, хянах самбар зэрэг
- Өөрчлөлт хийгдсэн үед автомашины тохиргоонууд автоматаар тухайн хэрэглэгчийн профайлд хадгалагдана.
- Хайлтын түүх, хувийн тохиргоо болон бусад хувийн мэдээллийг миний тохиргоонд тохируулан хамгаалах боломжтой.
- Жолооч таних төхөөрөмж бүртгэсэн үед автомашинд суухад тухайн жолоочийн миний тохиргоо автоматаар дуудагдана. Ухаалаг утас, ухаалаг түлхүүр болон хурууны хээгээр жолооч бүртгэх боломжтой.

■ **"Lexus Connected App" аккаунттай холбох*1**

- Миний тохиргоог ашиглах үед идэвхтэй "Lexus Connected App"-н аккаунт шаардлагатай.
- Та өөрийн "Lexus Connected App" аккаунтаа "Lexus Connected App"-тай холбосон үед LEXUS Connect сервисийн эрхтэй адил загварын мултимедиа системтэй автомашин жолоодох үедээ "Lexus Connected App Profile"-с өөрийн миний тохиргоог татаж ашиглах боломжтой.

- Бүртгэгдсэн миний тохиргоог "Lexus Connected App" дээр шалгах, засварлах боломжтой.
- Эзэмшигчээр бүртгэгдсэн жолооч бүх жолоочийн бүртгэлийг устгах боломжтой. Эзэмшигчээр бүртгэгдээгүй жолооч эзэмшигчийн миний тохиргоог устгах боломжгүй.
- Нэг автомашин дээр адилхан миний тохиргоог зэрэг ашиглах боломжгүй.
- Автомашины тохиргоо өөрчлөгдөх үед профайл автоматаар шинэчлэгдэх ба дэлгэц дээр шинэчлэлтийг жолоочид мэдээллэх мэдэгдэл гарна.
- Бүртгэгдсэн профайл үүлэн хадгалах санд хадгалагддаг тул автомашин дээр профайл устгасан ч үүлэн хадгалах санд үлдэнэ.

### Холбоотой холбоосууд

Жолооч таних тохиргоо хийх(Х. 83)

## Жолоочийн тохиргоог анхны удаа хийх (А төрөл)

Жолоочийн тохиргоо ашиглах үед идэвхтэй "Lexus Connected App"-н аккаунт шаардлагатай.

**1 Автомашин ассаны дараах эхний дэлгэц дээр [OK]-г дарна.**




**2 [Yes]-г дарна.**

- Жолооч бүртгэхгүй үед [**No**]-г дарна.

**3 Ухаалаг утасны "Lexus Connected App" аппликейшн ашиглан профайл бүртгэх үед [Through Lexus app]-г дарна.**

- Өөрийн аккаунт болон нууц үг ашиглан жолооч бүртгэх үед [**Enter account & password**]-г дарна.

**4 [Next]-г дарна.**

- Хэрэв таньд "Lexus Connected App" аппликейшн байхгүй үед дэлгэцний QR код ашиглан татна.

**5 Ухаалаг утасны "Lexus Connected App" аппликейшн нээж дэлгэцийн зааварчилгааг дагах ба QR код уншуулах, эсвэл**

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

**[Link acc. via verification code]-г дарж баталгаажуулах код оруулан жолооч бүртгэнэ.**

Бүртгэл дууссан үед мессеж дэлгэц дээр гарах ба миний тохиргоо хадгалагдана.

6 **Миний тохиргоо бүртгэсний дараа жолооч таниулах төхөөрөмж бүртгэнэ. Тохиргоог үргэлжлүүлэх үед [Continue]-г дарна.**

Төхөөрөмжийн мөн дараа бүртгэх боломжтой.

7 **Жолоочийн тохиргооны дэлгэц дээр төхөөрөмж бүртгэнэ. Жолооч таних төхөөрөмж бүртгэсэн үед миний тохиргоо автоматаар дуудагдана.**

- Ухаалаг утас, ухаалаг түлхүүр зэрэг дурын төхөөрөмжийг миний тохиргоонд бүртгэх боломжтой.
- Миний тохиргоонд олон төхөөрөмж бүртгэх боломжтой.

### МЭДЭЭЛЭЛ

Миний тохиргооны бүртгэл хийгээгүй үед жолоочийн тохиргооны дэлгэцнээс дахин эхлүүлэх боломжтой.

## Хэрэглэгчийн профайл анх удаа бүртгэх (B төрөл)

1 **Автомашин асаасны дараа хэл сонгох дэлгэц гарна. Хэлний сонголт хийнэ.**

Жолооч бүртгэх үеийн дэлгэцийн хэл сонгоно. Бүртгэл дууссаны дараа хэл үндсэн хэлэнд буцна.

Тус дэлгэц зарим улс, бүс нутагт гарахгүй байж болно.

2 **[Create]-г дарж жолооч бүртгэнэ.**

Жолооч бүртгэхгүй үед [**Don't create now**]-г дарна. Бүртгэлийн дэлгэц дахин гаргахгүй үед [**Do not show setup again**]-г дарна.

3 **Жолоочийн нэр оруулна.**

4 **Пин код тохируулна.**

- Пин код нь жолоочийн хувийн мэдээллийг хамгаалах зорилготой.
- Пин кодгүйгээр жолоочийн бүртгэл хийх үед [**Skip**]-г дарна.




5 **Пин код дахин оруулна.**

Бүртгэл дууссан үед мессеж гарч миний тохиргоо хадгалагдана.

**6 Жолооч бүртгэсний дараа жолооч таних төхөөрөмж бүртгэнэ. Тохиргоог үргэлжлүүлэх үед [Continue]-г дарна.**

Төхөөрөмж дараа бүртгэх боломжтой.

**7 Жолоочийн тохиргооны дэлгэцнээс төхөөрөмж бүртгэх боломжтой. Жолооч таних төхөөрөмж бүртгэн миний тохиргоог автоматаар дуудах боломжтой.**

- Ухаалаг утас, ухаалаг түлхүүр зэрэг төхөөрөмж миний тохиргоонд бүртгэх боломжтой.
- Миний тохиргоонд олон төхөөрөмж бүртгэх боломжтой.

### Холбоотой холбоосууд

Жолооч таних тохиргоо хийх(Х. 83)

## Миний тохиргоог автоматаар дуудах

Жолооч таних тохиргоонд тохируулсан ухаалаг утас, ухаалаг түлхүүр, бусад төхөөрөмжийг автомашинд авч орох үед холбогдох миний тохиргоо автоматаар дуудагдана.

- Асаах товчийг ACC, эсвэл ON горимд шилжүүлэх үед автомашин миний тохиргоонд бүртгэгдсэн жолооч таних төхөөрөмжийг танина. Төхөөрөмж танигдсан үед тухайн төхөөрөмжинд сануулсан миний тохиргоо автоматаар дуудагдана.
- Миний тохиргоонд бүртгэгдсэн төхөөрөмж танигдаагүй үед автомашин зочин жолоочийн горимд шилжинэ.
- [**Settings**] дээр дарж жолоочийн тохиргооны дэлгэц гарган миний тохиргоог өөрчлөх боломжтой.
- Жолооч таних төхөөрөмжөөр ухаалаг утас, ухаалаг түлхүүр, бусад төхөөрөмж бүртгэх боломжтой.

### МЭДЭЭЛЭЛ

- Миний тохиргоонд бүртгэгдсэн олон төхөөрөмж танигдсан үед эхэлж танигдсан төхөрөөмжийн тохиргоо дуудагдана. Үүний дараа илүү олон давтамжтай ашиглагддаг зэрэг давуу эрхтэй төхөөрөмж холбогдсон үед миний тохиргоо өөрчлөгдөнө.
- Миний тохиргоонд бүртэгдсэн төхөөрөмж дундаас хамгийн сүүлд ашигласан жолоочийн Bluetooth® төхөөрөмжийг зөвхөн танина.

### Холбоотой холбоосууд

Жолооч бүртгэх, бүртгэл өөрчлөх (Х. 80)

Жолооч таних тохиргоо хийх(Х. 83)

## Миний тохиргоо өөрчлөх

Автомашинд бүртгэгдсэн миний тохиргооны жагсаалтаас тухайн ашиглах миний тохиргоог сонгох боломжтой.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 "Saved profiles"-с өөрчлөх гэж буй хэрэглэгчийн профайл нэрийг сонгоно.**




**3 Пин код, эсвэл нууц үг оруулна.**

- Жолоочийн тохиргооны дэлгэц дээр [**Profile lock by password**]-г идэвхжүүлсэн үед нууц үг асууна.
- "Lexus Connected App" аккаунт үүсгэх үед тохируулсан нууц үгээ "Lexus Connected App" ухаалаг утасны аппликейшн дээр оруулна.
- Миний тохиргоог тохируулах үеийн пин кодоо оруулна.
- Миний тохиргоо өөрчлөгдсөн үед дэлгэц дээр мессеж гарна.

### МЭДЭЭЛЭЛ

Тус төхөөрөмж өөр миний тохиргоонд бүртгэгдсэн үед мултимедиа системийн дэлгэц дээр мессеж гарна.[ ]-г дарж миний тохиргооны өөрчлөлтийг идэвхжүүлнэ.

## Олон төрлийн тохиргоог өөрчлөх

Мултимедиа системтэй холбоотой олон төрлийн тохиргоог өөрчлөх боломжтой.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 Хүссэн тохиргоог сонгоно.**




| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| "Current driver" | |
| [ ](Жолооч, эсвэл автомашины нэр)<br>[ ] [**Guest**] | Тухайн жолоочийн нэрийг харуулна. Жолооч хооронд солих, эсвэл миний тохиргоог бүртгэх үед товшино.(→Х. 80) |
| "My settings" | |
| [**Personal info**] | Жолооч таних төхөөрөмж бүртгэнэ.(→Х. 83) |
| [**Bluetooth & Devices**] | Bluetooth® төхөөрөмж бүртгэх, бүртгэл засах үед товшино.<br>(→Х. 123) |
| [**General**] | Цагны тохиргоо, дэлгэцийн хэл, мултимедиа системийн бусад ерөнхий тохиргоог тохируулна.<br>(→Х. 86) |
| [**Data & Wi-Fi**], эсвэл [**Wi-Fi**] | Wi-Fi® тохиргоо болон бусад тохиргоог хийнэ.<br>(→Х. 121) |
| [**Display**] | Дэлгэцний өнгөний ялгарал, гэрлийн түвшин зэргийг тохируулна.(→Х. 89) |
| [**Sound & Media**] | Системийн дуу хоолойн дууны түвшин, аудио эх үүсвэрийн тохиргоог өөрчилнө.(→Х. 115) |

| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| [**Navigation**] | Газрын зургийн дэлгэц, маршрутын зааварчилгаатай холбоотой тохиргоог өөрчилнө. (→Х. 101) |
| [**Voice & Search**] | Дуу хоолой таних үйлдэлтэй холбоотой тохиргоог өөрчилнө. (→Х. 91) |
| "Vehicle" | |
| [**Vehicle customize**] *1 | Хянах самбар, жолооны хүрдний товч зэрэг автомашинтай холбоотой тохиргоог өөрчилнө. |
| [**Driving assist**] *1 | Lexus parking assist-мэдрэгч болон бусад жолоодлогод туслах функцтай холбоотой тохиргоог өөрчилнө. |
| [**Dealer info**] *2 | Дилерийн мэдээлэл бүртгэх буюу устгана.(→Х. 93) |
| [**Info & Security**] | Аюулгүй байдал, нууцлалтай холбоотой тохиргоог өөрчилнө. (→Х. 94) |
| [**Software update**] | Программ хангамжийн мэдээлэл шалгаж шинэчилна.(→Х. 98) |

## МЭДЭЭЛЭЛ

Аюулгүйн үүднээс автомашин явж байх үед зарим функцийг ашиглах боломжгүй.

*1 : Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

*2 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

## Жолооч бүртгэх, бүртгэл өөрчлөх*1

Хэрэглэгчийн профайл бүртгэх, өөрчлөх боломжтой. Хэрэглэгчийн профайл бүртгэснээр жолоодлогын байрлал, мултимедиа тохиргоо, мөн бусад олон янзын автомашины хувийн тохиргоог жолооч тус бүрийн хувийн тохиргоогоор хадгалах боломжтой.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 [ ]<User profile name or vehicle name>, эсвэл [ ][Guest]-г дарна.**

**3 Тохируулах зүйлээ сонгоно.**




| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| "Saved profiles" | Автомашинд бүртгэгдсэн жолоочийн мэдээллийг жагсаалтаар харуулна. Хэрэглэгчийн профайл нэр дээр даран миний тохиргоог өөрчлөн ашиглах боломжтой. Жолоочийн тохиргооны дэлгэц дээр [**Profile lock by password**]*2-г идэвхжүүлсэн үед нууц үг оруулах шаардлагатай.<br>[**Edit**]-г дарж бүртгэгдсэн хэрэглэгчийн профайл устгах, засах боломжтой.*2 |
| [ ] [**Connect your account**]/ [**Create profile**] | Шинэ хэрэглэгчийн профайл бүртгэх. |
| [**Sign out to guest mode**] | Зочин жолооч болгож өөрчлөх үед дарна.<br>Зочин жолооч тохиргоог ашигласнаар бусад миний тохиргоог өөрчлөлгүйгээр хувийн тохиргоог өөрчлөх боломж бүрдүүлдэг. Автомашинаа бусад хүнд шилжүүлэх үед [**Sign out to guest mode**]-г дарж холбогдсон төхөөрөмжийн хувийн мэдээллийг нууцлана. Энэ нь хайлтын түүх, хувийн тохиргоо зэрэг хувийн мэдээллээ хамгаалах үед ашиглах боломжтой. |

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

*2 : Тоноглогдсон автомашинд

**МЭДЭЭЛЭЛ**

Аюулгүйн үүднээс жолоодлогын үед тохиргоог өөрчлөх боломжгүй.

## Шинэ жолооч үүсгэх (A төрөл)

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[ ]<жолоочийн нэр>, эсвэл [ ][Guest]-г дэд цэснээс сонгоно.**

3 **Ухаалаг утасны "Lexus Connected App" Lexus-н аппликейшн ашиглан жолооч бүртгэх үед [Connect your profile]-г дарна.**

- Өөрийн аккаунт, нууц үгээр жолооч бүртгэх үед [**Enter account & password**]-г дарна.

4 **[Next]-г дарна.**

- Ухаалаг утасны "Lexus Connected App" аппликейшн байхгүй үед дэлгэцний QR код ашиглан татна.

5 **Ухаалаг утасны "Lexus Connected App" аппликейшн нээж дэлгэцийн зааврыг дагах ба QR код уншуулах, эсвэл [Link acc. via verification code] баталгаажуулах кодоор жолооч бүртгэнэ.**

Бүртгэл дууссан үед мессеж дэлгэц дээр гарч миний тохиргоо хадгалагдана.

6 **Жолооч бүртгэсний дараа жолооч таних төхөөрөмж бүртгэнэ. Тохиргоог үргэлжлүүлэх үед [Continue]-г дарна.**

Төхөөрөмж дараа бүртгэх боломжтой.

7 **Жолоочийн тохиргооны дэлгэцнээс жолооч бүртгэнэ. Жолооч таних төхөөрөмж бүртгэсэн үед миний тохиргоо автоматаар дуудагдана.**

- Ухаалаг утас, ухаалаг түлхүүр зэрэг дурын төхөөрөмж, мөн хурууны хээг миний тохиргоонд бүртгэх боломжтой.
- Миний тохиргоонд олон төхөөрөмж бүртгэх боломжтой.

### Холбоотой холбоосууд

Жолооч таних тохиргоо хийх(Х. 83)

## Шинэ жолооч үүсгэх (B төрөл)

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **Дэд цэснээс [ ](Жолоочийн нэр, эсвэл автомашины нэр), эсвэл [ ][Guest]-г дарна.**

**3 [ ][Create profile]-г дарна.**

**4 Жолоочийн нэр оруулна.**

**5 Пин код үүсгэж оруулна.**

- Миний тохиргооны хувийн мэдээлэл хамгаалах үүднээс пин код тохируулна.
- Пин кодгүйгээр жолооч бүртгэх үед [**Skip**]-г дарна.

**6 Пин код дахин оруулж жолоочийн бүртгэл хийнэ.**

Бүртгэл дууссан үед мессеж гарч тохиргоо хадгалагдана.

**7 Миний тохиргоо бүртгээд жолооч таних төхөөрөмж бүртгэнэ. Тохиргоог үргэлжлүүлэх үед [Continue]-г дарна.**

Төхөөрөмж дараа бүртгэх боломжтой.

**8 Жолоочийн тохиргооны дэлгэцнээс төхөөрөмж бүртгэнэ. Жолооч таних төхөөрөмж бүртгэсэн үед миний тохиргоо автоматаар дуудагдана.**

- Та миний тохиргоо функцийн дэмждэг ухаалаг утас, ухаалаг түлхүүр зэрэг дурын төхөөрөмжөөс гадна хурууны хээ бүртгүүлэх боломжтой.
- Миний тохиргоонд олон төхөөрөмж бүртгэх боломжтой.

## Жолооч таних тохиргоо хийх

Жолооч таних төхөөрөмж бүртгэнэ. Асаах товчийг ACC, эсвэл ON горимд шилжүүлсэн ба бүртгэгдсэн төхөөрөмж танигдсан үед миний тохиргоогоор тухайн төхөөрөмжинд сануулсан тохиргоо автоматаар дуудагдана. Ухаалаг утас, ухаалаг түлхүүр зэрэг төхөөрөмжийг жолооч таних төхөөрөмжөөр бүртгэх боломжтой.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 Дэд цэсний [Personal info]-г дарна.**

**3 Тохируулах зүйлийг сонгоно.**




▶ A төрөл

| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| "Хэрэглэгчийн профайлын нэр" | Хэрэглэгчийн профайлын нэрийг харуулна.<br>Дараах товчийг дарна. [**Edit**]*1 |
| "Devices linked to your profile" | |
| [**Хурууны хээ**] *1 *2 | Жолоочийг хурууны хээгээр таниж холбогдох тохиргоог дуудна. Автомашин асаах хурууны хээг бүртгүүлсэн үед тухайн хурууны хээг миний тохиргоо дээр бүртгэнэ. Автомашин асаах хурууны хээ бүртгээгүй үед [**Add fingerprint**]-г дарж шинэ хурууны хээ бүртгэнэ. (→ Х.95) |
| [**Link key**] *2 *3 | Автомашины ухаалаг түлхүүрээр жолооч таниж холбогдох тохиргоог дуудна. |

| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| "Bluetooth devices" | Ухаалаг утас, эсвэл бусад Bluetooth® төхөөрөмжөөр жолооч таниж холбогдох тохиргоог дуудна. [**Link devices**]-г дарж бүртгэнэ. (→Х. 148) |
| [**Profile lock by password**] | Миний тохиргоог гараар өөрчлөхөд ашиглах нууц үг тохируулна. |
| [**Reset settings**] | Тухайн сонгосон миний тохиргооны тохиргоог дахин тохируулна. |
| [**Delete driver**] | Тухайн сонгосон миний тохиргоог устгана.<br>Эзэмшигчээр бүртгэгдсэн миний тохиргоог устгах үед автомашины бүх миний тохиргоо устгагдана. |

▶ В төрөл

| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| "Хэрэглэгчийн профайлын нэр" | Хэрэглэгчийн профайлын нэрийг харуулна.<br>[**Edit**] дээр дарж хэрэглэгчийн профайлын нэр өөрчлөх боломжтой.*1 |
| "Таны профайлд холбогдсон төхөөрөмжүүд" | |
| "PIN" | PIN кодоор жолооч таниж холбогдох тохиргоонуудыг дуудна. [**Set new PIN**]-г дарж бүртгэнэ. |
| [**Хурууны хээ**] *1 *2 | Жолоочийг хурууны хээгээр таниж холбогдох тохиргоог дуудна. Автомашин асаах хурууны хээг бүртгүүлсэн үед тухайн хурууны хээг миний тохиргоо дээр бүртгэнэ. Автомашин асаах хурууны хээ бүртгээгүй үед [**Add fingerprint**]-г дарж шинэ хурууны хээ бүртгэнэ. (→ Х.95) |

| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| [**Link key**] *2 *3 | Автомашины ухаалаг түлхүүрээр жолооч танин холбогдох тохиргоонуудыг дуудна. |
| "Bluetooth devices" | Ухаалаг утас, эсвэл бусад Bluetooth® төхөөрөмжөөр жолооч таниж холбогдох тохиргоог дуудна. [**Link devices**]-г дарж бүртгэнэ. (→Х. 148) |
| [**Reset settings**] | Тухайн сонгосон миний тохиргоог устгана. |
| [**Delete driver**] | Тухайн сонгосон миний тохиргооны бүртгэлийг устгана. |



*1 : Тоноглогдсон автомашинд

*2 : Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

*3 : Түрээсийн автомашин зэрэг олон тоогоор захиалдаг автомашинд ашиглах боломжгүй.

## Мултимедиа системийн ерөнхий тохиргоог өөрчлөх

Цаг, дэлгэцийн хэл, мөн бусад мултимедиа системиийн тохиргоог өөрчлөх боломжтой.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 Дэд цэсний [General]-г дарна.**

**3 Хүссэн тохиргоогоо сонгоно.**




● [**Ашиглахад хялбар байдал**]

| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| [**Reduce animation**] | Дэлгэц солих үеийн анимацийг бууруулна. |
| [**Screen beep**] | Дэлгэц товших үед гарах дууг асаах буюу унтраана. |
| [**Screen sensitivity**] | Товших үеийн дэлгэцийн мэдрэг байдлыг тохируулна. |

● [**Өдөр, цаг**]

| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| [**Set automatically**] | GPS мэдээлэл болон газрын зургийн дата ашиглан цаг автоматаар тохируулна. Тус тохиргоог унтраасан үед цаг, цагийн бүсийг гараар тохируулах боломжтой. |
| "Time" | |
| [**24-hour time**] | Цагийг 12 болон 24 цагаар гаргана. |
| [**Time zone**] *1 | [**Set automatically**]-г унтраасан үед цагийн бүсийг гараар тохируулах боломжтой. |

| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| [**Daylight savings**] *1 | [**Set automatically**]-г унтраасан үед тус тохиргоог [**Auto**][**On**], эсвэл [**Off**] горимд тохируулах боломжтой. |
| [**Set time automatically**] | [**Set automatically**]-г унтраасан үед GPS ашиглан цаг автоматаар тохируулах үгүйг сонгох боломжтой. Тус тохиргоог унтраасан үед цаг гараар тохируулах боломжтой. |
| [**Set time manually**] | [**Set time automatically**]-г унтраасан үед цаг гараар тохируулах боломжтой. |
| "Date" | |
| [**Format**] | Огнооны формат өөрчилнө. (MM/DD/YYYY, DD/MM/YYYY, YYYY/MM/DD зэрэг) |

● [**Keyboard**]

| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| "Түүх" | |
| [**Memorize keyboard**] | Гараар бичиж оруулсан үгний түүхийг санана. |
| [**Delete keyboard history**] | Гарны үг санах түүхийг устгана. |
| [**Delete search history**] | Гарны хайлтын түүх устгана. |

● [**Language & Units**] *1

| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| [**Language**] *1 | Хэл солино. Дэлгэцийн болон дуу хоолойн системийн хэлийг солих боломжтой. |
| [**System language**] *1 | Системийн хэлийг солино. |
| [**Voice language**] *1 | Системийн дуу хоолойн хэлийг солино. |
| "Measurements" | |

| Тохиргоо | Тайлбар |
| --- | --- |
| [**Set automatically**] | Зай, шатахууны хэмнэлт, дугуйн даралт болон бусад мэдээллийг тухайн улсын мэдээлэл дээр үндэслэн автоматаар тохируулна. |
| [**Trip info. Unit**] | [**Set automatically**]-г унтраасан үед шатахуун хэмнэлтийн дэлгэцийн нэгжийг гараар өөрчлөх боломжтой. |
| [**Tire pressure**] | [**Set automatically**]-г унтраасан үед дугуйн даралтын дэлгэцийн нэгжийг гараар өөрчлөх боломжтой. |

### МЭДЭЭЛЭЛ

- Хэлний тохиргоог өөрчилсөн ч дэлгэцээр гарах бүх контент, дуут зааварчилгаа сонгосон хэлэнд шилжихгүй. Мөн хэл өөрчилсөн үед зарим дуут зааварчилгааны функц ажиллахгүй.
- Apple CarPlay/Android Auto-н хэлний тохиргоог холбосон төхөөрөмж дээр хийнэ.

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

## Дэлгэцийн тохиргоог өөрчлөх

Дэлгэцийн өнгөний ялгарал, гэрлийн түвшинг тохируулах боломжтой.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **Дэд цэсний [Display]-г дарна.**

3 **Тохируулах зүйлээ сонгоно.**




● [**Screen**]

| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| [**Display**] | Дэлгэц асаах, эсвэл унтраах үед дарна. Дэлгэц унтарсан үед дэлгэцээр дүрс гарахгүй ба зөвхөн дуу гарна.<br>Дэлгэцийг дахин гаргах үед дэлгэц дээр товшоод дэлгэцний голын товч дээр дарна |
| "Mode" | |
| [**Automatic**] *1 | Их гэрэл асаах, унтраах үед дэлгэц автоматаар өдрийн болон шөнийн горимд шилжинэ. |
| [**Daytime (light)**] | [**Automatic**]-г унтраасан үед дэлгэцийг өдрийн горимд гараар шилжүүлэх боломжтой. |
| [**Nighttime (dark)**] | [**Automatic**]-г унтраасан үед дэлгэцийг шөнийн горимд гараар шилжүүлэх боломжтой. |
| [**Brightness**] | Дэлгэцийн гэрлийн түвшинг тохируулна. |
| [**Contrast**] | Дэлгэцийн өнгөний ялгарлыг тохируулна. |

● [**Camera**]

| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| "Camera screen" | |
| [**Brightness**] | Дэлгэцийн гэрлийн түвшинг тохируулна. |
| [**Contrast**] | Дэлгэцийн өнгөний ялгарлыг тохируулна. |

## МЭДЭЭЛЭЛ

- Аудио дүрсний чанарыг тохируулах тухай дэлгэрэнгүйг “ Дүрсний чанар тохируулах ”(→Х. 119)-с харна уу.
- Дэлгэц унтарсан үед ч автомашины байрлалыг GPS үргэлжлүүлэн уншина.
- Дэлгэц
  - Товчноос бусад дэлгэцийн хэсэгт товшсон үед дэлгэц буцаж унтарна.
  - Дэлгэц унтарсан үед жолооны хүрдний [] товч дарах, эсвэл арааг R-д шилжүүлсний дараа камерын дэлгэц гарах зэргээр дэлгэц түр хугацаанд асч болно. Түр ассан дэлгэцийг унтраах үед дэлгэц буцаж унтарна.

*1 : Их гэрлийн автомат функц ашиглах үед гадна гэрлийн идэвхээс хамаарч гэрэл асч унтарна. Байрлалаас хамаарч систем автоматаар өдрийн (гэрэлтэй) болон шөнийн (бүдэг) горимд шилжихгүй байж болно.

## Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх

Дуу хоолойн таних функцийн тохиргоог өөрчлөх боломжтой.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**
2 **Дэд цэсний [Voice & Search]-г дарна.**
3 **Тохиргоо хийх зүйлийг сонгоно.**




| Setting | Description |
|---|---|
| "Voice recognition" | |
| [**Wake word**] | Систем идэвхжүүлэх сэрээх үгийг өөрчилнө.(→Х. 91) |
| [**Set custom wake word**] | Систем идэвхжүүлэх сэрээх үгийг өөр үгээр тохируулна. |
| [**Mic button**] | [ ]-г гаргах буюу нууна. |
| "Voice feedback" | |
| [**Voice prompt**] | Дуут зөвлөмжийг асааж унтраана. |
| "Notification" | |
| [**Voice support**] | Дуудлага ирэх болон бусад мэдэгдэлд дуу хоолойгоор хариу үйлдэл хийх боломжтой. |

## Дуу хоолойн удирдлагын систем асаах сэрээх үг солих

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**
2 **Дэд цэснээс [Voice & Search]-г дарна.**
3 **[Wake word]-г дарна.**

**4 Жагсаалтаас сэрээх үг сонгоно.**




### МЭДЭЭЛЭЛ

- Сэрээх үгийг өөрийн хүссэн үгээр тохируулах үед [**Set custom wake word**]-г дарж дэлгэцийн гар ашиглан тохируулах үгээ бичиж оруулна.
- Эхлүүлэх үг хэт богино үед дуу хоолойн командыг систем таних боломжгүй. 4-с олон үетэй үг сонгоно.

## Дилерийн мэдээлэл тохируулах*1

Дилерийн мэдээлэл бүртгэх, устгах боломжтой. Засвар үйлчилгээнд хамрагддаг дилерийн мэдээлэл бүртгэсэн нөхцөлд засвар үйлчилгээний цаг захиалах шаардлагатай үед тохиргооны дэлгэцнээс дилер лүүгээ холбогдох боломжтой болно.

1 **Үндсэн цэсний []-г дарна.**

2 **Дэд цэснээс [Dealer info]-г дарна.**

3 **Өөрчлөх тохиргоог сонгоно.**




| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| [**Add dealer**] | Дилер бүртгэнэ. |
| [**Dealer name**] | Дилерийн нэр өөрчлөнө. |
| [**Contact**] | Дилерийн хариуцсан ажилтны нэр бүртгэх, эсвэл өөрчлөнө. |
| [**Phone**] | Дилерийн утасны дугаар бүртгэх, эсвэл өөрчлөнө. |
| [**Delete dealer**] | Дилерийн мэдээлэл устгана. |

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

## Аюулгүй байдлын тохиргоо өөрчлөх

Аюулгүй байдал болон нууцлалтай холбоотой тохиргоог өөрчлөх боломжтой.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **Дэд цэсний [Info & Security]-г дарна.**

3 **Тохируулах зүйлийг сонгоно.**




| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| [**Vehicle name**] | Системийн нэр (автомашины нэр)-г харуулна.<br>Энэ нь Bluetooth® төхөөрөмжийг бусад төхөөрөмжөөс хайх үед гардаг нэр болно. Нэр дээр товшин өөрчлөх боломжтой. |
| "Fingerprints" [*1] | |
| [**Allow fingerprints**] | Хурууны хээгээр таних функцийг идэвхжүүлнэ. Идэвхжүүлсэн үед зөвхөн хурууны хээ таниулан автомашин асаах боломжтой. |
| [**Saved fingerprints**] | Автомашинд бүртгэгдсэн хурууны хээний жагсаалт гаргана. [**Edit**] дээр дарж хурууны хээний бүртгэл устгах, нэр өөрчлөх боломжтой.<br>Өөр жолооч дээр бүртгэгдсэн хурууны хээг устгах боломжгүй. Тухайн жолоочийн тохиргооноос хурууны хээ устгах боломжтой. (→Х. 83) |
| [**Add fingerprints**] | Шинэ хурууны хээ бүртгэнэ. (→Х. 95) |
| "Privacy" | |

| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| [**Privacy lock**] | Хувийн мэдээлэл хамгаалах үүднээс нууц үгээр хамгаалагдсан аюулгүйн цоожийг идэвхжүүлнэ. Идэвхжүүлсэн нөхцөлд 12в аккумулятор солих, эсвэл автомашинаас мултимедиа систем салгах үед нууц үг шаардана. |
| [**Reset privacy lock password**] | Аюулгүйн цоожны нууц үгийг дахин тохируулна. |
| [**Remote security**] *2 | Зайнаас удирдах аюулгүйн системийн ажиллагааг харуулна. |
| [**System reset**] | Системийн бүх датаг устгаж тохиргоог үйлдвэрийн тохиргоонд буцаана. |

### МЭДЭЭЛЭЛ

- Систем дахин тохируулсны дараа холболт салж болно. Энэ нөхцөлд системийг дахин асаана.
- Бүх мэдээллийг анхны тохиргоонд буцаасны дараа мултимедиа систем үйлдвэрийн үндсэн тохиргоонд буцна. Системийг анхны тохиргоонд буцаахаас өмнөх байдалд буцаах боломжгүй.

#### Холбоотой холбоосууд

Систем дахин асаах(Х. 17)

## Хурууны хээгээ бүртгэх

1 **Үндсэн цэсний [  ]-г дарна.**

2 **Дэд цэснээс [Info & Security]-г дарна.**

3 **[Add fingerprints]-г дарна.**

*1 : Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

*2 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

**4 Хурууны хээ бүртгэлийн анхааруулгыг уншаад [Agree]-г дарна.**




[**Agree**]-г дарах нь хурууны хээ бүртгэлийн анхааруулгыг хүлээн зөвшөөрснийг илэрхийлнэ. (Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.) Хувийн мэдээлэлтэй харьцах тухай гэрээг хүлээн зөвшөөрсөн үед систем ашиглах боломжтой.

**5 Хуруу бүртгүүлэх жолоочийн нэр оруулна.**

**6 Асаах товчны мэдрэгч дээр хурууны хээгээ систем бүрэн таних хүртэл олон байрлалаар үргэлжлүүлэн байрлуулна.**




- Хурууны хээ бүртгэгдэж дууссан үед мессеж гарна.
- Бүртгэгдсэн хурууны хээ устгах, эсвэл нэмэлт хурууны хээ бүртгэх үед одоо бүртгэсэн байгаа хурууны хээг таниулах шаардлагатай.

### МЭДЭЭЛЭЛ

Хүн бүрт 2, нийт 5 хүний хурууны хээ бүртгэх боломжтой.

## Аюулгүй байдлын түгжээ тохируулах

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 Дэд цэсний [Info & Security]-г дарна.**

**3 [Privacy lock]-г дарна.**

**4 [OK]-г дарна.**

**5 Тоо болон үсгээс бүрдэх 4-15 тэмдэгттэй нууц үг сонгоно.**

**6 Нууц үгийг дахин оруулна.**

Мессеж гарч аюулгүй байдлын түгжээ идэвхжинэ.

### МЭДЭЭЛЭЛ

- Нууц үг идэвхжсэн үед аккумлятор сольсны дараа, автомашинаас мултимедиа систем салгаад дахин холбоод мултимедиа систем

ашиглах зэрэг нөхцлүүдэд нууц үг оруулна. Энэ үед нууц үг оруулна.

- Нууц үгийг олон удаа буруу оруулсан үед нууц үг оруулах боломжгүй болно. Энэ нөхцөлд та өөрийн дилерт хандах, эсвэл [**System reset**]-г дарж системийн тохиргоог тэглэнэ.
- Аюулгүйн үүднээс нэг нууц үгийг олон давтан ашиглах, эсвэл толь бичгээс олох боломжтой үг сонгохгүй байх нь зүйтэй.

## Программ хангамжийн мэдээлэл шалгах, шинэчлэх

Программ хангамжийн мэдээлэл шалгаж шинэчлэх боломжтой. Мултимедиа системийн ажиллагааг сайжруулах, ашиглалтыг илүү хялбар болгох үүднээс программ хангамж шинэчилдэг.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 Дэд цэсний [Software update]-г дарна.**

**3 Шинэчлэх тохиргоог дарна.**




| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| "Software update" | |
| [**Updates available**] *1 | Программын шинэчлэлийн мэдээлэл шалгах үед [**View**]-г дарна. Шинэчлэлт байгаа үед шинэчлэлтийн датаг татаж программ шинэчлэх боломжтой.<br>Шинэчлэлт байхгүй үед [**No updates available**] гарна. |
| [**Model info**] | Одоогийн программын хувилбарыг шалгана. |
| [**Update software**] *1 | Программ шинэчилнэ.<br>Шинэчлэлт байхгүй үед тус мэдээлэл дэлгэцээр гарахгүй. |
| [**Output info to USB memory**] *1 | Тус автомашинд энэ функц байхгүй. |
| [**History**] *1 | Программ шинэчлэлтийн түүх харуулна.<br>Программ шинэчлэлтийн түүх байхгүй үед тус мэдээлэл гарахгүй. |
| [**License information**] | Программын лицензийн мэдээлэл шалгана. |

### Программ хангамж шинэчлэх

Дараах аль нэр аргаар программ хангамж шинэчилнэ:

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

- **Өгөгдлийн холболтын модуль (DCM) ашиглан шинэчлэх**
- **Wi-Fi® ашиглан шинэчлэх**

### МЭДЭЭЛЭЛ

- Тус үйлчилгээгээр газрын зургийн дата шинэчлэх боломжгүй.
- Программ шинэчлэгдэх үед зарим үйлдлийг хийх боломжгүй.
- Мэдээлэл шаардлагатай үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

### АНХААР

- Программ хангамж шинэчлэхээс үүсэх эрсдлийг та өөрийн үүрэг хариуцлагаар хариуцна.
- Шинэчлэгдсэн үед программ хангамжийг өмнөх хувилбарт буцаах боломжгүй.
- Шинэчлэгдсэн программ хангамжийг зөвхөн тус системд ашиглах боломжтой. Өөр төхөөрөмжинд ашиглах боломжгүй.
- Программ хангамжийн шинэчлэлийн агуулгаас хамаарч зарим тохиргоо тэглэгдэж болно. Энэ нөхцөлд боломжит тохиргоог дахин тохируулна.
- Шинэчлэл хийгдэх үед үндсэн функцуудыг ашиглах боломжтой ч ажиллагаа удаан байж болзошгүй. Боломжтой нөхцөлд системийг удирдахаас татгалзана.
- Программ хангамж шинэчлэгдсэний дараа Тоёота Мотор Корпорацийн серверт шинэчлэл хийгдсэн тухай мэдэгдэл автоматаар илгээгдэнэ. Тоёота Мотор Корпорац нь тус мэдэгдлийг программ хангамж шинэчлэхээс өөр зорилгоор ашиглахгүй. Таны хамрагдсан үйлчилгээ, тарифаас хамаарч дата төлбөр гарч болохыг анхаарна уу.

## DCM, эсвэл Wi-Fi® ашиглан программ шинэчлэх*2

Систем тогтмол хугацаанд серверт холбогдож программын шинэчлэлтийг шалгадаг.

1. Программын шинэчлэлийн мэдэгдлийн [ ] дээр дарна.
2. Дэлгэцийн зааварчилгааны дагуу шинэчлэлтийн агуулга болон ашиглах нөхцлийг шалгана.
   - Шинэчлэлийг татаж эхлэнэ. Татаж дууссаны дараа шинэчлэл эхлэнэ. (10-15 минут шаардагдана)
   - Холболтын байдлаас хамаарч шинэчлэл татах, суулгах хугацаа нэмэгдэж болно. Суулгах явцад хөдөлгүүр унтраасан үед асаах товчийг ACC, эсвэл ON горимд дараагийн удаа шилжүүлэх үед шинэчлэл үргэлжлэнэ.

*2 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

- Шинэчлэл дууссан үед дэлгэц дээр мессеж гарна.
- Системийг дахин асаах шаардлагатай үед мессеж гарна. [**Yes**]-г дарж систем дахин асаана.
- Программ хангамжийн шинэчлэлийн түүх шалгах үед программ хангамжийн шинэчлэлийн түүхийн дэлгэцнээс [**History**]-г дарна.

## ■ Программ гар аргаар шинэчлэх

1. Үндсэн цэснээс [⚙]-г дарна.
2. Дэд цэсний [**Software update**]-г дарна.
3. [**View**] of "Updates available"-г дарна.
4. Дэлгэцийн зааварчилгааны дагуу шинэчлэлтийн агуулга болон ашиглах нөхцлийг шалгана.
   - Шинэчлэлийг татаж эхлэнэ. Татаж дууссаны дараа шинэчлэл эхлэнэ. (10-15 минут шаардагдана)
   - Холболтын байдлаас хамаарч шинэчлэл татах, суулгах хугацаа нэмэгдэж болно. Суулгах явцад хөдөлгүүр унтраасан үед асаах товчийг ACC, эсвэл ON горимд дараагийн удаа шилжүүлэх үед шинэчлэл үргэлжлэнэ.
   - Шинэчлэл дууссан үед дэлгэц дээр мессеж гарна.
   - Системийг дахин асаах шаардлагатай үед мессеж гарна. [**Yes**] дарж дахин асаана.
   - Программ шинэчлэлийн түүхийг [**History**] дарж үзнэ.

### МЭДЭЭЛЭЛ

- Сервер дээр туйлын чухал шинэчлэл байгаа үед мессеж гарна. [**OK**] дарж шинэчлэл татна.
- Wi-Fi® ашиглан программ шинэчлэх үед дараах нөхцлүүд бүрдсэн байх шаардлагатай:
  - Системийг Wi-Fi®-д холбоно (гэр, ажлын зэрэг)
  - Wi-Fi®-д холбох боломжтой газар автомашин шилжүүлнэ
  - Холболтын тохиргоог [Wi-Fi®] болгоно

## Навигацийн системийн тохиргоо

Навигацийн системийн тохиргоогоор газрын зургийн өнгө, үсгийн хэмжээ зэрэг олон төрлийн тохиргоог өөрчлөх боломжтой.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Navigation]-г дарна.**

3 **Тохируулах зүйл дээр дарна.**

- Газрын зургийн дэлгэцийн тохиргоо
- Маршрутын тохиргоо
- Зааварчилгааны тохиргоо
- Газрын зураг шинэчлэх тохиргоо
- Бусад тохиргоо

### Холбоотой холбоосууд

Газрын зургийн дэлгэцийн тохиргоо өөрчлөх(Х. 102)

Маршрутын зааварчилгаа(Х. 104)

Зааварчилгааны тохиргоо(Х. 107)

Газрын зургийн мэдээллийн сангийн хувилбар ба хамрах хүрээ(Х. 202)

Бусад тохиргоо(Х. 109)

## Газрын зургийн дэлгэцийн тохиргоо өөрчлөх

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Navigation]-г дарна.**

3 **Тохируулах зүйлээ сонгоно.**




| Тохиргоо | Тайлбар |
| --- | --- |
| [**Country border guidance**] *1 | Улсын хилийн зааварчилгааг асаах, унтраах үед дарна.<br>Зааварчилгааг асаасан үед улсын хилээр гарсан нөхцөлд зааварчилгаа гарна. |
| [**Map style customization**] | Газрын зургийн өөрчлөх боломжтой тохиргоог өөрчлөх үед дарна. |
| "Traffic information" | |
| [**Show road class**] | Замын хөдөлгөөний мэдээлэл харуулах талбайг өөрчлөх үед дарна.<br>Замын төрлийг сонгоод [**OK**] дарна. |
| [**Show traffic jam flows**] | Замын түгжрэл, ачаалал ихтэй замын мэдээллийг гаргах, унтраах үед дарна. |
| [**Show free traffic flows**] | Одоогийн хөдөлгөөний мэдээлэл дээр үндэслэн чөлөөтэй замын мэдээлэл гаргах, унтраах үед дарна. |
| [**Traffic incident warning**] | Зам тээврийн ослын анхааруулга гаргах, унтраах үед дарна. |
| [**Show POI icons settings**] | Дэлгэц дээрх POI тэмдгийг өөрчлөх үед дарна. |

| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| [**3D view settings**] | Дэлгэцийн өнцгийг өөрчилж 3D болгох үед дарна. |
| [**On street parking suggestion**] *1 | Гудамжны зогсоол санал болгох зөвлөмжийг асааж унтраана. |
| [**Map language**] | Газрын зургийн хэл өөрчлөх үед дарна.<br>Дарсны дараа [**Region**], эсвэл [**System language**]-г сонгоод [**OK**] дарна. |

## Холбоотой холбоосууд

Дэлгэцийн өнцгийн тохиргоо(Х. 103)

Газрын зургийн дэлгэцийг өөрийн хүссэнээр тохируулах(Х. 103)

## Газрын зургийн дэлгэцийг өөрийн хүссэнээр тохируулах

Газрын зургийн өнгө болон үсгийн хэмжээг өөрчлөх боломжтой.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Navigation].**

3 **[Map style customization]-г дарна.**

4 **Тохируулах зүйл дээрээ дарна.**




A Газрын зургийн дэлгэц дэх үсгийн хэмжээг өөрчилнө.

B Газрын зургийн өнгө өөрчлөх үед товшино.

5 **[OK]-г дарна.**

## Дэлгэцийн өнцгийн тохиргоо

3D газрын зургийн дэлгэцийн өнцгийг өөрчлөх боломжтой.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Navigation]-г дарна.**

3 **[3D view settings]-г дарна.**

4 **[ ] (өнцөг нэмэх), эсвэл [ ] (өнцөг хасах)-г дарна.**

5 **[OK]-г дарна.**

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

## Маршрутын зааварчилгаа

**1 Үндсэн цэсний []-г дарна.**

**2 [Navigation]-г дарна.**

**3 [Route]-г дарна.**

**4 Тохиргоо хийх зүйлээ сонгоно.**




| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| [**Area to avoid**] | Зайлсхийх газар, бүсийг тохируулна. |
| [**Avoid traffic**] *1 | Замын түгжрэлээс зайлсхийх функцийг тохируулах үед дарна.<br>Товчийг товшоод [**Auto**], [**manual**], эсвэл [**Off**]-г дараад [**OK**] дарна. |
| [**Gas stations suggestion**] | ШТС санал болгох автомат дэлгэцийг унтраах буюу асаана. |
| [**Route learning**] | Маршрут суралцах үйлдлийг асааж унтраана. |
| [**Reset route learning**] | Маршрут суралцсан ой санамжийг арилгана. |

### Холбоотой холбоосууд

Зайлсхийх зам, хэсгийн тохиргоо(Х. 104)
Хайлтын үр дүнгийн жагсаалтын дэлгэц(Х. 187)
Бүтэн маршрутын газрын зургийн дэлгэц(Х. 191)

## Зайлсхийх зам, хэсгийн тохиргоо

Зам засвар, хөдөлгөөн хаагдсан, эсвэл тогтмол түгжирдэг зам болон хэсгийг зайлсхийх зам, хэсгээр бүртгэн тус хэсгийг оруулалгүйгээр маршрутын хайлт хийх боломжтой.

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**
2 **[Navigation]-г дарна.**
3 **[Route]-г дарна.**
4 **[Area to avoid]-г дарна.**
5 **Тохиргоог хийнэ.**




A Бүртгэгдсэн зайлсхийх зам, хэсгийг жагсаалтаар харуулна. Засварлах үед тухайн зам, хэсэг дээр товшино.

B Бүртгэгдсэн зайлсхийх зам, хэсгийг устгах үед товшио.

C Тухайн зам, хэсгийг зайлсхийх зам, хэсгээр бүртгэх үед товшино.

## Зайлсхийх газар, зам бүртгэх

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**
2 **[Navigation]-г дарна.**
3 **[Route]-г дарна.**
4 **[Area to avoid]-г дарна.**
5 **[Add]-г дарна.**
6 **Газрын зургийг гүйлгэн зайлсхийх газар, зам хайна.**
7 **[OK]-г дарна.**

Зайлсхийх газар, замын талбайг шар дөрвөлжингөөр харуулна.

8 **[ ] (нэмэх), эсвэл [ ] (хасах) дарж зайлсхийх газар, замын хэмжээг тохируулаад [OK]-г дарна.**
9 **Засварлах дэлгэц дээр өөрчлөлт хийгээд [OK]-г дарна.**

## Зайлсхийх газар, замын тохиргоог өөрчлөх

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**
2 **[Navigation]-г дарна.**
3 **[Route]-г дарна.**
4 **[Area to avoid]-г дарна.**
5 **Тухайн засах гэж буй зайлсхийх газар, зам дээр дарна.**

**6 Өөрчлөх тохиргоо дээр товшино.**




A Зайлсхийх газар, замын нэр өөрчлөх үед дарна.

B Зайлсхийх газар, замын хамрах талбайг өөрчлөх үед дарна.

**7 [OK]-г дарна.**

## Зайлсхийх газар, зам устгах

**1 Үндсэн цэсний [ ⚙ ]-г дарна.**

**2 [Navigation]-г дарна.**

**3 [Route]-г дарна.**

**4 [Area to avoid]-г дарна.**

**5 [Edit]-г дарна.**

**6 [ ⊖ ]-г дарж зайлсхийх газрыг устгана.**

- [**Delete all**] : Бүх зайлсхийх газрыг устгана.
- [**Cancel**] : Устгах үйлдлийг цуцлана.

**7 [OK]-г дарна.**

## Зааварчилгааны тохиргоо

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Navigation]-г дарна.**

3 **[Guidance]-г дарна.**

4 **Тохиргоо хийх зүйлийг дарна.**




| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| [**Intersection map**] | Уулзварын томруулсан дэлгэц гаргах, унтраах үед дарна. |
| [**Automatic zoom**] | Автоматаар томруулах функцийг асаах, унтраах үед дарна. |
| [**Speed limit**] *1 | Хурдны дээд хязгаарын мэдээг асаах, унтраах үед дарна.<br>Автомашин цагийн бүсчлэлтэй хурдны хязгаартай бүсэд орсон (худалдааны төв, явган хүний бүс, сургуулийн ойр орчим зэрэг) үед хурдны дээд хязгаарын мэдээллийн дэлгэцний хажууд нэмэлт анхааруулга гарна. |
| [**Speed camera**] *1 | Хурдны камерны байрлалыг тэмдгийг өөрчлөх үед дарна.<br>[**On**], [**On & Audible**], эсвэл [**Off**]-г дараад [**OK**] дарна. |
| [**Guidance with street names**] | Гудамжны нэрний зааварчилгааг асаах, унтраах үед дарна. |
| [**Weather warning**] *1 | Цаг агаарын анхааруулга асаах, унтраах үед дарна. |
| [**ERP warning**] *1 | Маршрутанд ERP нэвтрэх цэг орсон үед бүтэн маршрутын газрын зураг дээр ERP нэвтрэх цэгийн анхааруулга гарна. |

| Тохиргоо | Тайлбар |
| --- | --- |
| [**Traffic jam warning guidance**] | Замын түгжрэлийн дуут анхааруулга асаах, унтраах үед дарна. |
| [**Landmark voice guidance**] | Түүхэн дурсгалт газрын дуут зааварчилгааг асаах, унтраах үед дарна. |
| [**Guide language**] | Дуут зааварчилгааны хэл өөрчлөх үед дарна.<br>● Хэл сонгоод [**OK**] дарна.<br>● Ерөнхий дуут зааварчилгааны хэлийг өөрчлөх боломжтой боловч байршлын оноосон нэрний хэлийг өөрчлөх боломжгүй. |
| [**SALIK warning**] *1 | Маршрутанд SALIK нэвтрэх цэг орсон үед бүтэн маршрутын газрын зураг дээр SALIK нэвтрэх цэг байгааг анхааруулах анхааруулга гарна. |
| [**Rodizio warning**] *1 | Маршрутанд Rodizio сегмент орсон үед бүтэн маршрутын газрын зураг дээр Rodizio сегмент байгааг анхааруулах анхааруулга гарна. |
| [**E-toll warning**] *1 | Маршрутанд e-toll нэвтрэх цэг орсон үед бүтэн маршутын газрын зураг дээр e-toll нэвтрэх цэг байгааг анхааруулах анхааруулга гарна. |

### МЭДЭЭЛЭЛ

Контентын менежментийн байдлаас шалтгаалж SALIK, e-toll, ERP нэвтрэх цэгийг танихгүй байж болно.

## Холбоотой холбоосууд

Замын эгнээ харуулах дэлгэц(Х. 198)

Хурдны камер(Х. 179)

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

## Бусад тохиргоо

**1 Үндсэн цэсний []-г дарна.**

**2 [Navigation]-г дарна.**

**3 [Other]-г дарна.**

**4 Тохируулах зүйлийг сонгоно.**




| Тохиргоо | Тайлбар |
|---|---|
| [**Delete recent destinations**] | Очих газрын түүх устгана.<br>Устгах гэж буй очих газар дээр дараад [**OK**]-г дарна. Бүх түүх устгах үед [**Delete all**]-г дараад [**OK**]-г дарна. |
| [**Favorites**] | Тогтмол ашигладаг тохиргоог засварлана. |
| [**Position/Direction**] | Автомашины чиглэлийг засах үед дарна. |
| [**Service information**] | |
| [**Expiration date:**]*1 | Үйлчилгээний үргэлжлэх хугацааг харуулна. |
| [**Service ID:**]*1 | Үйлчилгээний ID-г харуулна. |
| [**Terms and conditions**]*1 | Үйлчилгээний нөхцлийг харуулна. |
| [**Consent status**]*1 | Зөвшөөрлийн статусыг харуулна. |
| [**Consent day**]*1 | Зөвшөөрсөн огноог харуулна. |
| [**Privacy/Policy**]*1 | Хувийн нууцлал/нөхцлийг харуулна. |
| [**Copyright**] | Зохиогчийн эрхийг харуулна. |

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

### Холбоотой холбоосууд

Тогтмол ашигладаг тохиргоо(Х. 110)
Байршил/Чиглэлийн тохиргоо(Х. 113)

## Тогтмол ашигладаг тохиргоо

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**
**2 [Navigation]-г дарна.**
**3 [Other]-г дарна.**
**4 [Favorites]-г дарна.**
**5 Өөрчлөх тохиргоог сонгоно.**

A Жагсаалт өөрчлөх үед сонгоно.

B USB төхөөрөмж рүү тохиргоог экспортлох, эсвэл USB төхөөрөмжөөс тохиргоо системд оруулах үед сонгоно.*2




### Тогтмол ашигладаг газраар бүртгэх

Тухайн цэгийг тогтмол ашигладаг газраар бүртгэх үед тухайн цэгийн мэдээлэл газрын зураг дээр гарах үед [ ]-г дарж бүртгэнэ.

### Холбоотой холбоосууд

Тухайн цэгийн тухай мэдээлэл гаргах(Х. 175)
Бүтэн маршрутын газрын зургийн дэлгэц(Х. 191)

### Тогтмол ашигладаг жагсаалтыг засварлах

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**
**2 [Navigation]-г дарна.**
**3 [Other]-г дарна.**
**4 [Favorites]-г дарна.**
**5 Засварлах тогтмол ашигладаг жагсаалт сонгоно.**

*2 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

**6 Засварлах зүйлээ сонгоно.**




A Тогтмол ашигладаг тохиргооны нэр засна.

B Утасны дугаар засна.

C Одоогийн байршлыг өөрийн гэрээр бүртгэнэ.

D Одоогийн байршлыг байнга очдог цэгээр бүртгэнэ.

E Газрын зургийн дэлгэцийн тэмдэг өөрчлөнө.

**7 [OK] дарна.**

**МЭДЭЭЛЭЛ**

Байнга очдог цэг бүртгэсэн үед тус байршлыг очих газар хайх үед тогтмол ашигладаг жагсаалтын дээд талд гаргана.

## Тогтмол ашигладаг тохиргоог устгах

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 [Navigation]-г дарна.**

**3 [Other]-г дарна.**

**4 [Favorites]-г дарна.**

**5 [Edit]-г дарна.**

**6 Устгах тогтмол ашигладаг тохиргооны [ ]-г дарна.**

- [**Delete all**] : Бүх тохиргоог устгана.
- [**Cancel**] : Тохиргоо устгах үйлдлийг цуцлана.

**7 [OK]-г дарна.**

## USB төхөөрөмж рүү гаргах

Навигацийн системд бүртгэгдсэн тогтмол ашигладаг тохиргоог USB төхөөрөмж рүү хадгалах боломжтой. Датаг нөөцлөхөөс өмнө нууц үг тохируулах шаардлагатай. Экспортлон гаргасан тогтмол ашигладаг тохиргооны датаг зөвхөн нөөцлөх зорилгоор ашиглах ба хувилан тараах, бусад системд ашиглахыг хатуу хориглодог.

**1 Системд USB төхөөрөмж холбоно.**

USB төхөөрөмж асаагүй үед асаана.

**2 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**3 [Navigation]-г дарна.**

**4 [Other]-г дарна.**

**5 [Favorites]-г дарна.**

**6 [Import/Export]-г дарна.**

**7 [Export to USB]-г дарна.**

**8 Нууц үг оруулаад [Confirm PIN]-г дарна.**

- Хялбар таах боломжтой нууц үг (төрсөн өдөр зэрэг), эсвэл эсвэл өөр газар ашигладаг нууц үг ашиглахаас зайлсхийнэ.
- Бодит үг ашиглахаас зайлсхийнэ.

**9 Датаг экспортлох үед явцыг дэлгэцээр харуулж байгаа эсэхийг нягтлана.**

Тус функцийг цуцлах үед [**Cancel**]-г дарна.

**10 Үйлдэл дууссан үед баталгаажуулах дэлгэц гарна.**

> ⚠ **АНХААР**
>
> Дата экспортлох явцад USB төхөөрөмжийг салгаж болохгүй. USB төхөөрөмж гэмтэнэ.

### Холбоотой холбоосууд

Нууц үг тохируулах(Х. 113)

## USB төхөөрөмжөөс оруулах

Нөөцөлсөн санах ойн цэгүүдийг USB санах ой ашиглан навигацийн системд хийх боломжтой. Тус функцийг ашиглах үед USB санах ойг автомашинд холбох шаардлагатай.

**1 Системд USB төхөөрөмж холбоно.**

USB төхөөрөмж асаагүй үед асаана.

**2 Үндсэн цэсний []-г дарна.**

**3 [Navigation]-г дарна.**

**4 [Other]-г дарна.**

**5 [Favorites]-г дарна.**

**6 [Import/Export]-г дарна.**

**7 [Import from USB]-г дарна.**

**8 Нууц үг оруулаад [Confirm PIN]-г сонгоно.**

- Хялбар таах боломжтой нууц үг (төрсөн өдөр зэрэг), эсвэл өөр газар ашигладаг нууц үг ашиглахаас зайлсхийнэ.
- Бодит үг ашиглахаас зайлсхийнэ.

**9 Дата импортлогдох үед явцыг харуулж байгаа эсэхийг нягтлана.**

Тус функцийг цуцлах үед [**Cancel**]-г сонгоно.

**10 Үйлдэл дуусах үед баталгаажуулах дэлгэц гарна.**

**МЭДЭЭЛЭЛ**

- Газрын зургийн датагаас бусад газар байрлах тогтмол ашигладаг тохиргоог импортлох боломжгүй.
- 400 хүртэлх тогтмол ашигладаг тохиргоо бүртгэх боломжтой.
- Навигацийн системд адил нэртэй тогтмол ашигладаг тохиргоо байгаа үед навигацийн систем эдгээрийг импортлохгүй.

## Нууц үг тохируулах

Нууц үг тохируулсан үед тогтмол ашигладаг тохиргоог экспортлохоос гадна USB төхөөрөмжөөс навигацийн системд оруулах үед мөн нууц үг шаардана.

**1 Системд USB төхөөрөмж холбоно.**

USB төхөөрөмж асаагүй үед асаана.

**2 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**3 [Navigation]-г дарна.**

**4 [Other]-г дарна.**

**5 [Favorites]-г дарна.**

**6 [Import/Export].**

**7 [Set new PIN]-г дарна.**

**8 Нууц үг оруулаад [Set PIN]-г дарна.**

Өмнө нь тохируулсан нууц үг өөрчлөх үед нууц үгээ оруулаад [**Confirm PIN**]-г сонгоод шинэ нууц үг оруулна.

**9 Баталгаажуулах үүднээс нууц үг дахин оруулаад [Confirm PIN]-г дарна.**

- Нууц үгээ мартсан үед:
  - Хувийн мэдээллээ системээс [**System reset**]-г ашиглан устгах шаардлагатай.
  - Та өөрийн Lexus дилерт хандана уу.

**Холбоотой холбоосууд**

Аюулгүй байдлын тохиргоо өөрчлөх(Х. 94)

## Байршил/Чиглэлийн тохиргоо

Жолоодлогын үед GPS сигналаар одоогийн байршлын тэмдэг автоматаар шинэчлэгддэг. GPS сигнал сул газар одоогийн байршлын тэмдгийг гараар тохируулах боломжтой.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Navigation]-г дарна.**

3 **[Other]-г дарна.**

4 **[Position/Direction]-г дарна.**

5 **Газрын зургийг тохируулах цэг хүртэл гүйлгээд [OK]-г дарна.**

6 **Суман дээр дарж одоогийн байрлын тэмдгийн чиглэлийг тохируулаад [OK]-г дарна.**

## Дуу болон медиа тохиргоо өөрчлөх

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 [Sound & Media]-г дарна.**

**3 Хүссэн тохиргоогоо сонгоно.**




● [**Sound**] > [**Levels**]

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**Автомат дууны түвшин тохируулагч**] | Автомашины хурдад нийцүүлэн аудио дууны түвшинг автоматаар тохируулна. |

● [**Sound**] > [**Voice**]

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**System volume**] | Системийн зааварчилгааны дууны түвшинг тохируулна. |
| [**Navigation volume**] | Навигацийн системийн дуут зааварчилгааны дууны түвшин тохируулна. |
| [**Navigation during calls**] | Утсаар ярих үед навигацийн дуут зааварчилгаа яриан дундуур орох эсэх тохиргоог хийнэ. |
| [**Adaptive volume control**] | Хурдны замаар явах үед дуут зааварчилгааны дууны түвшинг автоматаар нэмнэ. |
| [**Driving assist volume**] | Жолоодлогод туслах системийн дууны түвшин тохируулна. |
| [**Auto reading**] | Автоматаар дуудаж унших функцийг асаах буюу унтраана. |

● [**Sound**] > [**Acoustic setting**]

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**Surround sound**] | А төрөл : Эргэн тойрноос дуу дуугаргана |

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**Surround sound**] | В төрөл : Эргэн тойрноос дуу дуугаргах үед [**2D**], гурван хэмжээст дууны чанарт тохируулах үед [**3D**]-г сонгоно. |

● [**Media**] > [**General**]

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**Display cover art**] | Дууны цомог зэргийн хавтасны зураг гаргана. |

● [**AM/FM**] > [**AM/FM**]

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**Station list**] | Радио станцийн жагсаалтын дараалдыг өөрчилнө. |
| [**FM traffic announcement**] *1 | FM радио станц замын хөдөлгөөний мэдээлэл цацах үед автоматаар тус радиог сонгоно. |
| [**FM alternative frequency**] *1 | FM радио станцийн дохио муудах үед долгион сайтай нөөц давтамж руу шилжүүлнэ. |
| [**Regional code change**] *1 | Адил программтай сүлжээний орон нутгийн дамжуулалт руу шилжинэ. |
| [**FM program type**] *1 | Программын төрлийг (PTY) харуулна. |
| [**FM radio text**] *1 | FM радио станцийн дамжуулж буй радио текст гаргана. |

● [**Internet radio**] *1

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**Enable internet radio**] | Радио долгион сулрах үед систем IP радиод шилжинэ. |
| [**Changing to IP stream**] | IP радиод шилжүүлэх үеийн тохиргоог өөрчлөх боломжтой.<br>• [**Auto**]-р тохируулсан үед автоматаар шилжинэ.<br>• [**By request**]-р тохируулсан үед шилжүүлэх үед мэдэгдэнэ. |
| [**Enhanced metadata/art work**] | Gracenote радио таних технологи ашиглана.<br>• Тогтмол ашигладаг станцийн лого болон станцийн жагсаалт гаргана. |

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**Enhanced metadata/art work**] | • Станцийн жагсаалтын категорийн нэр өөрчлөнө.<br>• Станцийн жагсаалтыг автоматаар шинэчилнэ. |

● [**DAB**] *1

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**Traffic announcement**] | DAB дээр замын хөдөлгөөний мэдээлэл дамжуулагдах үед станц автоматаар солино. |
| [**Alternative frequency**] *1 | DAB-н дохио муудах үед долгион сайтай нөөц давтамж руу шилжинэ. |
| [**Radio text**] | DAB-н радио текст гаргана. |

## МЭДЭЭЛЭЛ

Дуут зааварчилгааны дууны түвшинг тохируулах үед зааварчилгааны үед [**PWR·VOL**] товчийг эргүүлнэ.

## Дэлгэцийн горим солих

Энгийн болон өргөн дэлгэцийн видеонд солино.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Sources]-г дарна.**

3 **Дэлгэцийн горим солих эх үүсвэрийг товшино.**

4 **[ ]-г дарна.**

5 **[Screen]-г дарна.**

Тус товч нь видео горимд дэлгэцээр гарна.

6 **[Screen format]-г дарна.**

7 **Дэлгэцийн горим сонгоно.**




[**Normal**] : Видеог 4:3 харьцаагаар гаргана.

[**Stretched**] : Видеог дэлгэцний хэмжээнд тааруулан сунгана.

[**Zoomed**] : Видеог босоо болон хөндлөн чиглэлд адил харьцаагаар томруулна.

### МЭДЭЭЛЭЛ

- Видео горимоос хамаарч тохиргоо хийх боломжтой горим өөр байна.
- Эдгээр өөрчлөлтийг хувийн зорилгоор видео үзэх үед хийх боломжтой. Нөгөөтэйгүүр аливаа бизнесийн, эсвэл олон нийтэд үзүүлэх видеог шахах, сунгах нь зохиогчийн эрхийн хуулиар хамгаалагдсан зохиогчийн эрхийг зөрчинө.
- Видеог сонин харагдахаас сэргийлж видео гаргаж буй дэлгэц дээр хар зурвас гарч болно.

## Дүрсний чанар тохируулах

Дүрсний өнгөний ялгарал, гэрлийн түвшин тохируулна.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Sources]-г дарна.**

3 **Дүрсний чанар тохируулах эх үүсвэрийг сонгоно.**

4 **[ ]-г дарна.**

5 **[Screen]-г дарна.**

Тус товч видео горимд гарч ирнэ.

6 **[Display]-г дарна.**

7 **Тохиргоог хийнэ.**




"Brightness" : Гэрлийн түвшин тохируулна.

"Contrast" : Өнгөний ялгарал тохируулна.

## Эх үүсвэр тус бүрийн дууны түвшин тохируулах

Эх үүсвэр тус бүрийн дууны чанар, түвшин болон балансийг тохируулна.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Sources]-г дарна.**

3 **Дууны тохиргоо хийх эх үүсвэрийг сонгоно.**

4 **[ ]-г дарна.**

Эх үүсвэрээс хамаарч **6**-д шилжинэ.

5 **[Sound]-г дарна.**

6 **Тохиргоо тус бүрийг хийнэ.**




"Treble" : Дууны өндөр дуугаралтын түвшинг тохируулна.

"Mid" : Дууны дунд түвшний дуугаралтыг тохируулна.

"Bass" : Дууны нам дуугаралтын түвшинг тохируулна.

Fader and balance : [ ]-г хөдөлгөж дуугаралтыг урагш хойш, баруун зүүн тийш тохируулна.

Дуугаралтыг буцааж голлуулах үед [**Recenter**]-г дарна.

### МЭДЭЭЛЭЛ

Эх үүсвэр тус бүрт Treble, Mid болон Bass тохиргоог тус тусад нь хийнэ.

## Wi-Fi® тохиргоо өөрчлөх

Wi-Fi® тохиргоо өөрчлөнө.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **Дэд цэснээс [Data & Wi-Fi], эсвэл [Wi-Fi]-г дарна.**

3 **Тохиргоог хийнэ.**



● "Wi-Fi settings"

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**Wi-Fi**] | Wi-Fi® функцийг асааж унтраана. |

- Мултимедиа системийн тохиргооноос хамаарч дэлгэц дээр мэдээлэл гарна. Дэлгэцийн зааварчилгааг баримтлана.
- [**Wi-Fi**]-г асаах үед холбох боломжтой сүлжээг дэлгэцээр харуулна.
- [**Wi-Fi**]-г унтраах үед Wi-Fi® холболт салгагдана.

● "Available networks" ("Available networks" мэдээлэл [**Wi-Fi**] асаалттай үед дэлгэцээр гарна.)

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| Холбох сүлжээний нэр (Network SSID) | Товшиж тухайн сүлжээнд холбоно. |
| Сүлжээний дэлгэцийн нэр (Network SSID)[ ] | Сүлжээний мэдээллийн дэлгэц гаргана. |

- Нэг сүлжээг олон MAC хаяг хуваах ашиглаж байгаа үед сүлжээний нэр давхардаж гарч болно.
- 30 хүртэлх сүлжээг дэлгэцээр харуулах боломжтой ба 6 секунд тутамд шинэчлэгдэнэ.
- Адилхан сүлжээний нэр (SSID) ашиглаж байгаа өөр төхөөрөмж байгаа үед аль төхөөрөмжэтй холбохыг таних боломжгүй. Олон төхөөрөмж ашигладаг үед төхөөрөмж тус бүрт өөр сүлжээний нэр (Network SSIDs) өгнө.

● Сүлжээний мэдээллийн дэлгэц (Сүлжээний нэрний [ ]-г дарсан үед гарна.)

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**Auto connect**][*1] | Сүлжээ хайх үед автоматаар холбох тохиргоог асааж унтраана. |
| "Network SSID" | Дэлгэцийн нэр харуулна (SSID). |
| "MAC address" | Сүлжээний MAC хаяг харуулна. |
| "Security" | Сүлжээний аюулгүй байдлын протоколыг харуулна. |
| "Frequency band" | Сүлжээний давтамжийг харуулна. |
| [**Forget this network**][*1] | Мултимедиа системээс сонгосон сүлжээний холболтын түүхийг устгана.<br>Холбосон сүлжээг өмнө нь системд холбож байгаагүй систем гэж танина. |

- [**Forget this network**] нь одоогийн Wi-Fi® сүлжээний холболтыг таслахгүй. Сүлжээний мэдээлэл хадгалагдахгүй ба Wi-Fi® сүлжээг дахин асаах үед тухайн Wi-Fi® сүлжээнд систем дахин холбогдохгүй.

### МЭДЭЭЛЭЛ

- Сүлжээний холболтын 20 хүртэлх түүхийг хадгалах ба шинэ сүлжээ нэмэх үед хамгийн хуучин холболтын түүх устана.
- Сүлжээний аюулгүй байдал хангагдаагүй сүлжээг холболтын түүхэн дээр харуулахгүй.

## Холбоотой холбоосууд

Wi-Fi® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 150)

Wi-Fi® ашиглан сүлжээнд холбох (Х. 152)

*1 : Мултимедиа системд холбогдож байсан сүлжээг дэлгэцээр харуулна.

## Bluetooth® төхөөрөмж тохируулах

Мултимедиа системийн ашиглалт болон холбосон Bluetooth® төхөөрөмжийг тохируулах боломжтой.

### МЭДЭЭЛЭЛ

- Bluetooth® төхөөрөмж тус бүр дээр өөр тохиргоо хийгдэнэ.
- Bluetooth® аудио тоглуулах үед гарны оролцоогүй утас сонгосон үед дуу солигдож болно.
- Bluetooth® төхөөрөмжийн загвараас хамаарч Bluetooth® төхөөрөмж дээр үйлдэл хийх шаардлагатай байж болно.
- Яаралтай дуудлагын үед Bluetooth® төхөөрөмж сонгох боломжгүй.
- Жолоодлогын үед тохиргоо сонгох боломжгүй.
- Bluetooth® төхөөрөмжийн ажиллагааны байдлаас хамаарч сонгох боломжгүй байж болно.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 [Bluetooth & Devices]-г дарна.**

**3 Дэд цэснээс тухайн тохиргоо хийх Bluetooth® төхөөрөмж сонгоно.**

Нэг ч Bluetooth® төхөөрөмж бүртгэгдээгүй үед дэлгэц хоосон байна.

**4 Тохиргоо хийнэ.**




| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**Гар утсанд ашиглах**] | Гарны оролцоогүй утасны функцийг асааж унтраана.*1 |
| [**Медиад ашиглах**] | Аудио функцийг асааж унтраана.*1 |
| [**Apple CarPlay-д ашиглах**] | Apple CarPlay функцийг асааж унтраана.*1 |
| [**Android Auto-д ашиглах**] | Android Auto функцийг асааж унтраана.*1 |

● "Дууны түвшин"

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**Ringtone**] | Дуудлагын аяны дууны түвшин тохируулна. |
| [**Received volume**] | Ярианы дууны түвшинг тохируулна. |
| [**New message**] | Ирсэн мессежний аяны дууны түвшинг тохируулна.*2 |

● "Ерөнхий"

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**Ringtone**] | Гарны оролцоогүй утасны аяыг дараах байдлаар тохируулах боломжтой.<br>• Гар утсанд аяыг мултимедиа системийн утасны аяаар тохируулна.<br>• Байгаа аянаас сонгоно.<br>• Дуудлага ирэх үед залгасан хүний нэрийг систем дуудаж хэлэх тохиргоог хийнэ. |
| [**Message tone**] | Ирсэн мессежний аяыг дараах байдлаар тохируулах боломжтой.*2<br>• Байгаа аяаар тохируулах.<br>• Дууг хаах.<br>• Илгээгчийн нэрийг дуудаж унших. |
| [**Sort contacts by**] | Бүртгэлтэй холбоо барих хаягийг дараах байдлаар жагсаана.*2<br>• Илгээгчийн нэрний дарааллаар жагсаах.<br>• Илгээгчийн овгийн дарааллаар жагсаах. |
| [**Auto read messages**] | Мессеж автоматаар дуудаж унших функцийг идэвхжүүлнэ.*2 |
| [**Clear call history**] | Гарны оролцоогүй дуудлагын түүх устгана.*3 |

● "Синхрончлох"

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**Sync contacts**] | Хаяг, тогтмол ашигладаг хаяг, дуудлагын түүхийг мултимедиа системд автоматаар дамжуулах тохиргоог асааж унтраана.<br>Зарим загварын гар утас тогтмол ашигладаг хаяг дамжуулах боломжгүй байдаг. |

| Тохиргоо | Агуулга |
|---|---|
| [**Display contact images**] | Хаягны зургийг дэлгэцээр гаргах тохиргоог идэвхжүүлж цуцлана.*2<br>[**Sync contacts**]-г асаагаагүй үед зураг дамжуулах боломжгүй. |
| [**Set as secondary device**] | Тухайн төхөөрөмжийг хоёрдогч төхөөрөмжөөр холбоно.*4 |
| [**Remove secondary device setting**] | Тухайн төхөөрөмжийг хоёрдогч төхөөрөмж тохиргооноос салгана. |
| [**Connect**] | Мултимедиа систем болон Bluetooth® төхөөрөмжийг холбоно. |
| [**Disconnect**] | Мултимедиа системнээс Bluetooth® төхөөрөмж салгана. |
| [**Forget**] | Бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмжийн бүртгэл устгана. |





## Холбоотой холбоосууд

Bluetooth® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 134)

Bluetooth® техник үзүүлэлт ба дэмжих функцууд(Х. 137)

Гарны оролцоогүй дуудлага ашиглах үеийн анхааруулга(Х. 258)

Bluetooth® аудио тоглуулах анхааруулга (Х. 226)

Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга(Х. 155)

Bluetooth® төхөөрөмжийг үндсэн төхөөрөмжөөр бүртгэх(Х. 148)

Хоёрдогч төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 149)

Жолооч бүртгэх (Х. 73)

*1 : Зөвхөн Bluetooth® төхөөрөмж тус функцийг гүйцэтгэх боломжтой үед дэлгэцээр гарна. Товчийг асааж унтраах үед холбогдох функцийг дэлгэцээр гаргах болон нуух, эсвэл функцийг асааж унтраана. Apple CarPlay, эсвэл Android Auto-г асаасан үед тус функцаар гарны оролцоогүй дуудлага, эсвэл аудио ашиглах боломжгүй. Холболт эхлүүлэх үед [**Connect**] товч дарна.

*2 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

*3 : [**Sync contacts**] тохиргоог унтраасан гар утас холбох үед дэлгэцээр гарна.

*4 : Систем жолоочийг танисан ба гарны оролцоогүй утасны функцтай Bluetooth® төхөөрөмжийг үндсэн төхөөрөмжөөр тохируулсан үед тус функцийг ашиглах боломжтой.

Жолооч бүртгэх, бүртгэл өөрчлөх (Х. 80)

## Арын суудлын энтертейнмент системийн дэлгэцийн тохиргоо өөрчлөх*1

Арын суудлын энтертейнмент системийн дэлгэцийн өнгөний горим, гэрлийн түвшин болон өнгөний ялгарлыг өөрчлөнө.

**1 Дараах аль нэг үйлдлээр арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын олон үйлдэлт удирдлагын самбарын арын суудлын энтертейнмент системийн "Advanced" удирдлагын дэлгэцнээс [ ]-г сонгоно.

Арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэц гарна.

**2 [Display], эсвэл [Display (Common)]-г сонгоно.**

**3 Тохиргоог хийнэ.**




[**Synchronised**] : Дэлгэцийн өнгөний горимыг урд суудлын аудио системтэй холбох тохиргоог асааж унтраана. Асаасан үед арын суудлын дэлгэцний өнгөний горимд урд суудлын дэлгэцтэй адил байдлаар тохируулагдана.

[**Light**]/[**Dark**]*2 : Дэлгэцний өнгөний горим өөрчлөх.

[**Brightness**] : Тохиргоог гүйлгэж, эсвэл [**+**] болон [**-**] товч дарж тохируулна.

[**Contrast**] : Тохиргоог гүйлгэж, эсвэл [**+**] болон [**-**] товч дарж тохируулна.

*1 : Тоноглогдсон автомашинд

*2 : [**Synchronised**] тохиргоог асаасан үед дэлгэцээр гарахгүй.

## Арын суудлын энтертейнмент системээр гаргаж буй видео болон зургийн дүрсний чанар тохируулах

Видео, зурагны гэрлийн түвшин, өнгөний ялгарал, өнгийг тохируулах боломжтой. Тус тохиргоог арын суудлаас видео, зураг үзэх үед өөрчлөх боломжтой.

**1 Дараах аль нэг үйлдлээр арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [⚙]-г сонгоно.
- Арын олон үйлдэлт удирдлагын самбарын арын суудлын энтертейнмент системийн "Advanced" удирдлагын дэлгэцнээс [⚙]-г сонгоно.

Арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэц гарна.

**2 [Display (Video)]-г сонгоно.**

**3 Тохиргоог хийнэ.**




[**Brightness**] : Тохиргоог гүйлгэж, эсвэл [**+**] болон [**-**] товч дарж гэрлийн түвшинг өөрчлөнө.

[**Contrast**] : Тохиргоог гүйлгэж, эсвэл [**+**] болон [**-**] товч дарж өнгөний ялгарлыг өөрчлөнө.

[**Tone**] *1 : Тохиргоог гүйлгэж, эсвэл [**+**] болон [**-**]-г дарж өнгийг хүчтэй, бүдэг өнгө болгон өөрчлөнө.

[**Color**] *1 : Тохиргоог гүйлгэж, эсвэл [**R**] болон [**G**]-г дарж өнгө өөрчлөнө.

### МЭДЭЭЛЭЛ

Автомашины гэрэл ассан үед дараах хязгаарлалтууд үүсдэг:*2

- Зорчигчийн суудлыг хэт урагш байрлалд тохируулсан үед тус суудлыг дэлгэцний гэрлийн түвшинг үндсэн тохиргооны түвшнээс нэмэх боломжгүй*3.
- Зорчигчийн суудлын дэлгэцний гэрлийн түвшинг үндсэн тохиргооны түвшнээс өндөр тохируулсан нөхцөлд *3 тус суудлыг хэт урагш байрлалд тохируулах үед дэлгэцийн гэрлийн түвшин үндсэн түвшинд тохируулагдана.

*1 : Арын суудлын эх үүсвэрийг [**Rear-Miracast®**]-р сонгосон үед дэлгэцээр гарахгүй.

## Арын суудлын энтертейнмент системийн дэлгэцийн горим солих

Видео эх үүсвэр тоглуулах үед дэлгэцийн горим солино.

**1 Дараах аль нэг үйлдлээр арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын олон үйлдэлт удирдлагын самбарын арын суудлын энтертейнмент системийн "Advanced" удирдлагын дэлгэцнээс [ ]-г сонгоно.

Арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэц гарна.

**2 [Screen format]*1-г сонгоно.**

**3 Дэлгэцийн горим сонгоно.**

- Арын суудал USB-Video-с бусад эх үүсвэрт байгаа үед

[**Normal**] : Дэлгэцийг 4:3 харьцаагаар харуулна.

[**Stretched**] : Видеог дэлгэцийн хэмжээгээр томруулна.




- Арын суудлын эх үүсвэр USB-Video байгаа үед

[**Normal**] : Дэлгэцийг 4:3 харьцаагаар харуулна.

[**Stretched**] : Видеог дэлгэцийн хэмжээгээр томруулна.

[**Zoomed**] : Видеог босоо болон хөндлөн чиглэлд адил харьцаагаар томруулна.




*2 : 4 суудалтай загварын зөвхөн зорчигчийн тал

*3 : Суудлын байрлал тохируулах тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

*1 : Сонгосон эх үүсвэрээс хамаарч энэ нь дэлгэцээр гарахгүй байж болно.

## Арын суудлын энтертейнмент систем дээр арын суудлын HDMI тохиргоо өөрчлөх

Эх үүсвэрээр [**Rear-HDMI**]-г сонгосон байгааг урьдчилан шалгана.

**1 Дараах аль нэг үйлдлээр арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын олон үйлдэлт удирдлагын самбарын арын суудлын энтертейнмент системийн "Advanced" удирдлагын дэлгэцнээс [ ]-г сонгоно.

Арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэц гарна.

**2 [Rear-HDMI]-г сонгоно.**

**3 Тохиргоог хийнэ.**




[**HDMI удирдлага идэвхжүүлнэ**] *1 : Арын суудлын энтертейнмент систем систем ашиглан HDMI төхөөрөмжийн ажиллагааг асааж унтраана. Асаасан үед рын суудлын энтертейнмент системээс HDMI төхөөрөмж удирдах боломжтой болно.

[**One Touch Play**] *2 : Тус тохиргоо нь HDMI төхөөрөмж асаах үед арын суудлын энтертейнмент системийн эх үүсвэр солидог. Тохиргоог идэвхжүүлсэн нөхцөлд HDMI төхөөрөмж асаах үед арын суудлын энтертейнмент систем асч автоматаар [**Rear-HDMI**] эх үүсвэр сонгогдоно.

[**System Standby**] *2 : Тус тохиргоо нь HDMI төхөөрөмж унтраах үед арын суудлын энтертейнмент системийн эх үүсвэр солидог. Тохиргоог идэвхжүүлсэн нөхцөлд арын суудлын энтертейнмент системийн эх үүсвэрийг [**Rear-HDMI**]-с өөр эх үүсвэрт шилжүүлэх үед HDMI төхөөрөмж автоматаар унтарна.

[**Overscan**] : Дүрсний хүрээг гаргах overscan функцийг асааж унтраана. Тохиргоог асаасан үед видеоны хүрээ хэсэгт үүсэх дүрсний хэлбэр алдагдалтыг нууна. (Дүрсний зарим хэсгийг таслаж болно.)

Баруун болон зүүн дэлгэц дээр тусад нь гаргах боломжтой.

[**Reset settings**] : Бүх тохиргоог тэглэнэ.

*1 : Төхөөрөмжөөс хамаарч [**Enable HDMI control**]-г идэвхжүүлэх боломжгүй байх, эсвэл хэвийн ажиллахгүй байж болно.

## Холбоотой холбоосууд

Арын суудлын энтертейнмент системд HDMI төхөөрөмж холбох (7 суудалтай)(Х. 52)

Арын суудлын энтертейнмент системд HDMI төхөөрөмж холбох (4 суудалтай)(Х. 53)

Арын суудлын энтертейнмент системээр арын суудлын HDMI медиа тоглуулах(Х. 251)



*2 : [**Enable HDMI control**]-г унтраасан үед дэлгэцээр гарахгүй.

## Арын суудлын энтертейнмент системийн лицензийн мэдээлэл шалгах

1 **Дараах аль нэг үйлдлээр арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын олон үйлдэлт удирдлагын самбарын арын суудлын энтертейнмент системийн "Advanced" удирдлагын дэлгэцнээс [ ]-г сонгоно.

Арын суудлын энтертейнмент системийн тохиргооны дэлгэц гарна.

2 **[License information]-г сонгоно.**

Программ хангамжийн мэдээлэл дэлгэц дээр гарна.

# 3 Ухаалаг утас, эсвэл холбоо харилцааны төхөөрөмж холбох


3-1. Bluetooth® функц ашиглах

Bluetooth® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга ...... 134

Bluetooth® техник үзүүлэлт ба дэмжих функцууд ...... 137

Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмж бүртгэх ...... 139

Бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмж устгах ...... 143

Bluetooth® төхөөрөмжтэй холбох ...... 144

Bluetooth® төхөөрөмжийг үндсэн төхөөрөмжөөр бүртгэх ...... 148

Хоёрдогч төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулах ...... 149

3-2. Wi-Fi® сүлжээнд холбох

Wi-Fi® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга ...... 150

Wi-Fi® ашиглан сүлжээнд холбох ...... 152

3-3. Apple CarPlay болон Android Auto ашиглах

Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга ...... 155

Бүртгэлгүй ухаалаг утсаар Apple CarPlay ашиглах ...... 158

Бүртгэгдсэн утсаар Apple CarPlay ашиглах ...... 161

Android Auto ашиглах ...... 164

Apple CarPlay, эсвэл Android Auto доголдсон үед ...... 166

## Bluetooth® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга

Мултимедиа системд Bluetooth® төхөөрөмж ашиглах үед дараах мэдээлэлд онцгой анхаарна.

### МЭДЭЭЛЭЛ

- Bluetooth® нь 2.4 GHz үелзлээр утасгүй холболт үүсгэх функц юм.
- Адилхан 2.4 GHz үелзэл ашигладаг Wi-Fi®-г Bluetooth®-тэй зэрэг ашиглах үед холболтууд нөгөө холболтондоо саад учруулна.
- Bluetooth® болон Wi-Fi® холболт хоорондоо саад учруулах нь видео дүрс сарних, аудио үсрэх, эсвэл холболтын хурд буурахад хүргэнэ.

  Bluetooth® төхөөрөмж холбосон үед саад учруулалт буурна. Bluetooth® төхөөрөмж бүртгэгдсэн үед бүртгэлтэй төхөөрөмжтэй холбох нь саад учруулалтыг бууруулна. (Мултимедиа системийн дэлгэцний тэмдгээр Bluetooth® төхөөрөмжийг шалгах боломжтой.)
- Bluetooth® гар утсыг бусад утасгүй холболтын төхөөрөмжтэй зэрэг ашиглах нь нөгөө төхөөрөмжийн холболтод сөрөг нөлөө үзүүлнэ.
- Apple CarPlay-г утасгүй холболтоор мултимедиа системд холбосон үед Bluetooth® функц ашиглах боломжгүй*1.
- Wi-Fi® функц (Wi-Fi® болон Miracast®) нь адилхан 2.4 GHz үелзлээр утасгүй холболт үүсгэдэг. Bluetooth® төхөөрөмж зэрэг холбох нь холболтууд хоорондоо саад учруулна. Wi-Fi® функц унтраасан үед холболтод саад үүсэхгүй.
- Bluetooth® төхөөрөмжийг Bluetooth®-р холбосон үед хэвийн үеэс илүү зайны цэнэг хурдан буурна.
- Bluetooth® холболт яаралтай дуудлагын үед салгагдана. Яаралтай дуудлага дуусах үед Bluetooth® төхөөрөмжийн холболт дахин сэргэнэ.

### ⚠ АЮУЛТАЙ

- Аюулгүйн үүднээс гарны оролцоогүй дуудлага хийнгээ жолоодох үедээ жолооч гар утсыг шууд удирдаж болохгүй.
- Дуудлага хийхийн өмнө аюулгүй газар зогсоно. Жолоодлогын үед дуудлага ирсэн нөхцөлд жолоодлогын аюулгүй байдлыг хангангаа богино ярина.

### ⚠ АНХААР

- Мултимедиа системд Bluetooth® төхөөрөмж хэт ойрхон ашиглаж болохгүй. Хэт ойртуулсан үед дууны чанар, холболт муудахад хүргэнэ.

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

**⚠ АНХААР**

- Автомашины бүхээгт гар утас үлдээж болохгүй. Бүхээгний хэм хэт өндөр болсон үед гар утсанд доголдол үүсгэх аюултай.

## ■ Пэйсмейкер, бусад эмчилгээний электрон төхөөрөмжтэй хамт ашиглах

Bluetooth® холболтын үед радио долгионтой холбоотой дараах зүйлсийг анхаарна.

**▲ АЮУЛТАЙ**

- Автомашины Bluetooth® холболтын антенн урд удирдлагын самбарын төв хэсэгт байрладаг.
- Дотуур суулгасан зүрхний пэйсмейкер, зүрхний ажиллагааг дахин синхрончлох эмчилгээний пэйсмейкер, эсвэл дефибриллятор суулгац эмчилгээтэй хүн Bluetooth® антеннаас зайтай сууна. Радио долгион эдгээр эмчилгээний төхөөрөмжид нөлөөлөх аюултай.
- Дотуур суулгасан зүрхний пэйсмейкер, зүрхний ажиллагааг дахин синхрончлох эмчилгээний пэйсмейкер, эсвэл дефибриллятор суулгац эмчилгээнээс бусад төрлийн эмчилгээний электрон төхөөрөмжтэй хүн Bluetooth® төхөөрөмж ашиглахын өмнө радио долгионы учруулах нөлөөг эмчилгээний төхөөрөмж үйлдвэрлэгчээс тодруулна уу. Радио долгион нь эдгээр төхөөрөмжинд урьдчилан мэдэх боломжгүй нөлөөтэй байж болно.

## ■ Bluetooth® аудиотой зэрэг ашигласан үед

- Bluetooth® дэмждэг төхөөрөмжийг (гар утас) гарны оролцоогүй дуудлага хийх зорилгоор Bluetooth® аудиотой зэрэг холбосон үед дараах нөхцлүүд үүсч болно.
  - Гар утасны Bluetooth® холболт салгагдаж болно.
  - Гарны оролцоогүй дуудлагын үед аудионд шуугиан үүсч болно.
  - Гарны оролцоогүй дуудлагын үйлдэл хоцрогдолтой байж болно.
- Bluetooth® аудио тоглуулах үед гарны оролцоогүй дуудлагад ашиглах төхөөрөмжийг өөр төхөөрөмжөөр солисон үед аудио дууг алгасч болно.
- Холбоо барих хаяг дамжуулах үед зөөврийн төхөөрөмжийн холболт салгагдаж болно. Хаяг дамжуулалт дуусах үед холболт сэргэнэ. (Зарим загварт холболт дахин автоматаар хийгдэхгүй байж болно)

- Гар утас гарны оролцоогүй дуудлага болон аудио холболтыг зэрэг дэмждэг байсан ч эдгээр функцуудыг зэрэг ашиглах боломжгүй байж болно.
- Системтэй холбож ашиглах боломжтой төхөөрөмжийн жагсаалтыг та өөрийн Lexus дилерээс тодруулна уу.

### Холбоотой холбоосууд

Wi-Fi® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 150)

Bluetooth® аудио тоглуулах анхааруулга (Х. 226)

Гарны оролцоогүй дуудлага ашиглах үеийн анхааруулга(Х. 258)

Miracast® тоглуулах үеийн анхааруулга (Х. 231)

Статусын тэмдэг(Х. 22)

## Bluetooth® техник үзүүлэлт ба дэмжих функцууд

Мултимедиа систем нь дараах техник үзүүлэлттэй төхөөрөмжийг дэмжинэ. Бүх Bluetooth® төхөөрөмжийг дэмжихгүй.

▶ А төрөл

### Дэмжих Bluetooth® техник үзүүлэлт

Bluetooth® үндсэн техник үзүүлэлт Ver. 2.1-с хойших

### Дэмжих функцууд

- HFP (Hands Free Profile) Дэмжих хувилбарууд: Ver. 1.5-с хойших

  Гар утас ашиглан гарны оролцоогүй дуудлага хийх боломж бүрдүүлнэ. Дуудлага хийх, хүлээн авах функцтай.
- PBAP (Phone Book Access Profile) Дэмжих хувилбарууд: Ver. 1.0-с хойших

  Холбоо барих хаяг, дуудлагын түүх зэрэг мэдээллийг синхрончлоно
- OPP (Object Push Profile) Дэмжих хувилбарууд: Ver. 1.1-с хойших

  Холбоо барих хаягийг дамжуулна
- MAP (Message Access Profile)*1 Дэмжих хувилбарууд: Ver. 1.2-с хойших

  Утасны мессежний функц ашиглана.
- SPP (Serial Port Profile) Дэмжих хувилбарууд: Ver. 1.1-с хойших
  - Bluetooth®-тэй төхөөрөмжийг виртуал цуврал порт болгож хувиргана
  - Ухаалаг утас холбоно
- A2DP (Advanced Audio Distribution Profile) Дэмждэг хувилбарууд: Ver. 1.0-с хойших

  Стерео аудио, өндөр чанарын дууг аудио системд дамжуулна.
- AVRCP (Audio/Video Remote Control Profile) Дэмждэг хувилбарууд: Ver. 1.0-с хойших

  Аудио системийг зайнаас удирдана

▶ В төрөл

### Дэмждэг Bluetooth® specifications

Bluetooth® үндсэн техник үзүүлэлт Ver. 5.0-с хойших

### Дэмжих функцууд

- HFP (Hands Free Profile) Дэмжих хувилбарууд: Ver. 1.7.1-с хойших

  Гар утас ашиглан гарны оролцоогүй дуудлага хийх боломж бүрдүүлнэ. Дуудлага хийх, хүлээн авах функцтай.

- PBAP (Phone Book Access Profile) Дэмжих хувилбарууд: Ver. 1.2.1-с хойших

  Холбоо барих хаяг, дуудлагын түүх зэрэг мэдээллийг синхрончлоно
- OPP (Object Push Profile) Дэмжих хувилбарууд: Ver. 1.2.1-с хойших

  Холбоо барих хаягийг дамжуулна
- MAP (Message Access Profile)*1 Дэмжих хувилбарууд: Ver. 1.4-с хойших

  Утасны мессежний функц ашиглана.
- SPP (Serial Port Profile) Дэмжих хувилбарууд: Ver. 1.2-с хойших
  - Bluetooth®-тэй төхөөрөмжийг виртуал цуврал порт болгож хувиргана
  - Ухаалаг утас холбоно
- A2DP (Advanced Audio Distribution Profile) Дэмждэг хувилбарууд: Ver. 1.3.1-с хойших

  Стерео аудио, өндөр чанарын дууг аудио системд дамжуулна.
- AVRCP (Audio/Video Remote Control Profile) Дэмждэг хувилбарууд: Ver. 1.6.1-с хойших

  Аудио системийг зайнаас удирдана

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

## Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмж бүртгэх

Гарны оролцоогүй утас ашиглах, эсвэл Bluetooth® аудио тоглуулах үед гар утас, зөөврийн төхөөрөмжийг бүртгэх шаардлагатай. Бүртгэл дууссан үед Bluetooth® автоматаар мултимедиа систем асаах бүрт холбогдоно.

Apple CarPlay/Android Auto төхөөрөмж USB-р холбогдсон үед төхөөрөмжийн бүртгэл автоматаар хийгдэнэ.

Bluetooth® төхөөрөмж холбогдоогүй үед жолооны хүрдний [ ] товчийг удаан дарж бүртгэлийн дэлгэц гаргах боломжтой.

### МЭДЭЭЛЭЛ

- Гар утсыг гарны оролцоогүй утас болон Bluetooth® аудио төхөөрөмжөөр зэрэг бүртгэх боломжтой.
- Тав хүртэлх Bluetooth® төхөөрөмж бүртгэх боломжтой ба үүнээс 2 хүртэлх гар утсыг гарны оролцоогүй утсаар ашиглах боломжтой. (Гарны оролцоогүй 2 утас холбох үед жолооч таниулах шаардлагатай.)
- Bluetooth® төхөөрөмжийг хэрхэн удирдах тухай мэдээллийг Bluetooth® төхөөрөмжийн гарын авлагаас харна уу.
- Олон Bluetooth® төхөөрөмж ашиглах үед Bluetooth® төхөөрөмж тус бүрийг бүртгэх шаардлагатай.
- Мултимедиа системд Bluetooth® төхөөрөмж бүртгэх үед пин кодоор баталгаажуулна.
- Гар утасны тохиргооноос хамаарч холболтын дараа дуудлага хийх үйлдэл түгжигдсэн байж болно. Гар утас ашиглахын өмнө автоматаар түгжих функцийг тайлна.
- Хэрэв гар утас эсвэл зөөврийн төхөөрөмжид холбогдсон үед өөр төхөөрөмж бүртгэгдсэн бол зөөврийн төхөөрөмж эсвэл аудио тоглуулж буй гар утасны холболт тасарна.
- Miracast® ашиглах үед өөр Bluetooth® төхөөрөмж бүртгэгдсэн нөхцөлд Miracast® аудионы дуу дараагийн дуунд шилжиж болно.
- Аюулгүйн үүднээс жолоодлогын үед төхөөрөмж бүртгэх боломжгүй.
- Bluetooth® төхөөрөмж бүртгэж болохгүй үед Bluetooth® төхөөрөмжийг дахин асаана.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 [Bluetooth & Devices]-г дарна.**

**3 [Manage devices]-г дарна.**

**4 [Add another device]-г дарна.**

- Төхөөрөмж бүртгэгдээгүй үед **5** үйлдэл рүү шилжинэ.

● Мултимедиа системд төхөөрөмж холбогдсон үед төхөөрөмжийг салгах баталгаажуулах дэлгэц гарч ирж болно. Бүртгэлийг хийхийн тулд төхөөрөмжийг салгана.

**5 [If not found]-г дарна.**




**6 Үндсэн хэсэг дээрээс бүртгэх төхөөрөмжийг товшино.**

● Төхөөрөмжийн нэрний оронд Bluetooth® хаяг гарч болно.

● Үндсэн хэсэг дээр бүртгэх төхөөрөмж гарч ирэхгүй үед Bluetooth® төхөөрөмжөөс бүртгэл хийх үйлдэл хийнэ.

● Зарим загварын Bluetooth® төхөөрөмж нь Bluetooth® төхөөрөмжийн дэлгэц дээр сонголт гарах хүртэл төхөөрөмжийн жагсаалт дээр гардаггүй. Дэлгэрэнгүйг Bluetooth® төхөөрөмжийн гарын авлагаас харна уу.

**7 Дэлгэц дэх пин код Bluetooth® төхөөрөмжийн пин кодтой таарч байгааг нягтлаад [OK] дарна.**

● Зарим Bluetooth® төхөөрөмж дээр бүртгэлийг дуусгах үед үйлдэл хийх шаардлагатай байдаг.

● Хэрэглэгчийн профайл бүртгэх зааавар дэлгэцээр гарч болно. дэлгэцийг зааврыг баримтлана.

● Үндсэн төхөөрөмжийн тохиргоо дэлгэцээр гарч болно. Дэлгэцийн зааврыг баримтлана.

● Apple CarPlay-н тохиргоо дэлгэцээр гарч болно. Тохиргоог идэвхжүүлсэн үед Apple CarPlay-н дэлгэц гарна.

● Холболт амжилттай болсныг илтгэх мэдээлэл гарч дэд цэсэн дээр бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмжийн нэр гарна.

● Үйлдэл амжилтгүй болсныг илэрхийлэх мэдээлэл гарсан үед дэлгэцийн зааврыг дагана.

### Холбоотой холбоосууд

Жолооч бүртгэх (Х. 73)

Жолооч бүртгэх, бүртгэл өөрчлөх (Х. 80)

Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга(Х. 155)

## Bluetooth® төхөөрөмжөөс бүртгэх

Мултимедиа системээс хайлт хийх үед Bluetooth® төхөөрөмж гарч ирэхгүй байгаа нөхцөлд мултимедиа системийг Bluetooth® төхөөрөмжөөс хайж болно.

**1 Үндсэн цэсний [⚙]-г дарна.**

**2 [Bluetooth & Devices]-г дарна.**

**3 [Manage devices]-г дарна.**

**4 [Add another device]-г дарна.**

- Төхөөрөмж бүртгэгдээгүй үед **5** үйлдлийг хийнэ.
- Өөр төхөөрөмж мултимедиа системд холбогдох үед төхөөрөмжийг салгах үйлдлийг баталгаажуулах дэлгэц гарч болно. Төхөөрөмжийг салгаж бүртгэлийг үргэлжлүүлнэ.

**5 Ашиглах Bluetooth® төхөөрөмж дээр мултимедиа системийг бүртгэнэ.**




- Үйлдлийг холбосон Bluetooth® төхөөрөмжийн ашиглах дарааллаар хийнэ.
- Bluetooth® төхөөрөмж бүртгэхээс өмнө тус Bluetooth® холболтын дэлгэцийг гаргана.

**6 Дэлгэц болон Bluetooth® төхөөрөмжийн пин код адил байгааг нягтлаад [OK]-г дарна.**

- Зарим Bluetooth® төхөөрөмж дээр нэмэлт үйлдэл хийх шаардлагатай байж болно.
- Хэрэглэгчийн профайл бүртгэх зааварчилгаа гарч болно. Зааварчилгааг баримтлана.
- Үндсэн төхөөрөмжийн тохиргоо дэлгэцээр гарч болно. Дэлгэцийн зааврыг баримтлана.
- Apple CarPlay-н тохиргоо дэлгэцээр гарч болно. Идэвхжүүлсэн үед Apple CarPlay-н дэлгэц гарна.
- Холболт хийгдсэнийг илтгэх мессеж дэлгэцээр гарч бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмжийн нэр дэд цэсэн дээр гарна.
- Үйлдэл амжилтгүй болсныг илтгэх мэдээлэл дэлгэцээр гарсан үед дэлгэцийн зааварчилгааг дагана.

### Холбоотой холбоосууд

Жолооч бүртгэх (Х. 73)

Жолооч бүртгэх, бүртгэл өөрчлөх (Х. 80)

Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга(Х. 155)

## Бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмж устгах

Бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмж устгах боломжтой.

**1 Үндсэн цэсний []-г дарна.**

**2 [Bluetooth & Devices]-г дарна.**

**3 Дэд цэснээс устгах Bluetooth®-г дарна.**




**4 [Forget]-г дарна.**

Өөр хэрэглэгчийн үндсэн төхөөрөмжөөр бүртгэсэн төхөөрөмжийг устгах боломжгүй.

**5 [Forget]-г дарна.**

### МЭДЭЭЛЭЛ

- Яаралтай дуудлагын үед бүртгэгдсэн гар утас устгах боломжгүй.
- Bluetooth® төхөөрөмжийн статусаас хамаарч анхны оролдлогоор устгах боломжгүй байж болно.

### Холбоотой холбоосууд

Bluetooth® төхөөрөмжийг үндсэн төхөөрөмжөөр бүртгэх(Х. 148)

Жолооч бүртгэх (Х. 73)

Жолооч бүртгэх, бүртгэл өөрчлөх (Х. 80)

## Bluetooth® төхөөрөмжтэй холбох

Мултимедиа системийн олон төрлийн функц ашиглах үед Bluetooth®төхөөрөмжтэй холбох шаардлагатай. Автомат болон гараар холбох холболтын 2 арга байдаг.

### МЭДЭЭЛЭЛ

- Bluetooth® төхөөрөмж хэрхэн холбож ашиглах талаар Bluetooth® төхөөрөмжийн гарын авлагаас харна уу.
- Гар утас холбоход холболт тогтворгүй үед дуудлагыг салгаад дахин холбоно.
- Bluetooth® төхөөрөмжийн Bluetooth®-г асаагаагүй үед төхөөрөмж холбох боломжгүй.
- Bluetooth® төхөөрөмж холбогдсон үед дэлгэцийн дээд талд гарна.
- Bluetooth® төхөөрөмж холбогдсон үед Bluetooth® холболтын статусын тэмдэг гарна.
- Гар утасны загвараас хамаарч хөдөлгүүрийн асаах товч асаалттай байгаа үед утасны дэлгэц үргэлжлэн асч болно. Энэ нөхцөлд утасны дэлгэц унтраана. (Тохиргооны тухай ухаалаг утасны гарын авлагаас харна уу)
- Apple CarPlay-р холбогдсон төхөөрөмжийн Bluetooth® функцийг ашиглах боломжгүй.
- Android Auto-р холбосон төхөөрөмжийн гарны оролцоогүй утаснаас бусад Bluetooth® функцийг ашиглах боломжгүй.
- Miracast® ашиглаж байгаа нөхцөлд Bluetooth® төхөөрөмж холбосон үед Miracast® аудио дараагийн дуунд шилжиж болно.

### ■ Bluetooth® дахин холбох

Асаах товчны On горимд холбогдсон Bluetooth® холболт салсан үед дахин холбох функц автоматаар дахин холбох оролдлого хийнэ.

### ■ Холбогдох боломжтой Bluetooth® төхөөрөмжийн тоо

- Жолооч танисан үед

  2 хүртэлх гарны оролцоогүй утас болон 1 аудио төхөөрөмж автоматаар холбогдох боломжтой. (Гарны оролцоогүй утас болон аудио төхөөрөмжийг нэг төхөөрөмжөөр тохируулж болно.)

- Жолооч таниагүй үед

  1 хүртэлх гарны оролцоогүй утас болон 1 аудио төхөөрөмж автоматаар холбогдох боломжтой. (Гарны оролцоогүй утас болон аудио төхөөрөмжийг нэг төхөөрөмжөөр тохируулж болно.)

### МЭДЭЭЛЭЛ

- Дахин холболт амжилтгүй болсон үед гараар холбох оролдлого хийнэ.
- Төхөөрөмж Apple CarPlay төхөөрөмжөөр холбогдсон үед Bluetooth® төхөөрөмжөөр дахин холбох боломжгүй байж болно.

#### Холбоотой холбоосууд

Статусын тэмдэг(Х. 22)
Жолооч бүртгэх (Х. 73)
Жолооч бүртгэх, бүртгэл өөрчлөх (Х. 80)
Bluetooth® төхөөрөмж гараар холбох(Х. 146)

## Автоматаар Bluetooth® төхөөрөмж холбох

Мултимедиа систем автоматаар Bluetooth® төхөөрөмжтэй асаах товч унтраагаад асаах бүрт өмнө нь тохируулсан дарааллын дагуу холбогдоно.

- Жолооч танисан үед

  Үндсэн төхөөрөмж, хоёрдогч төхөөрөмжийн дарааллаар автоматаар холбогдох ба үргэлжлээд хамгийн сүүлд холбогдсон дарааллаар холбогдоно.

  2 хүртэл гарны оролцоогүй утас болон 1 аудио төхөөрөмж автоматаар холбогдоно. (Гарны оролцоогүй утас болон аудио төхөөрөмжийг нэг төхөөрөмжөөр бүртгэх боломжтой.)

- Жолооч таниагүй үед

  Хамгийн сүүлд холбогдсон дарааллаар холбогдоно.

  1 хүртэл гарны оролцоогүй утас болон 1 аудио төхөөрөмж автоматаар холбогдоно. (Гарны оролцоогүй утас болон аудио төхөөрөмжийг нэг төхөөрөмжөөр бүртгэх боломжтой.)

Дахин холбох үйлдэл амжилтгүй болсон нөхцөлд гар аргаар дахин оролдоно.

### МЭДЭЭЛЭЛ

Bluetooth® төхөөрөмжийн загвараас хамаарч Bluetooth® төхөөрөмжийг удирдах шаардлагатай байж болно.

#### Холбоотой холбоосууд

Bluetooth® төхөөрөмжийг үндсэн төхөөрөмжөөр бүртгэх(Х. 148)
Хоёрдогч төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 149)

Жолооч бүртгэх (Х. 73)

Жолооч бүртгэх, бүртгэл өөрчлөх (Х. 80)

## Bluetooth® төхөөрөмж гараар холбох

Өөр Bluetooth® төхөөрөмж холбох, эсвэл автомат холболт амжилтгүй болсон үед бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмж холбох боломжтой.

1 **Үндсэн цэсний -г дарна.**

2 **Дэд цэснээс [Bluetooth & Devices]-г сонгоно.**

Мултимедиа системд Bluetooth® төхөөрөмж бүртгэгдээгүй үед төхөөрөмж хайх дэлгэц гарна. Bluetooth® төхөөрөмж бүртгэнэ.

3 **Дэд цэснээс холбох Bluetooth® төхөөрөмж сонгоно.**

Холбох гэж буй Bluetooth® төхөөрөмж дэд цэсний жагсаалтад гарч ирэхгүй үед Bluetooth® төхөөрөмж бүртгэнэ.

4 **Үндсэн хэсгээс [Connect]-г дарна.**

Өөр төхөөрөмж холбогдсон байгаа үед баталгаажуулах дэлгэц гарна.




### МЭДЭЭЛЭЛ

Төхөөрөмжийн статусаас хамаарч анхны оролдлогоор Bluetooth® төхөөрөмж холбогдохгүй байж болно. Энэ нөхцөлд хэсэг хугацааны дараа дахин холбоно.

### Холбоотой холбоосууд

Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмж бүртгэх(Х. 139)

## Bluetooth® төхөөрөмж салгах

Холбогдсон Bluetooth® төхөөрөмжийг мултимедиа системээс салгах боломжтой.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **Дэд цэснээс [Bluetooth & Devices]-г дарна.**

3 **Дэд цэснээс салгах гэж буй Bluetooth® төхөөрөмжийг дарна.**

**4 Үндсэн хэсгээс [Disconnect]-г дарна.**



## Bluetooth® төхөөрөмжийг үндсэн төхөөрөмжөөр бүртгэх

Bluetooth® төхөөрөмжийг үндсэн төхөөрөмжөөр бүртгэн автомат холболтын үед эхэлж холбох төхөөрөмжийг сонгоно.

- Мултимедиа системд HFP дэмждэг Bluetooth® төхөөрөмж холбох шаардлагатай.
- Үндсэн төхөөрөмж бүртгэхээс өмнө жолооч бүртгэсэн байх шаардлагатай.

**МЭДЭЭЛЭЛ**

Өөр хэрэглэгчийн үндсэн төхөөрөмжөөр бүртгэсэн Bluetooth® төхөөрөмжийг үндсэн төхөөрөмжөөр бүртгэх боломжгүй.

1 **Үндсэн цэсний [⚙]-г дэд цэснээс сонгоно.**

2 **[Personal info]-г дарна.**

3 **Үндсэн хэсгээс [Link devices], эсвэл [Change link devices]-г дарна.**




Үндсэн төхөөрөмжөөр бүртгэх боломжтой Bluetooth® төхөөрөмж байхгүй үед төхөөрөмж хайх дэлгэц гарна. Bluetooth® төхөөрөмж хайж шинээр мултимедиа системд бүртгэнэ. Шинээр бүртгэсний дараа үндсэн төхөөрөмжөөр бүртгэх боломжтой.

4 **Үндсэн төхөөрөмжөөр тохируулах Bluetooth® төхөөрөмж сонгоно.**

Одоо холбогдсон Bluetooth® төхөөрөмжийг салгаад үндсэн төхөөрөмжийг холбосны дараа тус төхөөрөмжийг хоёрдогч төхөөрөмжөөр холбоно.

### Холбоотой холбоосууд

Автоматаар Bluetooth® төхөөрөмж холбох(Х. 145)

Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 123)

Жолооч бүртгэх (Х. 73)

Жолооч бүртгэх, бүртгэл өөрчлөх (Х. 80)

Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмж бүртгэх(Х. 139)

## Хоёрдогч төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулах

Хоёрдогч төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулсан нөхцөлд холболтын үед систем тус төхөөрөмжийг хоёрдогч төхөөрөмжөөр танина.

- Тус тохиргоог жолооч танигдсан ба тухайн тохируулах гэж буй Bluetooth® төхөөрөмжийг үндсэн төхөөрөмжөөр бүртгээгүй үед хийх боломжтой.
- HFP дэмждэг Bluetooth® төхөөрөмж мултимедиа системд холбогдсон байх шаардлагатай.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 Дэд цэснээс [Bluetooth & Devices]-г дарна.**

Bluetooth® төхөөрөмж бүртгэгдээгүй үед төхөөрөмж хайх дэлгэц гарна. Bluetooth® төхөөрөмж бүртгэнэ.

**3 Bluetooth® төхөөрөмж дээр дарж хоёрдогч төхөөрөмжөөр сонгоно.**

Жагсаалт дээр тохируулах Bluetooth® төхөөрөмж байхгүй үед Bluetooth® төхөөрөмж бүртгэнэ.

**4 Үндсэн хэсгээс [Set as secondary device]-г дарна.**

Тус төхөөрөмжийг урьд нь хоёрдогч төхөөрөмжөөр бүртгэсэн үед тус сонголт нь тохиргоог цуцлах товч болж өөрчлөгдөнө.




### Холбоотой холбоосууд

Автоматаар Bluetooth® төхөөрөмж холбох(Х. 145)

Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 123)

Жолооч бүртгэх (Х. 73)

Жолооч бүртгэх, бүртгэл өөрчлөх (Х. 80)

## Wi-Fi® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга

Мултимедиа системийн Wi-Fi® ашиглах үед дараах мэдээлэлд анхаарал хандуулна.

### ■ Пэйсмейкер, бусад эмчилгээний электрон төхөөрөмжтэй хүн

Wi-Fi® холболтын үед радио долгионы дараах нөлөөллийг анхаарна.

**⚠ АЮУЛТАЙ**

- Wi-Fi® төхөөрөмжийг зөвхөн аюулгүй, мөн хууль эрхзүйн хувьд ашиглах нь зөвшөөрөгдсөн үед ашиглана.
- Автомашины Wi-Fi® антенн хөгжимний ард байрладаг.
- Дотуур суулгасан зүрхний пэйсмейкер, зүрхний ажиллагааг дахин синхрончлох эмчилгээний пэйсмейкер, эсвэл дефибриллятор суулгац эмчилгээтэй хүн Wi-Fi® антеннаас аюулгүй зайнд сууна.

  Радио долгион нь эдгээр төхөөрөмжийн ажиллагаанд нөлөөлөх аюултай.
- Wi-Fi® төхөөрөмж ашиглах үед дотуур суулгасан зүрхний пэйсмейкер, зүрхний ажиллагааг дахин синхрончлох эмчилгээний пэйсмейкер, эсвэл дефибриллятор суулгац эмчилгээнээс бусад эмчилгээний электрон төхөөрөмжтэй хүн төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс радио долгионы төхөөрөмжийн ажиллагаанд учруулах нөлөөг тодруулна.

  Радио долгион нь эдгээр төхөөрөмжийн ажиллагаанд урьдчилан мэдэх боломжгүй нөлөөтэй байж болно.

### ■ Wi-Fi® болон Bluetooth® зэрэг ашиглах

Wi-Fi® нь 2.4 GHz үелзлээр утасгүй холболт үүсгэх функц болно. Адилхан 2.4 GHz үелзлээр утасгүй холболт үүсгэх Bluetooth® ашиглах нь Wi-Fi® болон бусад холболтууд хоорондоо саад учруулахад хүргэнэ.

### ■ Wi-Fi®-н талаар мэдэх шаардлагатай зүйлс

**МЭДЭЭЛЭЛ**

- Wi-Fi®, Miracast®, Wi-Fi Direct® болон WMM® нь Wi-Fi Alliance®-д бүртгэлтэй барааны тэмдэгт болно.
- Wi-Fi Protected Setup™, Wi-Fi CERTIFIED™, WPA™, WPA2™ болон WPA3™ нь Wi-Fi Alliance®-д бүртгэлтэй барааны тэмдэгт болно.
- Тус функц нь боломжит дээд хурдаар холболт үүсгэх функц юм.

- Тус функцыг зөөврийн төхөөрөмж холбох үед ашиглана. Тухайн орчноос хамаарч зөөврийн төхөөрөмжөөс бусад төхөөрөмжийн холболт салж болно.
- Wi-Fi®-тай бүсээс гарсан үед холболт сална.
- Автомашин радио антенн, радио станц, эсвэл хүчтэй радио долгион болон электрон шум үүсгэдэг газрын ойр орчимд байгаа үед холболтын хурд удаашрах, эсвэл холболт хийх боломжгүй болж болно.
- Ашиглалтын тодорхой нөхцлөөс хамаарч холболтын хурд удаашрах, эсвэл холболт хийх боломжгүй болж болно (утасгүй антенны байрлал, мөн ойр байрлах утасгүй төхөөрөмж зэрэг).

**Дэмждэг Wi-Fi® холболтын протокол**

IEEE 802.11b/g/n (2.4GHz)

**Дэмждэг мэдээллийн аюулгүй байдлын протокол**

- WEP
- WPA™
- WPA2™
- WPA3™

## Холбоотой холбоосууд

Miracast® тоглуулах үеийн анхааруулга (Х. 231)

Bluetooth® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 134)

Статусын тэмдэг(Х. 22)

Wi-Fi® тохиргоо өөрчлөх(Х. 121)

Веб хөтчийн функцийн тухай (интернет)(Х. 298)

## Wi-Fi® ашиглан сүлжээнд холбох

Мултимедиа системийг Wi-Fi® сүлжээ ашиглан интернетэд холбох боломжтой.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

**МЭДЭЭЛЭЛ**

- Сүлжээний дохионы хэмжээг дэлгэцийн дээд талд гаргана.
- Apple CarPlay-г утасгүй холболтоор ашиглаж байгаа үед ашиглах боломжгүй.
- Зарим гар утасны загвар тухай бүр холболт хийх шаардлагатай байж болно.
- Wi-Fi® функц асаалттай үед сүлжээ танигдсан нөхцөлд хамгийн сүүлд холбогдсон сүлжээнд түрүүлж холбогдоно.

### Холбоотой холбоосууд

Wi-Fi® тохиргоо өөрчлөх(Х. 121)

### Ухаалаг утас ашиглан Wi-Fi®-д холбох

Дараах үйлдлийн жишээний дагуу Wi-Fi® цацах функцтай ухаалаг утас ашиглан Wi-Fi® холболт хийнэ. Сүлжээ цацах тохиргооны тухай дэлгэрэнгүйг ухаалаг утасны зааварчилгаанаас харна уу. Зарим ухаалаг утасны загвар холболт хийх бүрт баталгаажуулалт хийх шаардлагатай байдаг.

1 **Үндсэн цэсний [⚙]-г дарна.**

2 **Дэд цэснээс [Data & Wi-Fi], эсвэл [Wi-Fi]-г дарна.**

3 **Үндсэн хэсгийн [Wi-Fi]-г асаана.**




- Мултимедиа системийн тохиргооноос хамаарч мессеж гарч болно. Дэлгэцийн зааварчилгааг баримтлана.
- [**Wi-Fi**]-г асаах үед ойр байгаа сүлжээг харуулна.

4 **Ухаалаг утаснаас цацаж буй сүлжээний нэртэй адил сүлжээг сонгоно.**

- Нэг сүлжээг олон MAC хаяг ашиглаж байгаа үед сүлжээний нэр олон давхардаж гарч болно.

- 30 хүртэлх сүлжээг харуулах боломжтой. Сүлжээний жагсаалт 6 секунд тутамд шинэчлэгдэнэ.
- Адил сүлжээний SSID нэртэй олон төхөөрөмж байгаа үед аль төхөөрөмж холбохыг таних боломжгүй. Олон төхөөрөмж ашиглах үед сүлжээний өөр SSID нэр ашиглана.
- Жолоодлогын үед сонголт хийх боломжгүй.

**5 Сүлжээний нууц үг оруулна.**

- Нууц үг тохируулаагүй нөхцөлд сүлжээ сонгох үед холбогдоно.
- Автоматаар холбохоор тохируулсан сүлжээ танигдсан үед автоматаар шууд холбогдоно.

**МЭДЭЭЛЭЛ**

20 хүртэлх сүлжээний холболтын түүх хадгалагдах ба шинэ сүлжээнд холбогдох үед хамгийн хуучин түүх устгагдана.

## Wi-Fi® сүлжээнд холбох

Интернетэд ойр орчимд байгаа Wi-Fi®ашиглан холбогдох.

Холбогдох сүлжээний нууц үгийг урьдчилан тодруулна.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 Дэд цэснээс [Data & Wi-Fi], эсвэл [Wi-Fi]-г дарна.**

**3 Үндсэн хэсгийн [Wi-Fi]-г асаана.**




- Мултимедиа системийн тохиргооноос хамаарч мессеж гарч болно. Дэлгэцийн зааварчилгааг баримтлана.
- [**Wi-Fi**]-г асаах үед ойр байрлах боломжит сүлжээг харуулна.

**4 Үндсэн хэсгийн [Available networks]-с холбох сүлжээг сонгоно.**

- Нэг сүлжээг нэгээс олон MAC хаяг ашиглаж байгаа үед сүлжээний нэр олон хувилж гарч болно.
- 30 хүртэлх сүлжээг харуулна. 6 секунд тутамд жагсаалт шинэчлэгдэнэ.
- Адил сүлжээний SSID нэртэй олон төхөөрөмж байгаа үед холбох төхөөрөмжийг таних боломжгүй. Олон төхөөрөмж ашиглах үед өөр сүлжээний SSID нэр төхөөрөмж тус бүрт ашиглана.
- Жолоодлогын үед сонголт хийх боломжгүй.
- Сүлжээний [ ] дээр дарж сүлжээний дэлгэрэнгүй мэдээлэл харна.

**5 Сүлжээний нууц үг оруулна.**

- Нууц үг тохируулаагүй үед сүлжээ сонгох үед холбогдоно.
- Автоматаар холбогдох сүлжээ танигдсан үед тус сүлжээнд автоматаар холбогдоно.

**МЭДЭЭЛЭЛ**

20 хүртэлх сүлжээний холболтын түүх хадгалагдах ба шинэ сүлжээнд холбогдсон үед хамгийн хуучин түүх устана.

## Wi-Fi® салгах

Wi-Fi® функцийг унтраан Wi-Fi® холболтыг салгах боломжтой.

1 **Үндсэн цэсний []-г дарна.**

2 **Дэд цэснээс [Data & Wi-Fi], эсвэл [Wi-Fi]-г дарна.**

3 **Үндсэн хэсгийн [Wi-Fi]-г унтраана.**



## Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга

Apple CarPlay болон Android Auto нь зарим аппликейшн (газрын зураг, утас, дуу) мултимедиа систем дээр ашиглах боломж бүрдүүлдэг. Apple CarPlay, эсвэл Android Auto холбогдсон үед дэмждэг апп дэлгэцээр гарна. Apple CarPlay, эсвэл Android Auto ашиглах үед дараах мэдээлэлд онцгой анхаарна.

Тус автомашинд Android Auto ашиглах үед Google-н Play Store-с Android Auto аппликейшн суулгана.

### ■ Ашиглах боломжтой төхөөрөмж

- Apple CarPlay-г дэмждэг Apple iPhone төхөөрөмж. (iOS Ver. 13.3-с хойших)

  Ашиглах боломжтой төхөөрөмжийг https://www.apple.com/ios/carplay/-с харна уу.*1

- Android Auto-г дэмждэг Android төхөөрөмж.

  Ашиглах боломжтой төхөөрөмжийг https://www.android.com/auto/-с харна уу.*1

**⚠ АЮУЛТАЙ**

Аюулгүйн үүднээс жолооч жолоодлогын үед ухаалаг утас удирдаж болохгүй.

**⚠ АНХААР**

- Автомашинд утас үлдээж болохгүй. Бүхээг халах үед ухаалаг утсанд доголдол үүсгэх аюултай.
- Холбосон ухаалаг утсыг доош дарах, хөндлөн түлхэж болохгүй. Ухаалаг утас, эсвэл порт гэмтэх аюултай.
- USB портонд гадны биет орохоос сэргийлнэ. Ухаалаг утас, эсвэл порт гэмтэх аюултай.

**МЭДЭЭЛЭЛ**

- USB холболтод утасны үйлдвэрлэгчийн дата USB холбогч ашиглана.
- Apple CarPlay, эсвэл Android Auto-г холбосон үед үед системийн зарим товчны ажиллагаа өөрчлөгдөнө.
- Дараах функцууд Apple CarPlay, эсвэл Android Auto-н адил функцаар солигдох, эсвэл Apple CarPlay, эсвэл Android Auto-р холбогдсон төхөөрөмж дээр идэвхгүй болно.

*1 : Бүх төхөөрөмжтэй холбогдох баталгаа байхгүй.

- Bluetooth® утас (Зөвхөн Apple CarPlay)
- Bluetooth® аудио
- Miracast® (Зөвхөн утасгүй холбосон Apple CarPlay)

- Apple CarPlay-г утасгүй холболтоор холбосон үед Bluetooth® функц ашиглах боломжгүй. (Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.)
- Miracast® ашиглах үед Apple CarPlay, эсвэл Android Auto асаах нь Miracast®-н ажиллагааг зогсооно.
- Дуу хоолойн тохиргооны дэлгэцээр дуут зааварчилгааны дууны түвшинг тохируулах боломжтой. Мөн аудио удирдлагын [**PWR·VOL**] товч ашиглаж болно.
- Apple CarPlay, эсвэл Android Auto-г холбосон үед өөр төхөөрөмжийн Apple CarPlay, эсвэл Android Auto-г холбох боломжгүй.
- Apple CarPlay болон Android Auto нь Apple болон Google-н хөгжүүлсэн аппликейшн болно. Холбосон төхөөрөмжийн функц болон үйлдэл урьдчилан мэдэгдэлгүйгээр үйлдлийн систем, техник хангамжийн өөрчлөлт, Apple CarPlay болон Android Auto-н үзүүлэлтийн дагуу өөрчлөгдөж болно.
- Apple CarPlay, эсвэл Android Auto-г дэмждэг аппликейшны тухай дэлгэрэнгүйг тус тусын цахим хуудаснаас үзнэ үү.
- Apple CarPlay, эсвэл Android Auto-г ашиглах үед автомашины хурд, байрлал зэрэг автомашин болон хэрэглэгчийн мэдээлэл аппликейшн хөгжүүлэгч, үүрэн холбооны операторт дамжуулагдана.
- Аппликейшн татан ашиглах нь ашиглах нөхцлийг хүлээн зөвшөөрснийг илтгэнэ.
- Дата интернетээр илгээгдэх үед төлбөртэй байж болно. Тарифын мэдээллийг та өөрийн үүрэн холбооны оператороос тодруулна уу.
- Аппликейшнээс хамаарч дуу тоглуулах зэрэг зарим функцийн ажиллагаа хязгаарлагдаж болно.
- Эдгээр компаниудын аппликейшны функц болон үйлдэл урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчлөгдөж болно. Дэлгэрэнгүйг цахим хуудаснаас харна уу.
- Автомашины навигацийн систем маршрутын зааварчилгаа хийж байгаа ба Apple CarPlay, эсвэл Android Auto-н газрын зургийн аппликейшнээр шинэ маршрут сонгогдсон үед автомашины навигацийн зааварчилгаа зогсоно. Apple CarPlay, эсвэл Android Auto-н газрын зургийн аппликейшн ашиглах үед автомашины навигацийн системээр шинэ маршрут сонгогдсон үед Apple CarPlay, эсвэл Android Auto-н маршрутын зааварчилгаа зогсоно.
- Apple CarPlay-р холбосон төхөөрөмжийн Bluetooth® функцийг ашиглах боломжгүй.

- Android Auto-р холбосон төхөөрөмжийг гарны оролцоогүй дуудлагаас бусад Bluetooth® функцийг ашиглах боломжгүй.
- USB-р холбосон ба USB холболтыг салгасан үед Apple CarPlay, эсвэл Android Auto-н ажиллагаа зогсоно. Аудио дуугаралт зогсож мултимедиа системийн дэлгэцэнд буцна.

## Холбоотой холбоосууд

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх (Х. 115)

Аудио систем асааж унтраах, дууны түвшин тохируулах(Х. 36)

iPod/iPhone тоглуулах үеийн анхааруулга (Х. 217)

Apple CarPlay тоглуулах үеийн анхааруулга(Х. 220)

Android Auto тоглуулах үеийн анхааруулга(Х. 223)

Miracast® тоглуулах үеийн анхааруулга (Х. 231)

Bluetooth® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 134)

Wi-Fi® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 150)

Bluetooth® аудио тоглуулах анхааруулга (Х. 226)

## Бүртгэлгүй ухаалаг утсаар Apple CarPlay ашиглах

Мултимедиа системд бүртгэлгүй ухаалаг утас холбон Apple CarPlay ашиглах боломжтой. Бүртгэлтэй ухаалаг утаснаас өөрөөр удирдана.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

**Холбоотой холбоосууд**

Бүртгэгдсэн утсаар Apple CarPlay ашиглах(Х. 161)

## USB холболтоор Apple CarPlay ашиглах

Ухаалаг утсыг USB холболтоор мултимедиа системд холбон Apple CarPlay ашиглах боломжтой.

1 **Ухаалаг утасны тохиргооны цэснээс Siri-г идэвхжүүлнэ.**

2 **USB портод ухаалаг утас холбоно.**

Apple CarPlay-н үндсэн дэлгэц гарна.

- Холбосон ухаалаг утаснаас хамаарч анхны дэлгэцэнд буцах хүртэл 3-6 секунд шаардагдаж болно.
- Ухаалаг утасны дэлгэц дээр зааварчилгаа гарсан үед дэлгэцийн зааварчилгааг баримтлана.

3 **Apple CarPlay-г удирдана.**




Apple CarPlay-г дэмждэг iPhone-н аппликейшн дээр дарж ашиглах боломжтой.

**[ ]**

Мултимедиа системийн дэлгэц гаргана.

Apple CarPlay-н үндсэн дэлгэцийг дахин гаргах үед үндсэн цэсний [ ]-г дахин дарна.

**[ ]/[ ]**

Дэлгэц солино.

Удаан дарж Siri-г асаана.

**МЭДЭЭЛЭЛ**

- Apple CarPlay холбогдсон үед жолооны хүрдний [ ] товч удаан дарж Siri-г асаана. Цуцлах үед жолооны хүрдний [ ] товчийг дахин дарна.

- [**Wake word**]-г идэвхжүүлсэн ба Apple CarPlay холбогдсон үед Siri-г эхлүүлэх үг хэлж Siri-г асаана. (Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.)

  Системийн хэлийг зөвхөн англи хэлээр тохируулсан үед Siri ашиглах боломжтой. Мөн холбосон төхөөрөмж iOS-н 14.3-с хойших хувилбартай байх шаардлагатай.
- USB-р холбон бүртгэхдээ утасгүй холболтыг идэвхжүүлэхээр тохируулсан үед дараагийн удаагаас утасгүй холболтоор холбогдоно.

### Холбоотой холбоосууд

USB портод холбох(Х. 40)

Дуу хоолойн удирдлага эхлүүлэх(Х. 63)

Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх(Х. 91)

## Утасгүй холболтоор Apple CarPlay ашиглах

Apple CarPlay-г мултимедиа системд автомашины утасгүй холболтын функц ашиглан холбох боломжтой.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

1 **Ухаалаг утасны тохиргооны цэснээс Siri-г идэвхжүүлнэ.**

2 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

3 **[Bluetooth & Devices]-г дарна.**

- Мултимедиа системд ухаалаг утас бүртгээгүй үед төхөөрөмж хайх дэлгэц гарч ирнэ. Үйлдлийг эхлэнэ **6**.

4 **[Manage devices]-г дарна.**

5 **[Add another device]-г дарна.**

6 **[If not found]-г дарна.**

7 **Бүртгэх ухаалаг утас сонгоно.**

8 **Дэлгэц болон ухаалаг утсан дээр гарах пин код адил байгааг шалгаад [OK]-г дарна.**

- Дэлгэцийн зааварчилгааг баримтлана.

9 **Apple CarPlay-н тохиргоо дэлгэцээр гарсан үед [Yes]-г дарна.**

Apple CarPlay-н үндсэн дэлгэц гарна.

- Холбосон ухаалаг утаснаас хамаарч анхны дэлгэцэнд буцах хүртэл 3-6 секунд шаардагдаж болно.
- Үйлдэл амжилтгүй болсныг илтгэх дэлгэц гарсан үед дэлгэцийн заавры дагана.
- Ухаалаг утасны дэлгэц дээр зааварчилгаа гарсан үед зааварчилгааг баримтлана.

**10 Apple CarPlay-г удирдана.**




Apple CarPlay-г дэмждэг iPhone-н аппликейшн дээр даран ашиглах боломжтой.

**[ ]**

Мултимедиа системийн дэлгэц гаргана.

Apple CarPlay-н үндсэн дэлгэцийг дахин гаргах үед үндсэн цэсний [ ]-г дарна.

**[ ]/[ ]**

Дэлгэц солино.

Удаан дарж Siri-г асаана.

### МЭДЭЭЛЭЛ

- Apple CarPlay-г холбосон үед жолооны хүрдний [ ] товчийг удаан дарж Siri-г эхлүүлнэ. Цуцлах үед тус [ ] товчийг дахин дарна.
- [**Wake word**]-г идэвхжүүлсэн ба Apple CarPlay-г холбосон үед сэрээх үг хэлж Siri-г эхлүүлнэ. (Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.)

  Siri-г сэрээх үгийг системийн тохиргоог зөвхөн Англи хэл дээр тохируулсан үед ашиглах боломжтой. Мөн холбосон төхөөрөмж iOS-н 14.3-с хойших хувилбартай үйлдлийн системтэй байх шаардлагатай.

## Холбоотой холбоосууд

Дуу хоолойн удирдлага эхлүүлэх(Х. 63)

Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх(Х. 91)

## Бүртгэгдсэн утсаар Apple CarPlay ашиглах

Мултимедиа системд бүртгэгдсэн ухаалаг утас ашиглан Apple CarPlay ашиглах боломжтой. Ашиглах арга бүртгэлгүй утаснаас өөр байна.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

### Холбоотой холбоосууд

Бүртгэлгүй ухаалаг утсаар Apple CarPlay ашиглах(Х. 158)

## USB холболтоор Apple CarPlay ашиглах

Мултимедиа системд USB холбогчоор ухаалаг утас холбон Apple CarPlay ашиглах боломжтой.

1 **Ухаалаг утасны тохиргооны цэс дээр Siri-г идэвхжүүлнэ.**

2 **USB портод ухаалаг утас холбоно.**

Apple CarPlay-н үндсэн дэлгэц гарна.

- Холбосон ухаалаг утаснаас хамаарч анхны дэлгэц руу буцах хүртэл 3-6 секунд шаардагдаж болно.
- Үйлдэл амжилтгүй болсон мессеж гарсан үед дэлгэцийн зааварчилгааг дагана.
- Ухаалаг утасны дэлгэц дээр зааварчилгаа гарсан үед дэлгэцийн зааварчилгааг дагана.
- Apple CarPlay-н үндсэн дэлгэц гарахгүй үед Apple CarPlay-н [ ] > [**Bluetooth & Devices**] > [**Manage devices**]>[**Switch**] дараалллаар дарж ашиглах ухаалаг утас сонгоно.

3 **Apple CarPlay-г удирдана.**



Apple CarPlay-г дэмждэг iPhone апп дээр даран ашиглах боломжтой.

**[ ]**

Мултимедиа системийн дэлгэц гаргана.

Apple CarPlay-н дэлгэцийг дахин гаргах үед үндсэн цэсний [ ]-г дарна.

**[ ]/[ ]**

Дэлгэц солино.

Удаан дарж Siri асаана.

### МЭДЭЭЛЭЛ

- Apple CarPlay холбогдсон үед жолооны хүрдний [ ] товч удаан дарж Siri асаана. Цуцлах үед тус [ ] товчийг дахин дарна.
- [**Wake word**]-г идэвхжүүлсэн ба Apple CarPlay холбогдсон үед Siri эхлүүлэх үг хэлж Siri-г идэвхжүүлнэ. (Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.)

  Системийн хэлийг зөвхөн англи хэл дээр тохируулсан үед Siri-н сэрээх үгний функц ашиглах боломжтой. Мөн холбосон төхөөрөмж iOS-н 14.3-с хойших хувилбартай байх шаардлагатай.

### Холбоотой холбоосууд

USB портод холбох(Х. 40)

Дуу хоолойн удирдлага эхлүүлэх(Х. 63)

Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх(Х. 91)

## Утасгүй холболтоор Apple CarPlay ашиглах

Мултимедиа системд автомашины утасгүй холболтын функцаар Apple CarPlay-г холбох боломжтой.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

1 **Ухаалаг утасны тохиргооны цэс дээр Siri-г идэвхжүүлнэ.**

2 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

3 **[Bluetooth & Devices]-г дарна.**

4 **[Manage devices]-г дарна.**

5 **Apple CarPlay-н [Switch]-г дарна.**

6 **Apple CarPlay-г ашиглах ухаалаг утас сонгоно.**

Apple CarPlay-н үндсэн дэлгэц гарна.

- Холбосон ухаалаг утаснаас хамаарч анхны дэлгэцэнд буцах хүртэл 3-6 секунд шаардагдаж болно.
- Үйлдэл амжилтгүй болсон мессеж дэлгэцээр гарсан үед дэлгэцийн зааварчилгааг дагана.
- Ухаалаг утасны дэлгэц дээр зааварчилгаа гарсан үед зааварчилгааг дагана.

**7 Apple CarPlay-г удирдана.**

Apple CarPlay-г дэмждэг iPhone-н аппликейшн дээр даран ашиглах боломжтой.



**[ ]**

Мултимедиа системийн дэлгэц гаргана.

Apple CarPlay-н үндсэн дэлгэцийг дахин гаргах үед үндсэн дэлгэцнээс [ ]-г дарна.

**[ ]/[ ]**

Дэлгэц солино.

Удаан дарж Siri-г эхлүүлнэ.

### МЭДЭЭЛЭЛ

- Apple CarPlay холбогдсон үед жолооны хүрдний [ ] товчийг удаан даржSiri-г эхлүүлнэ. Цуцлах үед жолооны хүрдний [ ] товчийг дахин дарна.
- [**Wake word**]-г идэвхжүүлсэн ба Apple CarPlay холбосон үед Siri-г асаах үг хэлж Siri-г эхлүүлнэ. (Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.)

  Системийн хэлийг зөвхөн Англи хэл дээр тохируулсан үед Siri-н сэрээх үгний функцийг ашиглах боломжтой. Мөн холбосон төхөөрөмж iOS-н 14.3-с хойших хувилбартай байх шаардлагатай.

## Холбоотой холбоосууд

Дуу хоолойн удирдлага эхлүүлэх(Х. 63)

Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх(Х. 91)

## Android Auto ашиглах

Ухаалаг утсыг дата USB холбогчоор мултимедиа системд холбон Android Auto ашиглах боломжтой.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

**1 Холбох ухаалаг утсанд Android Auto аппликейшн суулгасан байгааг нягтлана.**

**2 Ухаалаг утсыг USB портод холбоно.**

Android Auto-н үндсэн дэлгэц гарна.

- Холбосон ухаалаг утаснаас хамаарч анхны дэлгэцэнд буцах хүртэл 3-6 секунд шаардагдаж болно.
- Үйлдэл амжилтгүй болсон мессеж гарсан үед дэлгэцийн зааварчилгааг баримтлана.
- Ухаалаг утсан дээр зааварчилгаа гарсан үед зааварчилгааг баримтлана.
- Android Auto-н үндсэн дэлгэц гарахгүй үед дараах үйлдлийг хийнэ.
  - Үндсэн цэсийг [ ] > [**Bluetooth & Devices**] > [**Manage devices**], [**Switch**] дараалаар дарж ашиглах утас сонгоно.
  - Үндсэн цэснээс [ ]-г дарна.

**3 Android Auto-г удирдана.**

Android Auto-г дэмждэг аппликейшн дээр дарж ашиглах боломжтой.




**[ ]**

Мултимедиа системийн дэлгэц гаргана.

Android Auto-н үндсэн дэлгэц дахин гаргах үед үндсэн цэсний [ ]-г дарна.

**[ ]**

Google Assistant эхлүүлнэ.

### МЭДЭЭЛЭЛ

Android Auto холбогдсон үед жолооны хүрдний [ ] товчийг удаан дарж Google Assistant эхлүүлнэ. Цуцлах үед жолооны хүрдний [ ] товчийг дахин дарна.

## Холбоотой холбоосууд

USB портод холбох(Х. 40)

Дуу хоолойн удирдлага эхлүүлэх(Х. 63)

## Apple CarPlay, эсвэл Android Auto доголдсон үед

Apple CarPlay, эсвэл Android Auto доголдсон үед дараах хүснэгтийг шалгана.

| Шинж тэмдэг | Шийдэл |
|---|---|
| Apple CarPlay, эсвэл Android Auto асахгүй байх. | Холбосон ухаалаг утас Apple CarPlay, эсвэл Android Auto-г дэмждэг эсэхийг нягтлана.<br>Ухаалаг утсан дээр Apple CarPlay, эсвэл Android Auto-г идэвхжүүлсэн байгааг нягтлана.<br>Холбосон ухаалаг утсан дээр Android Auto аппликейшн суулгасан байгааг нягтлана.<br>Дэлгэрэнгүйг дараах холбоосноос нягтлана уу.<br>● Apple CarPlay：https://www.apple.com/ios/carplay/<br>● Android Auto：https://www.android.com/auto/ |
| | Бүртгэгдсэн ухаалаг утасны Apple CarPlay, эсвэл Android Auto функцийг мултимедиа систем дээр идэвхжүүлсэн байгааг нягтлана. |
| | USB холбогчоор холбосон үед USB холбогч ухаалаг утас болон USB портод бүрэн залгагдсан байгааг нягтлана. Ухаалаг утсыг USB портод шууд холбоно. USB салаалагч ашиглаж болохгүй.<br>Apple CarPlay, эсвэл Android Auto холболтод зориулсан зөв USB порт ашиглаж байгааг нягтлана. Зөвхөн цэнэглэх зориулалттай USB портыг ухаалаг утасны аппликейшнд ашиглах боломжгүй. Apple CarPlay-н утасгүй холболт нь утасгүй цэнэглэх төхөөрөмж*1 ашиглагдаж байгаа үед холбогдохгүй.<br>Apple CarPlay-н утасгүй холболт ашиглах үед дараах зүйлсийг шалгана.<br>● Ухаалаг утас мултимедиа системд Bluetooth®-р холбогдох боломжтойг нягтлана.<br>● Ухаалаг утас Wi-Fi® ашиглах боломжтойг нягтлана.<br>● Таны машин утасгүй Apple CarPlay функцээр тоноглогдсон эсэхийг шалгана. |

| Шинж тэмдэг | Шийдэл |
|---|---|
| Apple CarPlay, эсвэл Android Auto асахгүй байх. | Apple CarPlay-д: Apple-с гэрчилгээтэй холбогч ашиглаж байгааг нягтлана.<br>Siri идэвхжсэн байгааг нягтлана.<br>Зөвхөн цэнэглэх зориулалттай USB холбогчоор ухаалаг утас холбох боломжгүй.<br>Дата дамжуулах хүчин чадалтай холбогч ашиглана. Зарим холбогч дата дамжуулдаггүй.<br>Ашиглахад тохиромжтой USB холбогчийн үзүүлэлтийг жагсаав.<br>● iPhone: Албан ёсны Apple USB холбогч, эсвэл Apple MFi гэрчилгээтэй USB холбогч ашиглана.<br>● Android: 1.8 м (6 фут) хүртэлх урттай холбогч ашиглах ба уртасгагч ашиглахгүй.<br>● USB логотой холбогч ашиглана.<br>Өмнө нь хэвийн холбогдож байсан ухаалаг утас холбогдохгүй үед USB холбогч солиход асуудал ихэвчлэн шийдэгддэг. |
| | Дээрх бүх нөхцлүүдийг шалгаад Apple CarPlay, эсвэл Android Auto-г дахин холбоно. |
| Apple CarPlay/Android Auto холболт үүсч видео тоглуулж байгаа үед дүрс гарахгүй ба системээс зөвхөн аудио дуу гарна. | Систем нь Apple CarPlay/Android Auto-р видео гаргах зориулалтгүй тул энэ нь доголдол биш болно. |
| Аудио дуу гарахгүй байх. | Мултимедиа системийн дууг хаасан, эсвэл бага түвшинд тохируулсан. Дууны түвшинг нэмнэ. |
| | Apple-н дэмждэг аппликейшныг Apple CarPlay-д, Google-н дэмждэг аппликейшныг Android Auto-д ашиглана. Веб хөтөчөөс шууд дуу тоглуулах нь муу чанартай аудио дуугаралт үүсгэнэ. |
| Дэлгэц анивчиж шуугиан үүсэх. | Мултимедиа системд холбосон USB холбогч гэмтсэн эсэхийг шалгана. USB холбогчид дотоод гэмтэл байгаа эсэхийг компьютер зэрэг өөр төхөөрөмжинд ухаалаг утас холбон цэнэг шахаж байгаа эсэх, ухаалаг утсыг таниж байгаа эсэхээр шалгана. |
| | USB холбогчийг өөрөөр солино. |

| Шинж тэмдэг | Шийдэл |
|---|---|
| Apple CarPlay газрын зургийн аппликейшн ашиглах үед газрын зураг томрохгүй, жижигрэхгүй байх | Apple CarPlay газрын зургийн аппликейшн 2 хуруугаараа удирдах үйлдлийг дэмждэггүй. |
| Apple CarPlay дэлгэцийн голд гарч байгаа ба бүтэн дэлгэцээр гарахгүй байх. | Бүтэн дэлгэц нь iOS Ver. 10-с хойших хувилбар дээр гардаг. iOS-н хувилбараа шинэчилнэ үү. |
| Apple CarPlay-н дууны апп (Apple Music, Spotify зэрэг) дуу тоглуулах үед Apple CarPlay*2-г дэмждэггүй iPhone-н аппликейшн ажиллаж эхлэн мултимедиа системд дуу өгч мултимедиа системийн дууны түвшин өөрчлөгдсөн үед дэмждэггүй аппликейшны дуу хаагдаж анхны дууны апп үргэлжлүүлэн дуугарна. | Энэ нь мултимедиа системийн техникийн шаардлагын дагуур үйлдэл бөгөөд доголдол биш болно. |
| Мултимедиа систем дээр аудио тоглуулах (FM зэрэг) үед Apple CarPlay-г дэмждэггүй аппликейшнээс дуу гарсан үед мултимедиа систем анхны аудио эх үүсвэр лүү буцахгүй. | Энэ нь мултимедиа системийн техникийн шаардлагын дагуур үйлдэл бөгөөд доголдол биш болно. Аудио эх үүсвэрийг гараар солино. Мөн Apple CarPlay*2-г дэмждэггүй аппликейшн ашиглахаас татгалзах нь зүйтэй. Зарим навигацийн аппликейшн iOS 12 үйлдлийн системээс эхлэн Apple CarPlay-г дэмждэг. iOS болон аппликейшнийг сүүлийн хувилбарт шинэчилнэ. |
| Android Auto-г ашиглах үед эргэлт заах навигаци мэдээллийн дэлгэц, эсвэл мултимедиа системийн дэлгэцээр гарахгүй. | Мэдээллийн дэлгэцийн үзүүлэлтээс хамаарч тус үйлдлийг дэлгэцээр гаргахгүй. |
| Android Auto-г ашиглах үед гарны оролцоогүй дуудлагын дуу автомашины спикерээс гарахгүй. | Яриаг дуусгана.<br>Ухаалаг утаснаас USB холбогчийг салгаж гарны оролцоогүй дуудлагыг ашиглаж үзнэ. Одоо аудио сонсогдож байгаа эсэхийг нягтлана. |

| Шинж тэмдэг | Шийдэл |
|---|---|
| Android Auto-г ашиглах үед гарны оролцоогүй дуудлагын дуу автомашины спикерээс гарахгүй. | Мултимедиа системийн дууны түвшинг нэмээд гарны оролцоогүй дуудлага сонсогдох эсэхийг нягтлана. Өөр ухаалаг утас ашиглаж үзнэ. Одоо аудио сонсогдож байгаа эсэхийг нягтлана. |



## Холбоотой холбоосууд

Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 123)

USB портод холбох(Х. 40)

Аудио систем асааж унтраах, дууны түвшин тохируулах(Х. 36)

Bluetooth® төхөөрөмжтэй холбох(Х. 144)

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх (Х. 115)

Мэдрэгчтэй дэлгэц ашиглах үеийн анхааруулга(Х. 25)



*1 : Тоноглогдсон автомашинд

*2 : "Apple CarPlay-г дэмждэггүй аппликейшн" гэдэг нь Apple CarPlay-н дэлгэц дээр гардаггүй iPhone-н аппликейшныг хэлнэ.

# 4 Навигаци

4-1. Навигацийн системийн тухай
Wi-Fi®-р газрын зургийн мэдээлэл илгээх үйлчилгээний тухай ....... 172
Серверт холбогдсон навигаци (автомашинд суурилагдсан навигацитай) .................. 174
4-2. Газрын зургийн тухай мэдээлэл
Тухайн цэгийн тухай мэдээлэл гаргах ............... 175
Газрын зургийн сонголтын дэлгэц............ 176
POI тэмдэг гаргах ............. 177
Газрын зургийн дэлгэцийн тохиргоо........ 178
Хурдны замын горимын тухай ................................ 182
4-3. Очих газраар тохируулах байршил хайх
Очих газар хайх................. 183
Очих газар хайх дэлгэц.... 184
Хайлтын үр дүнгийн жагсаалтын дэлгэц.......... 187
Замын цэг нэмэх................ 188
Ухаалаг утаснаас очих газар тохируулах............. 189
4-4. Очих газар тохируулах
Бүтэн маршрутын газрын зургийн дэлгэц................. 191
Маршрут зааварчилгааны демо үзэх.................................... 192
Маршрутын сонголт өөрчлөх............................. 193
Маршрут өөрчлөх ............. 194
Маршрутаар дамжин өнгөрөх цэгүүдийг тохируулах........................ 195
Замын цэгүүдийг засварлах......................... 196
4-5. Маршрутын зааварчилгаа
Маршрут зааварчилгааны дэлгэц. 197
Замын эгнээ харуулах дэлгэц .............................. 198
Маршрут дахин хайх ........ 200
Ердийн дуут зааварчилгаа .................. 201
4-6. Газрын зураг шинэчлэх
Газрын зургийн мэдээллийн сангийн хувилбар ба хамрах хүрээ................................ 202

## Wi-Fi®-р газрын зургийн мэдээлэл илгээх үйлчилгээний тухай

- Wi-Fi® ашигладаг үйлчилгээг ("үйлчилгээ" гэх) тус мультимедиа суурилагдсан автомашин шинээр худалдан авах үед тодорхой хугацаанд*1 ашиглах боломжтой.

  *1: Үйлчилгээний үргэлжлэх хугацааг навигацийн системийн тохиргооны дэлгэцнээс харах боломжтой. Дэлгэрэнгүйг тус тохиргооны дэлгэцнээс харна уу. Үйлчилгээний хугацаа дууссаны дараа үргэлжлүүлэн ашиглах үед та өөрийн Lexus дилерт хандана уу.
- Тус үйлчилгээнд гуравдагч этгээдийн үзүүлдэг дараах үйлчилгээ мөн хамаарна.
  - Замын түгжрэлийн мэдээлэл: Автомашин сүлжээнд холбогдох үед байршлын мэдээлэл TomTom Global Content B.V-д ([TomTom] гэх) илгээгддэг. Хүлээн авсан мэдээлэл дээр үндэслэн TomTom замын түгжрэлийн мэдээлэл илгээх зэрэг онлайн үйлчилгээ үзүүлдэг ба мэдээлэл мультимедиа систем дээр гардаг.
  - Байгууламжийн мэдээлэл/ойролцоох мэдээлэл: Хайсан байгууламжийн нэр болон байршлын мэдээлэл HERE Global B.V. ([HERE] гэх)-д илгээгддэг. Хүлээн авсан мэдээлэл дээр үндэслэн HERE байгууламжийн олон ойролцоох мэдээлэл илгээх зэрэг онлайн үйлчилгээ үзүүлдэг ба мэдээлэл мультимедиа систем дээр гардаг.
- Эдгээр үйлчилгээг ашиглах үед мультимедиа системийг Wi-Fi®-д холбож дэлгэцнээс үйлчилгээ үзүүлэгч тус бүрийн ашиглалтын нөхцлийг*2 шалгаад [**Agree**]-г дарна.

  *2: Ашиглалтын нөхцлийн тухай дэлгэрэнгүйг дараах холбоосоос харна уу.

| | |
|---|---|
| TomTom | https://www.tomtom.com/en_gb/legal/eula-automotive/<br>https://www.tomtom.com/en_us/privacy/ |
| HERE | https://legal.here.com/terms/<br>https://legal.here.com/privacy/policy |

- Тоёота Мотор Корпорац болон салбар компаниуд нь эдгээр үйлчилгээний чанар, ажиллагаа болон нарийвчлалтай холбоотой аливаа баталгаа өгөхгүй ба эдгээр үйлчилгээний контент, саатал, тасалдлаас үүдэн хэрэглэгчид учирсан хохиролд аливаа хариуцлага хүлээхгүй. Мультимедиа системээр дамжуулан үзүүлж буй үйлчилгээнүүд урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчлөгдөх, үйлчилгээ зогсох, түдгэлзүүлэгдэж болно.

## Холбоотой холбоосууд

Бусад тохиргоо(Х. 109)

## Серверт холбогдсон навигаци (автомашинд суурилагдсан навигацитай)

Хөтөч дээрх төхөөрөмж нь навигацийн газрын зургийг хадгалдаг тул Toyota Smart Center-тэй холбогдох боломжгүй газруудад газрын зургийн дэлгэц болон навигацийн чиглэлийн хайлтыг хийж болно. Автомашин хэрэгсэл харилцаа холбооны орчин сайтай газар руу ороход Toyota Smart Center-тэй холбоо автоматаар эхэлж, газрын зураг харуулах, маршрутын хайлтыг холбогдсон навигацаар гүйцэтгэдэг.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

### МЭДЭЭЛЭЛ

- Очих газрыг тохируулсан үед Toyota Smart Center автоматаар очих газар хүртэлх маршрут хайна. Toyota Smart Center-н илгээсэн маршрутыг []-р харуулдаг.
- Toyota Smart Center-н ашиглалтын гэрээ хийгээгүй бол автомашинд суурилагдсан навигацаар газрын зургийн дэлгэц болон маршрутын зааварчилгаа ашиглаж болно.

## Тухайн цэгийн тухай мэдээлэл гаргах

Газрын зураг дахь тухайн цэг, эсвэл POI-н тухай мэдээллийг шалгах боломжтой.

**1 POI, эсвэл тухайн цэг дээр удаан дарна.**

Тухайн цэгийг сонгосон үед цэгийн хаяг дэлгэцээр гарна. Тогтмол ашигладаг хаягаар бүртгэх үед [ ]-г дарна.

**2 Шаардлагатай мэдээлэл дээр дарна.**




A Тогтмол ашигладаг хаягаар бүртгэх үед дарна.

B Сонгосон цэгийн хаяг дэлгэцээр харуулна.

C POI-д бүртгэгдсэн дугаар луу дуудлага хийнэ.

D Тухайн цэгийг очих газраар тохируулан маршрутын зааварчилгаа эхлүүлнэ.

E Тухайн цэгийг очих газраар тохируулан маршрутын бүтэн газрын зураг гаргана. Өмнө өөр очих газар тохируулсан байгаа үед очих газруудыг замын дайрч өнгөрөх цэгээр бүртгэх боломжтой.

F Нэг цэг дээр олон POI байгаа үед POI-н жагсаалт дэлгэцээр гарна.

Тухайн POI-н холбогдох мэдээллийг өөрчлөх үед дээр нь товшино.

Мөн дэлгэцийн мэдээллийн [ ] [ ]-г дарж засах боломжтой.

## Газрын зургийн сонголтын дэлгэц

POI тэмдэг, замын хөдөлгөөний мэдээлэл зэрэг газрын зурган дээр гарах мэдээллийг тохируулах боломжтой.

**1 Газрын зургийн дэлгэцний [ ••• ]-г дарна.**



**2 [Points of interest] , эсвэл [Display map]-г дарна.**

A Газрын зураг дээр гарах POI тэмдгийг тохируулах боломжтой.

B Газрын зураг дээр гарах мэдээллийг тохируулах боломжтой.




### Холбоотой холбоосууд

POI тэмдэг гаргах(Х. 177)

Газрын зургийн дэлгэцийн тохиргоо(Х. 178)

## POI тэмдэг гаргах

Ресторан зэрэг POI тэмдгүүдийг газрын зурган дээр гаргах боломжтой.

**1 Газрын зургийн дэлгэцний [ ••• ]-г дарна.**

**2 [Points of interest]-г дарна.**

**3 Газрын зургийн дэлгэцээр гаргах POI-г сонгоно.**

Дэлгэцээр гарснаас өөр төрлийн POI сонгох үед [**Edit POI**]-г дарна.




### МЭДЭЭЛЭЛ

- Газрын зургийн датад ороогүй POI-г харуулах боломжгүй.
- Газрын зургийн масштабыг 1км (0.6 миль)-с томруулах үед POI гарахгүй.
- Автомашины одоогийн байршлын тэмдэг [ ], эсвэл [ ]-с 10 км (6 миль) радиус доторх POI-г харуулах боломжтой. (200 хүртэлх)
- Газрын зургийн масштабыг 1км (0.6 миль)-с багасгасан ба дэлгэц дэх POI-н тоо тодорхой хэмжээнээс давсан үед дэлгэц энгийн дэлгэцэнд шилжинэ (Замыг илүү сайн харагдуулах үүднээс).
- Ойр орчимд байгаа POI-г дэлгэрэнгүй навигацийн тохиргооны дэлгэц дээр тохируулах боломжтой.

### Холбоотой холбоосууд

Газрын зургийн дэлгэцийн тохиргоо өөрчлөх(Х. 102)

## POI тэмдэг тохируулах

Жолоодлогын үед сонголтод шилжүүлэх үйлдэл хязгаарлагддаг.

**1 Газрын зургийн дэлгэцний [ ••• ]-г дарна.**

**2 [Points of interest]-г дарна.**

**3 [Edit POI]-г дарна.**

**4 Өөрчлөх POI -г сонгоно.**

**5 Бүртгэх шинэ POI-г сонгоно.**

4

Навигаци

## Газрын зургийн дэлгэцийн тохиргоо

Газрын зургийн дэлгэц дээр замын хөдөлгөөний мэдээлэл зэргийг гаргах боломжтой.

**1 Газрын зургийн дэлгэцний [ ••• ]-г дарна.**

**2 [Display map]-г дарна.**




A Замын хөдөлгөөний мэдээллийн дэлгэцийг асааж унтраана.*1

B Автомашины байрлалаас ойр байрлах гудамжны зогсоол харуулах буюу унтраана.*1

C Хурдны замын гарцыг дэлгэцээр харуулах буюу унтраана.

D Явсан замын маршрутыг (явсан мөр) дэлгэцээр харуулах буюу нууна.

Нуусан үед хадгалагдсан мэдээллийг устгаж болох эсэхийг тодруулах дэлгэц гарна.

E Хурдны камерыг дэлгэцээр харуулах буюу нууна.*1

F Газрын зургийн дэлгэцийн хэвийн газрын зураг, луужин, цаг агаарын газрын зурагт тохируулах боломжтой*1.

### Холбоотой холбоосууд

Гудамжны авто зогсоол(Х. 178)

Туулсан замыг харуулах (явсан маршрут)(Х. 179)

Хурдны камер(Х. 179)

Замын хөдөлгөөний мэдээлэл(Х. 180)

## Гудамжны авто зогсоол

[**On street parking**] -г газрын зургийн дэлгэцний тохиргоон дээр On болгосон үед ойр байрлах гудамжны авто зогсоолыг харуулна. Off болгосон үед очих газрын ойр орчмын гудамжны авто зогсоолыг харуулна.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Газрын зургийн дэлгэцний [Ⓟ]-г дарна.

Газрын зураг дээр гудамжны авто зогсоолыг харуулна. Зогсоолын зай талбай байгаа эсэхээс хамаарч өнгө өөрчлөгдөнө.







● Газрын зургийн масштабыг 1/5,000-с их (масштаб 50 м (150 фут)-с их) болгосон үед гудамжны авто зогсоол харагдахгүй.

## Туулсан замыг харуулах (явсан маршрут)

1000 км (600 миль) орчим туулсан замын мэдээллийг хадгалан дэлгэцээр харуулах боломжтой.

1 **Газрын зургийн дэлгэцний [•••]-г дарна.**

2 **[Display map]-г дарна.**

3 **[Route trace]-г дарна.**

### МЭДЭЭЛЭЛ

● Туулсан замын хэмжээ хадгалах хязгаараас давсан үед хамгийн хуучин мэдээлэл устгагдаж шинэ туулсан замыг хадгална.

● Туулсан замын мэдээллийг газрын зургийн 1/2,500-с 1/5,120,000 масштабтай үед харуулах боломжтой.

**Холбоотой холбоосууд**

Газрын зургийн дэлгэцийн тохиргоо(Х. 178)

## Хурдны камер

Газрын зурган дээр хурдны камерны тэмдэг гаргах боломжтой.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.




A Газрын зураг дахь хурдны камерны байршил.

B Хурдны камерны тэмдгийн мэдээлэл болон камер хүртэлх зайг харуулна.

## МЭДЭЭЛЭЛ

- Дээрх мэдээллүүд газрын зургийн масштабаас хамаарч дэлгэцээр гарна.
- Дээрх мэдээллүүд газрын зургийг дата өгөгдөл байгаа эсэхээс хамаарч гарна.
- Дээрх мэдээллийг унтраах боломжтой.
- Контентын хяналтын нөхцөл байдлаас хамаарч камерны бодит байрлал дэлгэцээр гарахгүй байж болно.

### Холбоотой холбоосууд

Зааварчилгааны тохиргоо(Х. 107)

## Замын хөдөлгөөний мэдээлэл

IP-Traffic, эсвэл RDS-TMC-р дамжуулан замын хөдөлгөөний мэдээлэл авч газрын зургийн дэлгэц дээр гаргах боломжтой.

Тус функцийг ашиглах үед Toyota Smart Center-н ашиглалтын гэрээ, эсвэл Wi-Fi® холболт шаардлагатай.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

1 **Газрын зургийн дэлгэцний [•••]-г дарна.**

2 **[Display map]-г дарна.**

3 **[Traffic]-г дарна.**




Газрын зургийн дэлгэц дээр замын хөдөлгөөний мэдээлэл гарна.

- Зам засвар, осол зэрэг замын хөдөлгөөний мэдээллийг тэмдгээр илэрхийлнэ.
- Хөдөлгөөний чиглэлийг сумаар илэрхийлнэ. Хөдөлгөөний хурдаас хамаарч өнгө өөрчлөгдөнө.

Зам тээврийн ослын тэмдэг дээр дарсан үед тухайн ослын дэлгэрэнгүй мэдээлэл гарна.




## Холбоотой холбоосууд

Wi-Fi® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 150)

## Хурдны замын горимын тухай

Хурдны зам, шулуун зам руу орох үед дэлгэц автоматаар хурдны замын горимд шилжинэ.




A Одоогийн байршлаас хэр зайтайг харуулна.

B Нэг байгууламжид 8 хүртэлх POI харуулна.

- 8-с олон POI байгаа үед тэмдэг дээр дарж үлдсэн POI-г гаргах боломжтой.

C Дэлгэцээр гарах сегмент өөрчлөгдсөн үед жолоодлогод ашиглаж байсан сегмент рүү товшин газрын зургийг буцаана.

## Очих газар хайх

Очих газар хайх дэлгэц дээр очих газар хайж тохируулах боломжтой.

**1 Газрын зургийн дэлгэцний [ 🔍 ]-г дарна.**

**2 Очих газар хайх дэлгэц гарна. Хайлт хийх арга сонгоно.**




**3 Дэлгэц дээр хайлтын үр дүнгийг жагсаалт гарна. Жагсаалтаас очих газраар тохируулах хайлтын үр дүнг сонгоно.**

- Өмнө нь очих газар тохируулсан байгаа үед [**New destination**] (шинэ очих газар тохируулах), эсвэл [**Add to route**]-г дарна.
- Холбогдсон навигаци ашиглаж байгаа үед үүлэн хайлтын системээс очих газар мөн хайх боломжтой. (Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.)

### Холбоотой холбоосууд

Замын цэгүүдийг засварлах(Х. 196)

Дэлгэцний гар ашиглан мэдээлэл хайх(Х. 69)

## Очих газар хайх дэлгэц




A Байршлын нэр, хаяг, утасны дугаар ашиглан хайх үед товшино.

B Текстийн курсор шилжүүлэх үед товшино.

C Тогтмол ашигладаг гэж бүртгэгдсэн бүх цэгийн эргэн тойрон дахь газрын зургийг харуулна.

Тогтмол ашигладаг цэг бүртгэгдсэн үед тус функцийг ашиглах боломжтой.

D Очих газрын түүх (өмнө нь очих газраар сонгосон) дэх цэгүүдийг дэлгэцээр гаргана.

Тус функцийг зөвхөн очих газрын түүх хадгалагдсан үед ашиглах боломжтой.

E Ухаалаг утаснаас урьдчилан илгээсэн Drive Plan-н газрын зураг гаргах үед товшино.*1

F Өөрийн гэрээ очих газраар сонгон маршрут хийнэ.

Өөрийн гэрийн хаягаа бүртгээгүй үед [ ]-г дарж бүртгэнэ.

G Очих газрын нэр дээр товшсон үед маршрутын бүтэн газрын зураг гарна. Маршрутын зааварчилгаа эхлүүлэх үед [**Go**]-г дарна.

### Холбоотой холбоосууд

Тэмдэгт бичиж оруулан хайх(Х. 184)

Очих газрын түүхээс хайлт хийх(Х. 186)

Жолоодлогын төлөвлөгөөний дагуу хайх(Х. 186)

Гэрийнхээ байршлыг очих газраар тохируулах(Х. 185)

Тогтмол очдог газрыг очих газраар тохируулах(Х. 185)

## Тэмдэгт бичиж оруулан хайх

Байршлын нэр, хаяг, утасны дугаар оруулан очих газрын хайлт хийх боломжтой.

**1 Газрын зургийн дэлгэцний [ ]-г дарна.**

**2 [Where to? (POI, Street, Town etc.)]-г дарна.**

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

**3 Байршлын нэр, хаяг, утасны дугаар зэргийг оруулаад [Go] дарна.**

- Тэмдэгт оруулах бүрт очих газрын боломжит хувилбарууд дэлгэц дээр гарна.
- Тухайн оруулж буй тэмдэгт болон өмнөх хайлтын түүх, очих газрын түүх, мөн тогтмол ашигладаг хаяг зэрэг дээр үндэслэн боломжит хайлтын хувилбаруудыг дэлгэц дээр гаргана.
- Буруу бичсэн зэргээс шалтгаалан хайлтын үр дүн гарахгүй боломжит зассан хувилбараар хайлт хийсэн үр дүнг дэлгэцээр гаргана.
- Бичсэн тэмдэгтийн тоо нь оруулах боломжтой тооноос давсан үед илүү гарсан тэмдэгтийг систем устгана.

### Холбоотой холбоосууд

Тоо ба үсэг бичих(Х. 29)

## Гэрийнхээ байршлыг очих газраар тохируулах

**1 Газрын зургийн дэлгэцний [ ]-г дарна.**

**2 [ ]-г дарна.**

Маршрутын зааварчилгаа эхлүүлэх үед [**Go**]-г дарна.

### Холбоотой холбоосууд

Тогтмол ашигладаг тохиргоо(Х. 110)

### Гэрийн байршил тохируулах

**1 Газрын зургийн дэлгэцний [ ]-г дарна.**

**2 [ ]-г дарна.**

**3 Газрын зургийг бүртгэх байрлал руу шилжүүлээд [OK]-г дарна.**

## Тогтмол очдог газрыг очих газраар тохируулах

**1 Газрын зургийн дэлгэцний [ ]-г дарна.**

**2 Тохируулах тогтмол очдог хаяг дээр дарна.**

Очих газрын нэр дээр дарсан үед бүтэн маршрутын газрын зураг дэлгэц дээр гарна.

Маршрутын зааварчилгааг эхлүүлэх үед [**Go**]-г дарна.

**МЭДЭЭЛЭЛ**

Бүртгэгдсэн тогтмол очдог газруудыг нэр оруулан хайх боломжтой.

4

Навигаци

### Холбоотой холбоосууд

Тогтмол ашигладаг тохиргоо(Х. 110)

## Очих газрын түүхээс хайлт хийх

**1 Газрын зургийн дэлгэцний [ 🔍 ]-г дарна.**

**2 [Recents]-г дарна.**

**3 Очих газрын түүхээс одоо тохируулах гэж буй очих газар сонгоно.**

Очих газрын нэр дээр товшсон үед маршрутын бүтэн газрын зураг гарна.

[**Go**]-г дарж маршрутын зааварчилгааг эхлүүлнэ.

## Жолоодлогын төлөвлөгөөний дагуу хайх

Ухаалаг утас ашиглан жолоодлогын төлөвлөгөө (очих газар, гарах цаг зэрэг) гаргасан нөхцөлд автомашинд суух үед автомашины навигацийн төлөвлөгөөг жолоочид мэдэгдэж жолоодлогын төлөвлөгөөний дагуу очих газар тохируулах боломжтой.

Тус функцийг ашиглах үед жолоочийн бүртгэл хийсэн байх шаардлагатай.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

**1 Газрын зургийн дэлгэцний [ 🔍 ]-г дарна.**

**2 [Trips]-г дарна.**

**3 Сонгох жолоодлогын төлөвлөгөөг дарна.**

Очих газрын нэр дээр дарсан үед бүтан маршрутын газрын зургийн дэлгэц гарна.

Маршрутын зааварчилгааг эхлүүлэх үед [**Go**]-г дарна.

**МЭДЭЭЛЭЛ**

Автомашиныг очих газраас хол газар зогсоолд байрлуулсан үед автомашины навигацийн систем дээр тохируулсан очих газрын тохиргоог ухаалаг утасны навигацийн аппликейшн рүү илгээх боломжтой.

### Холбоотой холбоосууд

Жолооч бүртгэх (Х. 73)

## Хайлтын үр дүнгийн жагсаалтын дэлгэц

Очих газар хайсан ба хайлтын үр дүн олон хувилбартайгаар гарсан нөхцөлд дэлгэц дээр жагсаалт гарна.




A Өмнөх дэлгэц рүү буцах үед товшино.

B Хайлтад ашигласан үгийг дэлгэцээр харуулна.

C Хайлтын нөхцөл сонголтуудыг харуулна.

D Хайлтын үр дүнгийн жагсаалт харуулна.

- Байршил доторх боломжит очих газрууд мөн дэлгэцээр гарна.

E Газрын зургийн дэлгэц дээр одоо гарч буй жагсаалтын байршлыг харуулна.

- Газрын зургийг хөдөлгөөд [**Search this area**]-г дарсан үед газрын зургийг шилжүүлсэн тухайн хэсгээс хайлт хийнэ.

### Хайлтын сонголтууд

Дэлгэцээр гарах мэдээллийн дэмжээ болон хайлтын үр дүнгийн дарааллыг өөрчлөх боломжтой.

1 **Хайлтын үр дүнгийн жагсаалтын дэлгэцний [ ]-г дарна.**

2 **Хайлтын сонголтуудыг тохируулна.**

3 **[Complete]-г дарж өөрчлөлтийн тохиргоог дуусгана.**

## Замын цэг нэмэх

Өмнө нь очих газар тохируулсан байгаа үед замын цэгээр шинэ очих газар нэмэх боломжтой.

- **Очих газар тохируулсан хэвээр өөр очих газар хайна.**

  Шинэ очих газар тохируулах үед мессеж гарна.

  - [**New destination**] : Одоо тохируулсан байгаа очих газрыг устгаад шинэ очих газар хүртэлх шинэ маршрут хайна.
  - [**Add to route**] : Сонгосон цэгийг замын цэгээр нэмээд очих газар хүртэлх шинэ маршрут хайна.

### МЭДЭЭЛЭЛ

- Газрын зургийн дэлгэцний дурын цэгийг дарж замын цэгээр нэмэх боломжтой.
- Замын цэгийг оролцуулаад 10 хүртэл очих газрыг оруулах боломжтой.
- Хамгийн сүүлд нэмсэн замын цэгийг эхний очих газраар тохируулна. Замын цэгийг засварлан очих газрын дарааллыг өөрчилнө.

### Холбоотой холбоосууд

Очих газар хайх(Х. 183)

Замын цэгүүдийг засварлах(Х. 196)

# Ухаалаг утаснаас очих газар тохируулах

## NaviBridge

NaviBridge* нь ухаалаг утасны олон төрлийн дэмждэг апп дээр хийгдсэн очих газрын хайлтын үр дүнг автомашины навигацийн системд илгээж навигацийн систем дээр автоматаар очих газраар тохируулах "Send To Car" апп юм.




NaviBridge (iOS/Android-д зориулагдсан)-г төлбөргүйгээр татан авах боломжтой.

Татах арга зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг дараах хуудаснаас харна уу.

NaviBridge-н цахим хуудас: https://www.navicon.com/navibridge/support

▶ Холбох арга:

| Холбох арга | iOS төхөөрөмж | Android төхөөрөмж |
|---|---|---|
| Bluetooth® (утасгүй холболт) | ○ | ○ |
| USB (утастай холболт) | ○ | × |

4

Навигаци

▶ Ашиглах боломжтой функцууд:

| Очих газар тохируулах | Олон очих газар | Газрын зураг удирдах | Найзуудтайгаа байршлаа хуваалцах |
|---|---|---|---|
| ○ | ○ | × | × |

*NaviBridge нь DENSO Корпорацид бүртгэлтэй барааны тэмдэгт болно.

## Бүтэн маршрутын газрын зургийн дэлгэц

Очих газрыг тохируулсны дараа бүтэн маршрутын газрын зураг дэлгэцээр гарна. Тус дэлгэц дээр явах маршрутаа сонгох, эсвэл маршрутын мэдээлэл шалгах боломжтой.




- A Очих газрын нэр, эсвэл хаягыг харуулна.
- B Тухайн очих газрыг тогтмол очдог газраар бүртгэх.
- C Очих газрын одоогийн цаг агаарыг харуулна.*1
- D Эхлэх цэгээс очих газар хүртэлх зай аялах хугацаа, очих цагийг харуулна.

  Олон очих газрыг нэгэн зэрэг тохируулсан үед газар тус бүр дээр товшин тухайн газрын эдгээр мэдээллийг харах боломжтой.
- E Маршрутын сонголт гаргах үед товшино.
- F Дуут зааварчилгааны дууг хаана.
- G Очих газрын дэлгэрэнгүй мэдээлэл гаргах үед товшино.
- H Өөр маршрут сонгох үед дарна.
- I Маршрутын зааварчилгааг эхлүүлэх үед товшино. Удаан дарж маршрутын демо зааварчилгаа эхлүүлнэ.

### Холбоотой холбоосууд

Маршрутын зааварчилгаа(Х. 104)

Хайлтын үр дүнгийн жагсаалтын дэлгэц(Х. 187)

Маршрут зааварчилгааны демо үзэх(Х. 192)

Маршрутын сонголт өөрчлөх(Х. 193)

Маршрут өөрчлөх(Х. 194)

Замын цэгүүдийг засварлах(Х. 196)

*1 : Тус функц Connected навигаци ашиглах үед дэлгэцээр гарна. Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

## Маршрут зааварчилгааны демо үзэх

Маршрут зааварчилгаа эхлүүлэхээс өмнө маршрут зааварчилгааны демо үзэх боломжтой.

● **Бүтэн маршрутын дэлгэцний [Go]-г удаан дарна.**

Демог дуусгах үед [ ], [**End**]-г дарах, эсвэл жолоодлогыг эхлүүлнэ.

## Маршрутын сонголт өөрчлөх

Төлбөр хураах цэг, хурдны замтай маршрутаас зайлсхийх зэргээр маршрут хайлтын сонголт өөрчлөх боломжтой.

**1 Бүтэн маршрутын дэлгэцнээс [Route options]-г дарна.**

**2 Хайлтын нөхцөл зэргийг өөрчилнө.**




A Тодорхой төрлийн замаас зайлсхийх/зайлсхийхгүй тохиргоог хийнэ. Зайлсхийх тохиргоог хийсэн үед маршрутын заавварчилгаа тухайн замыг оруулалгүйгээр тохируулагдана.

B Тохируулсан замын цэгүүдийн дарааллыг өөрчлөх үед дарна.

C Маршрут дахь замын цэг нэмэх, устгах, өөрчлөх үед товшино.

### Холбоотой холбоосууд

Маршрутаар дамжин өнгөрөх цэгүүдийг тохируулах(Х. 195)

Замын цэгүүдийг засварлах(Х. 196)

## Маршрут өөрчлөх

Өөр хайлтын нөхцөлтэй олон маршрутаас хүссэн маршрутаа сонгох боломжтой.

1 **Бүтэн маршрутын газрын зургийн дэлгэцний [Alternative route]-г дарна.**

2 **Тухайн маршутаа сонгоод [OK]-г дарна.**

### МЭДЭЭЛЭЛ

- Шинэ маршрут даруй дэлгэцээр гарна.*1
- Бүтэн маршрутын газрын зургийн дэлгэцэн дээр сонгосон маршрутаас өөр маршрутыг дарж хүссэн маршрут руугаа өөрчилж болно.

*1 : Тус функц Connected навигаци ашиглах үед дэлгэцээр гарна. Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

## Маршрутаар дамжин өнгөрөх цэгүүдийг тохируулах

Очих газрыг тохируулсны дараа дамжин өнгөрөх цэгүүдийг тохируулах боломжтой.

**1 Дамжин өнгөрөх тохиргооны дэлгэцний [ ]-г дарна.**




**2 Замын цэгээр нэмэх цэгийг газрын зурган дээр товшоод [Complete]-г дарна.**

[ ]: Товшсон замын цэгийг устгах боломжтой.

## Замын цэгүүдийг засварлах

Замын цэгүүдийг устгах, эсвэл маршрут дахь дарааллыг өөрчлөх боломжтой.

**1 Дэлгэц дээр даран [Move up] болон [Move down]-г гаргаад замын цэгийн дараалал өөрчилнө.**




[]: Товшсон замын цэгийг өөрчлөх боломжтой.

**2 [OK]-г дарна.**

### Холбоотой холбоосууд

Очих газар хайх(Х. 183)

## Маршрут заавварчилгааны дэлгэц

Маршрутын заавварчилгааны үед уулзвар зэрэг цэгүүд дээр дуут болон дэлгэцийн заавварчилгаа өгч маршрутыг ойлгоход хялбар болгодог.




A Автомашины одоогийн байршлаас очих газар хүртэлх зай болон очих цагийг харуулна. Автомашин маршрутаасаа хазайсан үед очих цаг дэлгэцээр гарахгүй ба очих газар хүртэлх шулуун шугамыг заана.

Бүтэн маршрутын газрын зургийн дэлгэц гаргах үед дарна.

B Дараагийн эргэлт хүртэлх зай болон эргэлтийн чигийг заана.

Очих газар хүртэлх эгнээний жагсаалт гаргах үед дарна.

C Очих газар хүртэлх маршрут гаргана.

Маршрутын өнгө солих тухай дэлгэрэнгүйг (→Х. 102)-с харна уу.

D Маршрутын заавварчилгааны үед эргэлт хийх, эсвэл чигээрээ гарах дараагийн уулзварыг харуулна.

E Дарж маршрутын заавварчилгааг дуусгана. Олон очих цэг тохируулсан үед [**Delete destination**]-г дарж бүх очих газар устгаж заавварчилгаа зогсоох, мөн [**Delete next destination**]-г дарж зөвхөн дараагийн очих газрыг устган маршрутын заавварчилгааг үргэлжлүүлэх боломжтой.

- Маршрутыг хайх боломжгүй үед дэлгэц дээр мессеж гарна.
- Дараах нөхцөлд луужингийн дэлгэц гарахгүй:
  - Газрын зургийн дата байхгүй үед

### Холбоотой холбоосууд

Газрын зургийн дэлгэцийн тохиргоо өөрчлөх(Х. 102)

Замын эгнээ харуулах дэлгэц(Х. 198)

## Замын эгнээ харуулах дэлгэц

Маршрутын зааварчилгааны явцад эргэлт хийх уулзварт ойртох үед томруулсан уулзварын дэлгэц гарч ирнэ.

### Уулзварын томруулсан дэлгэц

Эргэлт хийх уулзварт ойртох үед уулзварын зааварчилгаа гарна. Мөн уулзварын дөнгөж өмнө томруулсан уулзварын дэлгэц гарна.

A Явж өнгөрсөн, эргэлт хийсэн замын нэрийг харуулна.

B Одоогийн байрлалаас хэр зайтай байгааг харуулна

C Томруулсан уулзварын дэлгэц хаана.




#### МЭДЭЭЛЭЛ

- Газрын зургийн дата мэдээлэлгүй уулзвар дээр томруулсан уулзварын дэлгэц гарахгүй.
- Дэлгэцээр гарах томруулсан уулзварын харагдах байдал бодит уулзвараас өөр байж болно.
- Маршрутын зааварчилгаа эхлүүлсэн даруйд уулзварын зааварчилгаа ажиллаж эхлэхгүй байж болно.
- Уулзварын томруулсан дэлгэц эрт, эсвэл оройтож гарч болно.
- Эргэлт хийх уулзварууд хоорондоо ойр зайтай үед томруулсан уулзварын дэлгэц үргэлжлэн гарч болно.
- Томруулсан уулзварын дэлгэц нь зөвхөн эргэлт хийх уулзвар дээр гарна. Эргэлт хийх уулзвар хүртэлх уулзварууд дээр уулзварын зааварчилгаа гарахгүй.
- Томруулсан уулзварын дэлгэц болон мэдээллийн дэлгэцээр зааж буй уулзвар хүртэлх зай өөр байж болно.
- Навигацийн системийн дэлгэц болон мэдээллийн дэлгэцээр гарч буй томруулсан уулзварын дэлгэц өөр харагдаж болно.

#### Холбоотой холбоосууд

Зааварчилгааны тохиргоо(Х. 107)

## Томруулсан 3D дэлгэц

Маршрутын зааварчилгааны үед эргэлтийг илүү ойлгоход хялбар болгох үүднээс уулзварын ойр орчмыг харуулсан 3D дэлгэц гарч болно.

**МЭДЭЭЛЭЛ**

Газрын зургийн дата мэдээлэлтэй цэгүүдэд тус мэдээлэл дэлгэцээр гарна.

[×]-г дарж томруулсан дэлгэц цуцлана.



## Маршрут дахин хайх

Маршрутын зааварчилгааны үед (маршрутаас хазайсан байсан ч) маршрут дахин хайх боломжтой.

1 **Газрын зургийн дэлгэцний [∨]-г дарна.**




2 **[Route options], эсвэл [Alternative route]-г дарна.**

3 **Хайлтын нөхцлийг тохируулна.**

4 **[OK] дарна.**

### Холбоотой холбоосууд

Бүтэн маршрутын газрын зургийн дэлгэц(Х. 191)
Маршрутын сонголт өөрчлөх(Х. 193)
Маршрут өөрчлөх(Х. 194)

## Ердийн дуут зааварчилгаа

Автомашин эргэлт, маневр хийх уулзвар, цэгт ойртох үед навигацийн системийн дуут зааварчилгаа олон төрлийн мэдээлэл өгнө.

### МЭДЭЭЛЭЛ

- Дуут зааварчилгаа цаг хугацааны хувьд эрт, эсвэл оройтож дуугарч болно.
- Навигацийн систем одоогийн байрлалыг зөв танихгүй үед навигацийн систем дуут зааварчилгаа өгөхгүй байх, эсвэл уулзварын томруулсан дэлгэц гарахгүй байж болно.

### ⚠ АЮУЛТАЙ

Замын хөдөлгөөний дүрмийг дагаж мөрдөж, ялангуяа дижиталчлагдаагүй замаар явж байхдаа замын нөхцөл байдлыг анхаарч үзнэ үү. Маршрутын зааварчилгаанд нэг чигийн хөдөлгөөн зэрэг мэдээлэл байхгүй байж болно.

### Холбоотой холбоосууд

Зааварчилгааны тохиргоо(Х. 107)

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх (Х. 115)

## Газрын зургийн мэдээллийн сангийн хувилбар ба хамрах хүрээ

Хамрах хүрээ, хууль эрх зүйн мэдээллийг харуулах, газрын зургийн өгөгдлийг шинэчлэх боломжтой.

### ■ Газрын зургийн мэдээлэл харуулах

**1 Үндсэн цэсний []-г дарна.**

**2 [Navigation]-г дарна.**

**3 [Map update]-г дарна.**

**4 Газрын зургийн мэдээллийн дэлгэц гарч байгаа эсэхийг шалгана.**




A Газрын зургийн хамрах хүрээ болон газрын зургийн хувилбарыг гаргана.

B Газрын зураг шинэчлэх үед товшино.

C Хуулийн мэдээллийг гаргах үед товшино

Газрын зургийн дата шинэчлэх тухай та өөрийн Lexus дилерт хандана уу.

# 5 Аудио систем


5-1. Радио ажиллуулах

Радио сонсох ...................... 204

DAB сонсох ......................... 206

Радио антеннтай харьцах .......................................... 208

5-2. Интернет радио

Интернет радио ашиглах 209

5-3. USB флаш ашиглах

USB флаш тоглуулах үеийн анхааруулга ......... 210

USB флашнаас дуу тоглуулах .......................... 212

USB флашнаас видео файл тоглуулах ............... 214

5-4. iPod/iPhone ашиглах

iPod/iPhone тоглуулах үеийн анхааруулга ......... 217

iPod/iPhone тоглуулах ...... 218

5-5. Apple CarPlay ашиглах

Apple CarPlay тоглуулах үеийн анхааруулга.......... 220

Apple CarPlay тоглуулах ... 221

5-6. Android Auto-н ажиллагаа

Android Auto тоглуулах үеийн анхааруулга.......... 223

Android Auto тоглуулах..... 224

5-7. Bluetooth® аудионы ажиллагаа

Bluetooth® аудио тоглуулах анхааруулга .. 226

Bluetooth® аудио тоглуулах ......................... 228

5-8. Miracast®-н ажиллагаа

Miracast® тоглуулах үеийн анхааруулга ......... 231

Miracast® дэмждэг төхөөрөмж холбох ......... 232

Miracast® тоглуулах .......... 233

## Радио сонсох

Давтамжаа сонгон радио сонсох боломжтой.

### МЭДЭЭЛЭЛ

- Стерео дамжуулалт хүлээн авсан үед радио стерео дамжуулалтанд автоматаар шилжинэ.
- Дохио суларсан үед гадио сувгийн салаалалтын тоог бууруулж шуугиан үүсэхээс сэргийлнэ. Сигнал хэт сул болсон үед радио стереогоос моно хүлээн авах горимд шилжинэ.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 [Sources]-г дарна.**

**3 [AM], эсвэл [FM]-г дарна.**

**4 Шаардлагатай үед радио станц сонгох арга хэлбэрээ сонгоно.**

[**Presets**] : Урьдчилан сануулах товчинд бүртгэсэн радио станцаас сонгоно.

[**Station list**] : Радио станцийн жагсаалтаас радио станц сонгоно.

[**Refresh**]*1-г дарж хүлээн авах боломжтой радио станцийг дахин хайна.

[**Direct tune**] : Давтамжийг тоогоор шууд бичиж оруулан радио станц сонгоно.

**5 Шаардлагатай үед хүлээн авч буй радиог удирдана.**

- Дэлгэцнээс удирдах




[**Seek**] : [ ], эсвэл [ ]-г дарж одоогийн байрлалаас дараагийн хүчтэй долгионтой станцийг автоматаар сонгоно. Удаан дарж давтамж өөрчлөнө. Товчийг суллах үед тухайн байрлалаас дараагийн хүчтэй долгионтой станцийг автоматаар сонгоно.

[**Scan**] : Өндөр давтамж руу автоматаар радио станц хайна.

Радио станц хүлээн авсан үед 5 секунд шалгах боломж өгнө. Тухайн станцийг үргэлжлүүлэн сонсох үед товшино.

[  ] : Сонсож буй радио станцийг урьдчилан сануулах товчинд бүртгэнэ. Цуцлах үед дахин товшино.

[  ] : Тохируулах боломжтой зүйлсийг харуулна.

- [**Radio text**][*1] : FM радио станцийн дамжуулж буй радио текстийг гаргана.

Урьдчилан сануулах товч, эсвэл дэд цэсний радио станцийн жагсаалт : Сонгосон радио станц хүлээн авна.

● Жолооны хүрдний товчоор удирдах

**[<]/[>] товч**



**"Presets"** дэлгэцнээс радио станц сонгосон үед урьдчилан сануулсан товчинд сануулсан давтамж, эсвэл радио станцад шилжинэ.

**"Station list"** дэлгэцээс сонгосон үед жагсаалт дахь радио станцад шилжинэ.

**"Direct tune"** дэлгэцээс сонгосон үед тухайн байрлалаас дараагийн хүчтэй долгионтой радио станцад автоматаар шилжинэ.

Удаан дарж давтамж солино. Товч суллах үед тухайн байрлалаас дараагийн хүчтэй долгионтой радио станцад автоматаар шилжинэ.

## Холбоотой холбоосууд

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх (Х. 115)

Эх үүсвэр тус бүрийн дууны түвшин тохируулах (Х. 120)

*1 : Тоноглогдсон автомашинд

## DAB сонсох

Давтамжаа сонгон DAB сонсох боломжтой.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

### МЭДЭЭЛЭЛ

Ухрааж тоглуулах боломжтой хугацаа нь DAB-н бичигдсэн хурд, DAB-н санах ойн хэмжээ, радио дамжуулалт хүлээн авч эхэлсэн цагаас хамаарч өөр байна.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Sources]-г дарна.**

3 **[DAB]-г дарна.**

4 **Шаардлагатай үед радио станц сонгох арга хэлбэрээ сонгоно.**

[**Presets**] : Урьдчилан сануулах товчинд бүртгэсэн радио станцаас сонгоно.

[**Station list**] : Үйлчилгээний жагсаалтаас үйлчилгээ сонгоно.

[**Refresh**]*1-г дарж хүлээн авах боломжтой радио станцийг дахин хайна.

[**Manual tune**] : Радио станцийг гараар сонгоно. [**Ensemble**]/[**Channel**], эсвэл [**Service**]/[**Component**]-г дарж радио станц сонгоно.

5 **Шаардлагатай үед хүлээн авч буй радиог удирдана.**

● Дэлгэцнээс удирдах




[ ]/[ ] : Ухрааж тоглуулах функцийг одоо сонсож буй үйлчилгээг дахин сонсох үед ашиглана. Товчин дээр дарах үед 10 секундээр хойш ухраах, эсвэл урагш гүйлгэнэ. Удаан дарж хурдан хойш ухраах, эсвэл урагш гүйлгэнэ.

[**Live**] : Ухрааж тоглуулах үйлчилгээг цуцлаж одоо дамжуулж буй үйлчилгээг сонсоно.

*1 : Тоноглогдсон автомашинд

[ ] : Тухайн хүлээн авч байгаа үйлчилгээг урьдчилан сануулах товчинд бүртгэнэ. Цуцлах үед дахин товшино.

[ ] : Тохируулах боломжтой зүйлсийг харуулна.

- [**Radio text**] : DAB-н радио текст харуулна.

Урьдчилан сануулах товч, эсвэл дэд цэсний радио станцийн жагсаалт : Сонгосон радио станц хүлээн авна.

● Жолооны хүрдний товчоор удирдах

**[<]/[>] товч**



**"Presets"** дэлгэцнээс сонгосон үед урьдчилан сануулсан товчинд сануулсан дарааллаар үйлчилгээ солигдоно.

**"Station list"** дэлгэцнээс сонгосон үед станцийн жагсаалтын дагуу үйлчилгээ солигдоно.

**"Manual tune"** дэлгэцнээс сонгосон үед тухайн байрлалд ойрхон, хүчтэй долгионтой үйлчилгээг автоматаар сонгоно.

Удаан дарж үйлчилгээ солино. Товч суллах үед тухайн байрлалаас дараагийн хүчтэй долгионтой үйлчилгээг автоматаар сонгоно.

## Холбоотой холбоосууд

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх (Х. 115)

Эх үүсвэр тус бүрийн дууны түвшин тохируулах (Х. 120)

5

Аудио систем

## Радио антеннтай харьцах

Радио долгион хүлээн авах антенн нь тээшний хэсгийн хажуу шил болон хойд спойлерт суурилагдсан байдаг.

### ⚠ АНХААР

Антенн суурилагдсан шилийг (дотор тал) антенны утасны дагуу чийгтэй алчуураар зөөлөн арчина. Антенн гэмтээх тул шил толь цэвэрлэгч, бусад цэвэрлэгээний бодис ашиглаж болохгүй.

Тээшний хэсгийн антенны утсанд дараах зүйлсийг тогтоож болохгүй. Эдгээр нь долгион сулруулах, мөн шуугиан үүсгэнэ.

- Металлийн агуулгатай цонхны хуулга
- Бусад металл эд зүйл (Lexus-н оригинал тоноглолоос бусад зүйлс)

## Интернет радио ашиглах

AM/FM/DAB сонсох үед тухайн дууны нэр, хавтасны зураг, радио станцийн лого зэрэг мэдээллийг авах боломжтой. Тус мэдээллийг Gracenote® серверээс DCM, эсвэл Wi-Fi®-р дамжуулан авч дэлгэцээр гаргах боломжтой.

Интернетэд DCM, эсвэл Wi-Fi®-р холбогдсон үед радио сигнал муудахад дамжуулалтын холболтыг интернет болгон шилжүүлэх боломжтой. Энэ нь нэг радио станцийг үргэлжлүүлэн сонсох боломж бүрдүүлнэ.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

### МЭДЭЭЛЭЛ

- Бүх радио станцийг дэмжихгүй байж болно.
- Радио сигнал муудах үед интернет радио дамжуулалтанд шилжинэ.
- Интернет радио ашиглах үед тодорхой хугацааны турш долгион сайтай аналог радио дамжуулалт хүлээн авсан нөхцөлд автоматаар аналог радиод шилжинэ.
- Интернет радио сонсох үед интернет радио асааж унтраах, эсвэл тохиргоог автомат болон гараар тохируулах тохиргоог хийнэ.

### Холбоотой холбоосууд

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх (Х. 115)

## USB флаш тоглуулах үеийн анхааруулга

USB флаш тоглуулах үед дараах мэдээлэлд онцгой анхаарна.

### МЭДЭЭЛЭЛ

- Тоглуулах үед USB флаш сугалах, төхөөрөмжийн холболт салгасан нөхцөлд шуугиан гарч болно.
- USB флаш холбосон ба өөр эх үүсвэрээс USB флашинд эх үүсвэр шилжүүлсэн үед флаш дахь эхний файлыг тоглуулж эхлэнэ. Өмнө нь тоглуулж байсан USB флаш (контент өөрчлөөгүй) дахин холбосон үед өмнө нь тоглуулж байсан дуунаас үргэлжлүүлэн тоглуулна.
- Дэмждэггүй форматтай файл уншуулах нь ажиллагаанд саад учруулна.
- USB салаалагч ашиглан олон төхөөрөмж холбосон үед эхэлж таниснаас бусад төхөөрөмжийг танихгүй ба ашиглах боломжгүй.

### ⚠ АЮУЛТАЙ

Аюулгүйн үүднээс жолооч жолоодлогын үед USB флаш удирдаж болохгүй.

### ⚠ АНХААР

- Бүхээг дотор USB флаш үлдээж болохгүй. Бүхээг хэт халсан нөхцөлд USB флашинд доголдол үүсгэх аюултай.
- Холбосон USB флаш доош дарах, хөндлөн хөшихийг хориглоно. USB флаш, порт гэмтэх аюултай.
- Портод гадны зүйл орохоос сэргийлнэ. USB флаш, порт гэмтэх аюултай.

### ■ MP3/WMA/AAC/WAV/FLAC/ALAC/Ogg Vorbis файл тоглуулах

MP3/WMA/AAC/WAV/FLAC/ALAC/Ogg Vorbis файлтай USB флаш холбосон үед USB флашны файлыг эхлээд шалгана.

USB флаш дээр MP3/WMA/AAC/WAV/FLAC/ALAC/Ogg Vorbis-с өөр файл болон шаардлагагүй файл хадгалахгүй байх нь зүйтэй. Ингэснээр USB флаш хурдан шалгана.

### МЭДЭЭЛЭЛ

MP3/WMA/AAC/WAV/FLAC/ALAC/Ogg Vorbis файланд зориулагдсан олон төрлийн хөрвүүлэгч программ хангамж байдаг. Хөрвүүлэг программаас хамаарч файлын формат, аудио чанар алдагдалт, эсвэл шуугиан үүсэх, тоглуулах боломжгүй байх зэрэг нөхцөл байдал үүсч болно.

**⚠ АНХААР**

Файланд буруу өргөтгөл ашиглаж болохгүй. Файлын агуулгатай тохирохгүй өргөтгөл нэмэх нь файл буруу танигдахад хүргэнэ. Энэ нөхцөлд хүчтэй шуугиан үүсэх ба спикер гэмтээх аюултай.

Буруу жишээ:

- MP3 биш файланд ".mp3" өргөтгөл нэмэх
- WMA биш файланд ".wma" өргөтгөл нэмэх

## Холбоотой холбоосууд

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх (Х. 115)

Ашиглах боломжтой медиа(Х. 306)

Форматын мэдээлэл(Х. 306)

USB флашнаас тоглуулах боломжтой видео датаны мэдээлэл(Х. 309)

USB санах ойн тухай мэдээлэл(Х. 313)

## USB флашнаас дуу тоглуулах

USB портод холбосон USB флаш дуу тоглуулах боломжтой. USB флаш холбогдох үед эх үүсвэр сонгох дэлгэц дээр төхөөрөмжийн нэртэй товч гарна. Тус товч зарим төхөөрөмж дээр гарахгүй байж болно.

USB флаш холбоно.

1 **Үндсэн цэсний []-г дарна.**

2 **[Sources]-г дарна.**

3 **Төхөөрөмжийн нэр, эсвэл [USB]-г дарна.**

USB флаш дээр видео файл байхгүй үед **5** руу шилжинэ.

4 **[Music]-г дарна.**

5 **Шаардлагатай үед USB флашийг удирдана.**

● Дэлгэцнээс удирдах




[] : Дурын дууг тоглуулах.

Товч дарах бүрт дурын файл эсвэл дуу тоглуулах, дурын дуу тоглуулахыг цуцлах, мөн одоогийн хавтас, цомог доторх дурын дууг тоглуулах тохиргоонд солигдоно.

[] : Одоогийн дуу, эсвэл файлыг эхнээс нь тоглуулна. Дуу, эсвэл файлны эхэнд байгаа үед өмнөх файлыг эхнээс нь тоглуулна.

Удаан дарж хурдан ухраана. Суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

[] : Түр зогсоох.

[] : Тоглуулах.

[] : Файл, эсвэл дуу солино.

Удаан дарж хурдан гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

[  ] : Давтан тоглуулна.

Товч дарах бүрт одоогийн файл, эсвэл дууг давтан тоглуулах, эсвэл одоогийн хавтас, эсвэл цомог доторх дууг давтан тоглуулах, эсвэл бүх файл, дууг давтан тоглуулах горимд солигдоно.

[  ] : Тохиргоо хийх боломжтой зүйлсийг харуулна.

Дэд цэсний жагсаалт : Дараах нөхцлөөс дуу сонгоно.

- [**Artists**] : Дуучны нэрнээс дуу сонгоно.
- [**Albums**] : Цомгийн нэрнээс дуу сонгоно.
- [**Folders**] : Хавтасны нэрнээс дуу сонгоно.
- [**Songs**] : Дууны нэрнээс дуу сонгоно.
- [**Genres**] : Дууны төрлөөс дуу сонгоно.
- [**Composers**] : Хөгжмийн зохиолчийн нэрнээс дуу сонгоно.

● Жолооны хүрдний товчоор удирдах

**[<]/[>] товч**

Дуу, эсвэл файл солино.

Удаан дарж арагш болон урагш хурдан гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.



## Холбоотой холбоосууд

USB портод холбох(Х. 40)

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх (Х. 115)

Эх үүсвэр тус бүрийн дууны түвшин тохируулах (Х. 120)

## USB флашнаас видео файл тоглуулах

USB портод USB флаш холбон видео файл тоглуулах боломжтой. USB флаш холбогдох үед эх үүсвэр сонгох дэлгэц дээр төхөөрөмжийн нэртэй товч гарна. Зарим төхөөрөмж дээр тус товч гарахгүй байж болно.

USB флаш холбоно.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**
2 **[Sources]-г дарна.**
3 **Төхөөрөмжийн нэр, эсвэл [USB]-г дарна.**
4 **[Video]-г дарна.**
5 **Шаардлагатай үед USB флашийг удирдана.**

● Бүтэн дэлгэцийн үед удирдах

Дэлгэц дээр товшин удирдах товч гаргана.




[ ] : Одоо тоглуулж буй файлыг эхнээс нь тоглуулна. Файлын эхэнд байгаа үед өмнөх файлыг эхнээс нь тоглуулна.

Удаан дарж хурдан ухраана. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

[ ] : Видеог түр зогсооно.

[ ] : Видеог тоглуулна.

[ ] : Файл солино.

Удаан дарж хурдан гүйлгэнэ. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

Видеог түр зогсоосон үед удаан дарж удаанаар тоглуулна.

[**Move**] : Удирдлагын товчийг шилжүүлнэ.

Видеотой давхцаж үзэхэд хүндрэлтэй үед товчийг өөр байрлалд шилжүүлнэ.

[ ] : Удирдлагын дэлгэц гаргана.

● Удирдлагын дэлгэцнээс удирдах

Бүтэн дэлгэцний [ ]-г дарж удирдлагын дэлгэц гаргана.




[ ] : Одоо тоглуулж буй файлыг эхнээс нь тоглуулна. Файлын эхэнд байгаа үед өмнөх файлыг эхнээс нь тоглуулна.

Удаан дарж хурдан ухраана. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

[ ] : Видеог түр зогсооно.

[ ] : Видеог тоглуулна.

[ ] : Файл солино.

Удаан дарж хурдан гүйлгэнэ. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

Видеог түр зогсоосон үед удаан дарж удаанаар тоглуулна.

[ ] : Бүтэн дэлгэцэнд шилжүүлнэ.

[ ] : Тохируулах боломжтой зүйлсийг харуулна.

Хавтас, эсвэл дэд цэсний файлын нэр : Хавтас, эсвэл дэд цэсний файлын нэр дээр дарж тоглуулах файл солино.

● Жолооны хүрдний товчоор удирдах

**[<]/[>] товч**

Файл солино.

Удаан дарж видеог арагш, эсвэл урагш хурдан гүйлгэнэ. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ. Видеог түр зогсоосон үед [>] товч удаан дарж видеог удаанаар тоглуулна.



## Холбоотой холбоосууд

USB портод холбох(Х. 40)

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх (Х. 115)

5
Аудио систем

Дэлгэцийн горим солих (Х. 118)
Дүрсний чанар тохируулах (Х. 119)
Эх үүсвэр тус бүрийн дууны түвшин тохируулах (Х. 120)

## iPod/iPhone тоглуулах үеийн анхааруулга

iPod/iPhone тоглуулах тухай дараах мэдээлэлд онцгой анхаарна.

### МЭДЭЭЛЭЛ

- Портоос салгах, эсвэл холбогдсон төхөөрөмж iPod/iPhone горимд байгаа үед салгах нь шуугиан үүсгэж болно.
- USB салаалагч ашиглан олон төхөөрөмж холбосон үед эхэлж танихнаас бусад төхөөрөмжийг танихгүй.
- iPod/iPhone холбоотой ба бусад эх үүсвэрээс iPod/iPhone-д шилжүүлэх үед өмнө тоглуулж байсан дууг үргэлжлүүлэн тоглуулна. Зарим төхөөрөмж дээр үргэлжлүүлэн тоглуулахгүй байж болно.

### АЮУЛТАЙ

Аюулгүйн үүднээс жолооч жолоодлогын үед iPod/iPhone-г удирдаж болохгүй.

### АНХААР

- Бүхээгт iPod/iPhone үлдээж болохгүй. Бүхээг халуун болсон үед iPod/iPhone-д доголдол үүсгэх аюултай.
- iPod/iPhone-г доош дарах, эсвэл хөндлөн хөшиж болохгүй. iPod/iPhone, эсвэл порт гэмтэх аюултай.
- Портод гадны биет орохоос сэргийлнэ. iPod/iPhone, эсвэл порт гэмтэх аюултай.

### Холбоотой холбоосууд

iPod-н мэдээлэл(Х. 310)

## iPod/iPhone тоглуулах

USB портод холбосон iPod/iPhone-н дууг тоглуулах боломжтой. iPod/iPhone холбогдсон үед эх үүсвэр сонгох дэлгэц дээр төхөөрөмжийн нэртэй товч гарна. Тус товч зарим төхөөрөмж дээр гарахгүй байж болно.

### МЭДЭЭЛЭЛ

- Холбосон iPod/iPhone-н загвар, үеэс хамаарч хавтасны зураг бүдэг харагдах, эсвэл дэлгэц удаан гүйж болно.
- Холбосон iPod/iPhone-н загвар, үеэс хамаарч зарим үйлдлийг ашиглах боломжгүй байх, эсвэл функцийн ажиллагаа өөр байж болно.

iPod, эсвэл iPhone-г холбоно.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Sources]-г дарна.**

3 **Төхөөрөмжийн нэр, эсвэл [USB]-г дарна.**

4 **Шаардлагатай үед iPod/iPhone-г удирдана.**

- Дэлгэцнээс удирдах




[ ] : Дууг солиж тоглуулах.

Товч дарах бүрт дууг солиж тоглуулах горим өөрчлөгдөнө.[*1]

[ ] : Одоогийн тоглож буй дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхэнд байгаа үед өмнө дууг эхнээс нь тоглуулна.

Удаан дарж хурдан ухраана. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

[ ] : Түр зогсоох.

[ ] : Тоглуулах.

[ ▷| ] : Дуу солих.

Удаан дарж хурдан гүйлгэнэ. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

[ ⇄ ] : Дахин тоглуулах.

Товч дарах бүрт дахин тоглуулах тохиргоо өөрчлөгдөнө.*1

[ ••• ] : Тохируулах боломжтой зүйлсийг харуулна.

Дэд цэсний жагсаалт : Дараах нөхцлөөс дуу сонгоно.

- [**Playlists**] : Тоглуулах жагсаалтаас дуу сонгоно.
- [**Artists**] : Дуучны нэрнээс дуу сонгоно.
- [**Albums**] : Цомгийн нэрнээс дуу сонгоно.
- [**Songs**] : Дууны нэрнээс дуу сонгоно.
- [**Genres**] : Дууны төрлөөс дуу сонгоно.
- [**Composers**] : Хөгжмийн зохиогчийн нэрнээс дуу сонгоно.
- [**Radio**] : Радио станцаас дуу сонгоно.
- [**Audiobooks**] : Аудио номны нэрнээс дуу сонгоно.
- [**Podcasts**] : Podcast-н нэрнээс дуу сонгоно.

● Жолооны хүрдний товчоор удирдах

**[<]/[>] товч**

Дуу солих.

Удаан дарж хурдан арагш, урагш гүйлгэнэ. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.



## Холбоотой холбоосууд

USB портод холбох(Х. 40)

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх (Х. 115)

Эх үүсвэр тус бүрийн дууны түвшин тохируулах (Х. 120)

*1 : Тухайн холбосон төхөөрөмжөөс хамаарч дуу холиж тоглуулах, давтан тоглуулах дараалал өөр байна.

## Apple CarPlay тоглуулах үеийн анхааруулга

Apple CarPlay тоглуулах тухай дараах мэдээлэлд онцгой анхаарал хандуулна.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

### МЭДЭЭЛЭЛ

- Android Auto холбогдсон үед тус функцийг ашиглах боломжгүй.
- Apple CarPlay USB-р холбогдсон үед холбогдсон төхөөрөмжийг салгах нь шуугиан үүсгэж болно.
- iPhone холбогдсон ба өөр эх үүсвэрээс Apple CarPlay-д эх үүсвэр шилжүүлэх үед өмнө нь тоглуулж байсан дуунаас үргэлжлүүлж тоглуулна.

### ⚠ АЮУЛТАЙ

Аюулгүйн үүднээс жолооч жолоодлогын үед iPhone утас удирдаж болохгүй.

### ⚠ АНХААР

- Бүхээгт iPhone үлдээж болохгүй. Бүхээгний хэм халсан үед iPhone-д доголдол үүсгэх аюултай.
- Холбогдсон iPhone-г доош дарах, хөндлөн хөшиж болохгүй. iPhone, эсвэл порт гэмтэх аюултай.
- Портод гадны биет орохоос сэргийлнэ. iPhone, эсвэл порт гэмтэх аюултай.

### Холбоотой холбоосууд

Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга(Х. 155)

## Apple CarPlay тоглуулах

USB порт, эсвэл утасгүй холболтоор холбосон iPhone утасны дууг тоглуулах боломжтой. Apple CarPlay холбогдсон үед эх үүсвэр сонгох дэлгэц дээр төхөөрөмжийн нэртэй товч гарна. Тус товч зарим дэлгэц дээр гарахгүй байж болно.

### МЭДЭЭЛЭЛ

- Холбосон iPhone утасны загвар, үеэс хамаарч зарим функцийг ашиглах боломжгүй, эсвэл өөрөөр ажиллаж болно.
- Дуу хэвийн тоглуулагдахгүй үед iOS-г сүүлийн хувилбарт шинэчилнэ. Шинэчлэлт нь тус асуудлыг шийдвэрлэх боломжтой.

Apple CarPlay холбох.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Sources]-г дарна.**

3 **[Apple CarPlay] (төхөөрөмжийн нэр)-г дарна.**

4 **Apple CarPlay-г удирдана.**

- Дэлгэцнээс удирдах




[ ] : Дууг холиж тоглуулах.

Товч дарах бүрт холиж тоглуулах тохиргоо өөрчлөгдөнө.*1

[ ] : Одоо тоглуулж буй дууг эхнээс нь тоглуулна.

Дууны эхэнд байгаа үед өмнөх дууг эхнээс нь тоглуулж эхлэнэ.

Удаан дарж хурдан буцаана. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[ ] : Түр зогсоох.

[ ] : Тоглуулах.

[ ] : Дуу солих.

Удаан дарж хурдан урагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[ ] : Дахин тоглуулах.

Товч дарах бүрт дахин тоглуулах тохиргоо өөрчлөгдөнө.*1

[ ] : Тохиргоо хийх боломжтой зүйлсийг харуулна.

[**Open CarPlay**] : Apple CarPlay-н дэлгэц гаргана.

● Жолоны хүрдний товчоор удирдах

**[<]/[>] товч**

Дууг солих.

Удаан дарж хурдан урагш, эсвэл арагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.



## Холбоотой холбоосууд

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх (Х. 115)

Эх үүсвэр тус бүрийн дууны түвшин тохируулах (Х. 120)

Бүртгэлгүй ухаалаг утсаар Apple CarPlay ашиглах(Х. 158)

Бүртгэгдсэн утсаар Apple CarPlay ашиглах(Х. 161)

Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 123)

*1 : Холбосон төхөөрөмжөөс хамаарч дууг холиж, эсвэл давтан тоглуулах дараалал өөрчлөгдөнө.

## Android Auto тоглуулах үеийн анхааруулга

Android Auto тоглуулах тухай дараах мэдээлэлд онцгой анхаарал хандуулна.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

### МЭДЭЭЛЭЛ

- Apple CarPlay холбогдсон үед тус функцийг ашиглах боломжгүй.
- Android Auto-р холбогдсон үед холбогдсон төхөөрөмжийг салгах нь шуугиан үүсгэж болно.
- Android төхөөрөмж холбогдсон ба өөр эх үүсвэрээс Android Auto-д эх үүсвэр шилжүүлэх үед өмнө нь тоглуулж байсан дуунаас үргэлжлүүлж тоглуулна.

### АЮУЛТАЙ

Аюулгүйн үүднээс жолооч жолоодлогын үедAndroid төхөөрөмж удирдаж болохгүй.

### АНХААР

- Бүхээгт Android төхөөрөмж үлдээж болохгүй. Бүхээгний хэм халсан үед Android төхөөрөмжид доголдол үүсгэх аюултай.
- Холбогдсон Android төхөөрөмжийг доош дарах, хөндлөн хөшиж болохгүй. Android төхөөрөмж, эсвэл порт гэмтэх аюултай.
- Портод гадны биет орохоос сэргийлнэ. Android төхөөрөмж, эсвэл порт гэмтэх аюултай.

### Холбоотой холбоосууд

Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга(Х. 155)

5

Аудио систем

## Android Auto тоглуулах

USB портод холбосон Android төхөөрөмжийн дуу тоглуулна. Android төхөөрөмж холбогдсон үед эх үүсвэр сонгох дэлгэц дээр төхөөрөмжийн нэртэй товч гарна. Зарим төхөөрөмж дээр тус товч гарахгүй байж болно.

Android Auto холбох.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Sources]-г дарна.**

3 **[Android Auto] (төхөөрөмжийн нэр)-г дарна.**

4 **Шаардлагатай үед тоглуулж буй Android Auto-г удирдана.**

● Дэлгэцнээс удирдах




[ ] : Одоо тоглож буй дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхэнд байгаа үед өмнөх дууг эхнээс нь тоглуулна.

[ ] : Түр зогсоох.

[ ] : Тоглуулах.

[ ] : Дуу солих.

[ ] : Тохиргоо хийх боломжтой зүйлсийг харуулна.

[**Open Android Auto**] : Android Auto-н дэлгэц нээнэ.

● Жолооны хүрдний товчоор удирдах

**[<]/[>] товч**

Дуу солино.



## Холбоотой холбоосууд

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх (Х. 115)

Эх үүсвэр тус бүрийн дууны түвшин тохируулах (Х. 120)

Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 123)

## Bluetooth® аудио тоглуулах анхааруулга

Bluetooth® аудио тоглуулах үед дараах мэдээлэлд онцгой анхаарна.

### МЭДЭЭЛЭЛ

- Гар утас, бусад зөөврийн Bluetooth® аудио тоглуулагч (зөөврийн төхөөрөмж) мултимедиа системд холбон ашиглахаас өмнө төхөөрөмжийг бүртгэх шаардлагатай.
- Зөөврийн төхөөрөмжийн загвараас хамаарч зарим функцийг ажиллагаа хязгаарлагдаж болно.
- Apple CarPlay-г утасгүй холболтоор холбосон үед тус функцийг ашиглах боломжгүй*1.
- Утасгүй төхөөрөмжтэй зэрэг ашигласан нөхцөлд холболтууд хоорондоо нөлөөлж болно.
- Мултимедиа системийн тохиргоон дээр Wi-Fi® функцийг идэвхжүүлсэн үед Bluetooth® аудионы дуунд нөлөөлөл орж болно.

### ⚠ АЮУЛТАЙ

- Аюулгүйн үүднээс жолооч жолоодлогын үед зөөврийн төхөөрөмж удирдаж болохгүй.
- Автомашины Bluetooth® холболтын антенн нь автомашины урд удирдлагын самбарын ойр байрладаг.

  Дотуур суулгасан зүрхний пэйсмейкер, зүрхний ажиллагааг дахин синхрончлох эмчилгээний пэйсмейкер, эсвэл дефибриллятор суулгац эмчилгээнээс бусад эмчилгээний электрон төхөөрөмжтэй хүн эдгээр төхөөрөмжийн ажиллагаанд электрон долгионы үзүүлэх сөрөг нөлөөг урьдчилан өөрийн эмч болон эмчилгээний төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс тодруулна.

### ⚠ АНХААР

- Бүхээгт зөөврийн төхөөрөмж үлдээж болохгүй. Бүхээг халсан үед зөөврийн төхөөрөмжинд доголдол үүсгэх аюултай.
- Зөөврийн төхөөрөмжийг мултимедиа системийн ойрхон ашиглаж болохгүй. Хэт ойртуулах нь дууны чанар буурах, алдагдахад хүргэнэ.

### Холбоотой холбоосууд

Wi-Fi® тохиргоо өөрчлөх(Х. 121)

Bluetooth® мэдээлэл(Х. 314)

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Bluetooth® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 134)
Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмж бүртгэх(Х. 139)

## Bluetooth® аудио тоглуулах

Зөөврийн төхөөрөмж холбосон үед төхөөрөмжийг шууд удирдалгүйгээр ашиглах боломжтой.

### МЭДЭЭЛЭЛ

- Холбосон төхөөрөмжөөс хамаарч дараах мэдээлэл гарахгүй байж болно.
  - Хавтасны нэр
  - Дууны нэр
  - Цомгийн нэр
  - Дуучны нэр
  - Тоглуулах хугацаа
  - Нийт хугацаа
  - Дурын дуу
  - Давтан тоглуулах
  - Тоглуулах/түр зогсоох
  - Дууг дээш/доош
- Холбосон төхөөрөмжөөс хамаарч дараах зүйлс үүсч болно.
  - Мултимедиа системээс удирдах боломжгүй байж болно.
  - Үйлдэл, эсвэл дууны түвшин өөр байж болно.
  - Дууны мэдээлэл, хугацаа зэрэг мэдээлэл мултимедиа систем болон зөөврийн төхөөрөмжөөр өөр гарч болно.
  - Тоглуулж дууссан үед холболт салж болно.
- Удаан тоглуулсан үед дуу дараагийн дуунд шилжиж болно.
- Холболт үүсэх үед зөөврийн төхөөрөмжөөс хамаарч дууны түвшин өөр байж болно.

Өөр зөөврийн төхөөрөмж мултимедиа системд холбогдож болно.

1 **Үндсэн цэсний [  ]-г дарна.**

2 **[Sources]-г дарна.**

3 **Төхөөрөмжийн нэр, эсвэл [Bluetooth]-г дарна.**

4 **Bluetooth® аудиог удирдана.**

- Дэлгэцнээс удирдах




[  ] : Дурын дуу тоглуулах.

Товч дарах үед дурын дуу тоглуулах тохиргоог өөрчилнө.*1

[  ] : Одоо тоглуулж буй дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхэнд байгаа үед өмнөх дууг эхнээс нь тоглуулна.

Удаан дарж хурдан ухраана. Сулласан үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[  ] : Түр зогсооно.

[  ] : Тоглуулна.

[  ] : Дууг солино.

Удаан дарж хурдан урагш гүйлгэнэ. Сулласан үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[  ] : Дахин тоглуулна.

Товч дарах бүрт дахин тоглуулах тохиргоог өөрчилнө.*1

[  ] : Тохиргоо хийх боломжтой зүйлсийг харуулна.

Дэд цэсний хавтасны нэр, эсвэл дууны нэрийг гаргана : Хавтасны нэр, эсвэл дууны нэрийг дарж тоглуулах файлыг солино.

● Жолооны хүрдний товчоор удирдах

**[<]/[>] товч**

Дуу солино.

Удаан дарж хурдан урагш, эсвэл арагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.



*1 : Утасны загвараас хамаарч дурын дуу, эсвэл дахин тоглуулах тохиргооны дараалал өөрчлөгдөнө.

## Холбоотой холбоосууд

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх (Х. 115)

Эх үүсвэр тус бүрийн дууны түвшин тохируулах (Х. 120)

Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 123)

## Miracast® тоглуулах үеийн анхааруулга

Miracast® тоглуулах үед дараах мэдээлэлд онцгой анхаарал хандуулна.

### МЭДЭЭЛЭЛ

- Төхөөрөмж Wi-Fi® (P2P горим)-р холбогддог.
- Утасгүй холболтоор Apple CarPlay холбогдсон үед тус функцийг ашиглах боломжгүй*1.
- Тус функц нь боломжит хамгийн өндөр гүйцэтгэлээр холболт хийх функц болно.
- Төхөөрөмжөөс хамаарч Miracast®-н нэр өөр байж болно.
- Wi-Fi® холболтыг идэвхжүүлсэн үед Wi-Fi® сүлжээ болон Miracast® нь тус тусын дамжуулалтанд нөлөөлж болно. Үүнээс үүдэн дүрс хэлбэрээ алдах, аудио дуугаралт муудаж болно.

### АЮУЛТАЙ

Жолоодлогын үед ухаалаг утас, таблет холбох, ажиллуулахыг хориглоно.

### АНХААР

Бүхээгт ухаалаг утас, таблет үлдээж болохгүй. Бүхээг хэт халсан үед ухаалаг утас, таблетанд доголдол үүсгэх аюултай.

### Холбоотой холбоосууд

Wi-Fi® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 150)

Wi-Fi® тохиргоо өөрчлөх(Х. 121)

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх (Х. 115)

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

## Miracast® дэмждэг төхөөрөмж холбох

Miracast® дэмждэг Android ухаалаг утас, таблет холбох боломжтой.

Тухайн төхөөрөмж Miracast® дэмждэг эсэхийг төхөөрөмжийн гарын авлага, бусад бичиг баримтаас шалгана уу.

1 **Үндсэн цэсний []-г дарна.**

2 **[Sources]-г дарна.**

3 **[Miracast®]-г дарна.**

4 **Miracast® дэмждэг төхөөрөмж холбох боломж бүрдүүлнэ.**




- Төхөөрөмжийг хэрхэн ажиллуулах тухай дэлгэрэнгүй мэдээллийг төхөөрөмжийн гарын авлагаас харна уу.
- Холболт амжилтгүй болсон үед холбох үйлдлийг дахин эхнээс нь хийж гүйцэтгэнэ.

5 **Төхөөрөмжийн нэрийг шалгаад [OK] дарна.**

### Холбоотой холбоосууд

Wi-Fi® тохиргоо өөрчлөх(Х. 121)

## Miracast® тоглуулах

Мултимедиа систем дээр ухаалаг утас, таблетны дуу, хөгжим тоглуулах боломжтой.

### МЭДЭЭЛЭЛ

- Холбосон төхөөрөмжөөс хамаарч Miracast®-н дууны түвшин өөр байж болно.
- Wi-Fi® холболт салах үед аудио унтарна.

Miracast® дэмждэг төхөөрөмж холбоно.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Sources]-г дарна.**

3 **[Miracast®]-г дарна.**

4 **Тоглуулж буй Miracast® контентийг удирдана.**

- Бүтэн дэлгэцнээс удирдах

  Удирдлагын товч гаргах үед дэлгэц дээр товшино.




  [ ] : Удирдлагын дэлгэц гаргана.

- Удирдлагын дэлгэцнээс удирдах

  Бүтэн дэлгэцний [ ]-г дарж удирдлагын дэлгэц гаргана.




  [ ] : Тохиргоо хийх боломжтой зүйлсийг харуулна.

  [ ] : Бүтэн дэлгэцэнд шилжүүлнэ.

  [**Disconnect**] : Miracast®-г салгана.

  Аудио унтарна.

## Холбоотой холбоосууд

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх (Х. 115)
Дэлгэцийн горим солих (Х. 118)
Дүрсний чанар тохируулах (Х. 119)
Эх үүсвэр тус бүрийн дууны түвшин тохируулах (Х. 120)

# 6 Арын суудлын энтертейнмент систем*


6-1. Арын суудлын энтертейнмент системээр радио удирдах

Арын суудлын энтертейнмент системээр радио сонсох 236

Арын суудлын энтертейнмент системээр DAB сонсох .... 237

6-2. Арын суудлын энтертейнмент системээс USB удирдах

Арын суудлын энтертейнмент системээр USB флашны дуу тоглуулах.................... 239

Арын суудлын энтертейнмент системээр USB флашны видео файл тоглуулах .... 241

Арын суудлын энтертейнмент системээр iPod, эсвэл iPhone-н дуу тоглуулах ... 243

6-3. Арын суудлын энтертейнмент системээс ухаалаг утасны дуу тоглуулах

Арын суудлын энтертейнмент систем дээр Apple CarPlay-н хөгжим тоглуулах............ 245

Арын суудлын энтертейнмент системээр Android Auto-н дуу тоглуулах ................ 247

6-4. Арын суудлын энтертейнмент системээр Bluetooth® аудио удирдах

Арын суудлын энтертейнмент системээс холбогдсонBluetooth® төхөөрөмжийн дуу тоглуулах.......................... 249

6-5. Арын суудлын энтертейнмент холбогдсон HDMI удирдах

Арын суудлын энтертейнмент системээр арын суудлын HDMI медиа тоглуулах.......................... 251

6-6. Арын суудлын энтертейнмент системээс холбогдсон Miracast® төхөөрөмж удирдах

Арын суудлын энтертейнмент системээр Miracast® тоглуулах.......................... 252

Арын суудлаас Miracast® ашиглах үеийн анхааруулга...................... 253

Арын суудлаас Miracast®-д холбогдох...................... 254

Арын суудлын энтертейнмент систем дээр арын суудлын Miracast® тоглуулах ........ 255

Арын суудлаас Miracast® салгах................................ 256


*:Тоноглогдсон автомашинд

## Арын суудлын энтертейнмент системээр радио сонсох

**1 Дараах аль нэг үйлдлээр эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын суудлын дэлгэцний [**SOURCE**]-г дарна.

Эх үүсвэрийн дэлгэц гарна.

**2 [AM], эсвэл [FM]-г сонгоно.**

Радио хүлээн авах дэлгэц гарна.

**3 Радиог удирдана.**

- Арын суудлын дэлгэц




[**Tune**] : [ ], эсвэл [ ]-г дарж долгион солино.

Удаан дарж долгион үргэлжлүүлэн солино. Суллах үед тухайн байрлалаас ойр, хүчтэй долгионтой радио станцийг автоматаар сонгоно.

[**Ch**] : [ ], эсвэл [ ]-г дарж урьдчилан сануулах товчинд сануулсан радио станц сонгоно.

- Арын олон үйлдэлт удирдлагын самбар*1




[**Ch**] : [ ], эсвэл [ ]-г дарж урьдчилан сануулах товчинд сануулсан радио станц сонгоно.

[**Tune**] : [ ], эсвэл [ ]-г дарж долгион солино.

Удаан дарж долгион үргэлжлүүлэн солино. Суллах үед тухайн байрлалаас ойр, хүчтэй долгионтой радио станцийг автоматаар сонгоно.

### Холбоотой холбоосууд

Радио сонсох(Х. 204)

*1 : Тоноглогдсон автомашинд

## Арын суудлын энтертейнмент системээр DAB сонсох

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

**1 Дараах аль нэг үйлдлээр эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.**

● Үндсэн цэсний [ ]-г сонгоно.

● Арын суудлын дэлгэцний [**SOURCE**]-г дарна.

Эх үүсвэрийн дэлгэц гарна.

**2 [DAB]-г сонгоно.**

DAB хүлээн авах дэлгэц гарна.

**3 Шаардлагатай үед хүлээн авч буй DAB-г удирдана.**

● Арын суудлын дэлгэц




[**Text**] : Текст мессеж гаргана.*1

[**Time shift**] : Хөтөлбөрийг урагшлуулж, ухрааж сонсох горимд тохируулна.

[**Ch**] : [ ], эсвэл [ ]-г дарж урьдчилан сануулах товчинд сануулсан үйлчилгээг сонгоно.

[ ]/[ ] : 10 секундээр урагш, эсвэл арагш гүйлгэнэ.

Зөвхөн Time shift горимд тус функцийг ашиглах боломжтой.

[**Seek**] : [ ], эсвэл [ ]-г дарж одоогийн байрлалаас ойр, хүчтэй долгионтой үйлчилгээг автоматаар сонгоно.

Удаан дарж үйлчилгээг үргэлжлүүлэн солино. Суллах үед тухайн байрлалаас ойр, хүчтэй долгионтой үйлчилгээг автоматаар сонгоно.

● Арын олон үйлдэлт удирдлагын самбар*2




[ ]/[ ] : 10 секундээр урагш, эсвэл арагш гүйлгэнэ.

Зөвхөн Ttime shift горимд тус функцийг ашиглах боломжтой.

[**Ch**] : [], эсвэл []-г дарж урьдчилан сануулах товчинд сануулсан үйлчилгээг сонгоно.

[**Tune**] : [], эсвэл []-г дарж одоогийн байрлалаас ойр, хүчтэй долгионтой үйлчилгээг автоматаар сонгоно.

Удаан дарж үйлчилгээг үргэлжлүүлэн солино. Суллах үед тухайн байрлалаас ойр, хүчтэй долгионтой үйлчилгээг автоматаар сонгоно.

## Холбоотой холбоосууд

DAB сонсох(Х. 206)

*1 : Зарим загварт

*2 : Тоноглогдсон автомашинд

## Арын суудлын энтертейнмент системээр USB флашны дуу тоглуулах

USB портод холбосон USB флашны дууг тоглуулна.

Урд суудлын аудио системд USB флаш хийнэ.

**1 Дараах аль нэг үйлдлээр эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын суудлын дэлгэцний [**SOURCE**]-г дарна.

Эх үүсвэрийн дэлгэц гарна.

**2 [USB], эсвэл холбогдсон төхөөрөмжийн нэр сонгоно.**

**3 Дэлгэц дээр жагсаалт гараагүй үед үндсэн цэснээс [ ]-г сонгоно.**

**4 [Music]-г сонгоно.**

**5 Жагсаалтаас тоглуулах файл сонгоно.**

**6 Тоглуулах дууг удирдана.**

- Арын суудлын дэлгэц




[ ] : Дурын дууг тоглуулна. Товч дарах бүрт бүх файл эсвэл дуу, дурын дууг тоглуулах горим цуцлах, одоо тоглож буй хавтас, цомгийн дурын дууг тоглуулах горимуудад солигдоно.

[ ] : Одоо тоглуулж буй файлыг эхнээ нь тоглуулна.

Дуу, эсвэл файлны эхэнд байгаа үед өмнөх дуу, файлыг эхнээс нь тоглуулна. Удаан дарж хурдан ухраана. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[ ] : Түр зогсоох.

[ ] : Тоглуулах.

[ ] : Файл, дууг солих.

Удаан дарж хурдан урагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[ ] : Давтан тоглуулах.

Дурын дууг тоглуулна. Товч дарах бүрт бүх файл эсвэл дуу, дурын дууг тоглуулах горим цуцлах, одоо тоглож буй хавтас, цомгийн дурын дууг тоглуулах, тухайн дууг дахин тоглуулах горимуудад солигдоно.

● Арын олон үйлдэлт удирдлагын самбар*1




[ ]/[ ] : Удаан дарж хурдан урагш, эсвэл арагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[ ]/ : Одоогийн дуу, файлыг эхнээс нь тоглуулна. Дуу, файлын эхэнд байгаа үед өмнөх дуу, файлыг эхнээс нь тоглуулна.

[ ] : Дуу, файл тоглуулах.

[ ] : Дууг тоглуулах, түр зогсоох.

[**Хавтас, цомог**] : [ ], эсвэл [ ]-г дарж хавтас солино.

[**Видео**] : Видео тоглуулах.

## Холбоотой холбоосууд

USB портод холбох(Х. 40)

Аудио системээр ашиглах боломжтой медиа болон датаны мэдээлэл(Х. 306)

*1 : Тоноглогдсон автомашинд

## Арын суудлын энтертейнмент системээр USB флашны видео файл тоглуулах

USB портод холбосон USB флашны видео файл тоглуулна.

Урд суудлын аудио системд USB флаш холбоно.

**1 Дараах аль нэг үйлдлээр эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын суудлын дэлгэцний [**SOURCE**]-г дарна.

Эх үүсвэрийн дэлгэц гарна.

**2 [USB], эсвэл холбосон төхөөрөмжийн нэр сонгоно.**

**3 Дэлгэц дээр жагсаалт гарахгүй үед үндсэн цэсний [ ]-г дарна.**

**4 [Video]-г сонгоно.**

**5 Жагсаалтаас тоглуулах файл сонгоно.**

**6 Удирдлагын товч гарахгүй үед дараах аль нэг үйлдлийг хийнэ.**

- Дэлгэцийн дурын цэг дээр товшино.
- Арын олон үйлдэлт удирдлагын самбарны курсорын түлхүүр дэлгэцний [**Options**]-г сонгоно.

Дэлгэц дээр удирдлагын товч гарна.

Тоглуулах медиа болон файлын форматаас хамаарч дэлгэцээр гарах товч өөр байна.

**7 Видеог удирдана.**

- Арын суудлын дэлгэц




[ ] : Одоо тоглуулж байгаа файлыг эхнээс нь тоглуулна.

Файлын эхэнд байгаа үед өмнөх файлыг эхнээс нь тоглуулна. Удаан дарж видеог хурдан ухраана. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[ ] : Файл солих.

Удаан дарж хурдан урагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

Түр зогсоосон үед удаан дарж удаан тоглуулна.

[ ]/[ ] :  Видеог тоглуулах, түр зогсооно.

[ ]  :  Дэлгэц жижигрүүлнэ.

[ ]  :  Бүтэн дэлгэцэнд шилжүүлнэ.

[**Товч нуух**]  :  Товч дэлгэц дээр нууна.

[**Хөдөлгөх**]  :  Товчны дэлгэцийн байрлал өөрчилнө.

● Арын олон үйлдэлт самбар*1




[ ]  :  Удаан дарж хурдан ухраана. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[ ]  :  Удаан дарж хурдан урагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна. Түр зогсоосон үед удаан дарж удаан тоглуулна.

[ ]  :  Одоо тоглуулж байгаа файлыг эхнээс нь тоглуулна. Файлын эхэнд байгаа үед өмнөх файлыг эхнээс нь тоглуулна.

[ ]  :  Файл солих.

[ ]  :  Тоглуулах, түр зогсоох.

[**Дуу**]  :  Тоглуулах, түр зогсоох.

## Холбоотой холбоосууд

USB портод холбох(Х. 40)

Аудио системээр ашиглах боломжтой медиа болон датаны мэдээлэл(Х. 306)

*1 : Тоноглогдсон автомашинд

## Арын суудлын энтертейнмент системээр iPod, эсвэл iPhone-н дуу тоглуулах

USB портод холбосон iPod, эсвэл iPhone-н дууг тоглуулах боломжтой.

Урд суудлын аудио системд USB холбогчоор iPod, эсвэл iPhone холбоно.

**1 Дараах аль нэг үйлдлээр эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын суудлын дэлгэцний [**SOURCE**]-г дарна.

Эх үүсвэрийн дэлгэц гарна.

**2 Төхөөрөмжийн нэр, эсвэл [USB]-г сонгоно.**

iPod аудионы дэлгэц гарна.

**3 Дэлгэц дэх жагсаалтаас тоглуулах файл сонгоно.**

**4 Шаардлагатай үед тоглуулж буй дууг удирдана.**

- Арын суудлын дэлгэц




[ ] : Дууг холиж тоглуулна. Товч дарах бүрт холиж тоглуулах тохиргоо өөрчлөгдөнө.*1*2

[ ] : Одоо тоглуулж буй дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхэнд байгаа өмнөх дууг эхнээс нь тоглуулна.*1

[ ] : Түр зогсоох.

[ ] : Тоглуулах.

[ ] : Дуу солих. *1

[ ] : Давтан тоглуулна. Товч дарах бүрт давтан тохируулах тохиргоо өөрчлөгдөнө.*1*2

- Арын олон үйлдэлт удирдлагын самбар*3




[  ] : Одоо тоглуулж буй дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхэнд байгаа өмнөх дууг эхнээс нь тоглуулна. Удаан дарж хурдан ухраана. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.*1

[  ] : Дуу солино. Удаан дарж хурдан урагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.*1

[  ] : Тоглуулах, эсвэл түр зогсооно.

## Холбоотой холбоосууд

USB портод холбох(Х. 40)

iPod-н мэдээлэл(Х. 310)

*1 : Тус үйлдлийг радио сонсох үед хийх боломжгүй.

*2 : Холиж тоглуулах, давтан тоглуулах дараалал нь холбогдсон төхөөрөмжөөс хамаарч өөр байна.

*3 : Тоноглогдсон автомашинд

## Арын суудлын энтертейнмент систем дээр Apple CarPlay-н хөгжим тоглуулах

Холбогдсон төхөөрөмжийн Apple CarPlay-р дуу тоглуулна. Тус фунцкийг зөвхөн аудио дуугаралтын горимыг холбогдсон горимд тохируулсан үед ашиглах боломжтой. Тус функцийг Android Auto холбогдсон үед ашиглах боломжгүй.

Урд суудлын аудио системд Apple CarPlay-г холбоно.

**1 Дараах аль нэг үйлдлээр эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын суудлын дэлгэцний [**SOURCE**]-г дарна.

Эх үүсвэрийн дэлгэц гарна.

**2 [Apple CarPlay] (төхөөрөмжийн нэр)-г сонгоно.**

Apple CarPlay аудио дэлгэц гарна.

**3 Шаардлагатай нөхцөлд тоглуулж буй дууг удирдана.**

- Арын суудлын дэлгэц




[ ] : Дууг холиж тоглуулна. Товч дарах бүрт холиж тоглуулах тохиргоо өөрчлөгдөнө.*1

[ ] : Тоглуулж буй дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхэнд байгаа үед өмнөх дууг эхнээс нь тоглуулна.

[ ] : Тоглуулах, эсвэл түр зогсооно.

[ ] : Дуу солих.

[ ] : Дууг давтан тоглуулна. Товч дарах бүрт давтан тоглуулах тохиргоо өөрчлөгдөнө.*1

- Арын олон үйлдэлт удирдлагын самбар*2




[ ] : Тоглуулж буй дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхэнд байгаа үед өмнөх дууг эхнээс нь тоглуулна. Удаан дарж хурдан ухраана. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[ ] : Дуу солино. Удаан дарж хурдан урагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[ ] : Тоглуулах, эсвэл түр зогсооно.

## Холбоотой холбоосууд

Apple CarPlay тоглуулах үеийн анхааруулга(Х. 220)

Бүртгэлгүй ухаалаг утсаар Apple CarPlay ашиглах(Х. 158)

Бүртгэгдсэн утсаар Apple CarPlay ашиглах(Х. 161)

*1 : Холбогдсон төхөөрөмжөөс хамаарч холиж тоглуулах, эсвэл дахин тоглуулах дараалал өөр байна.

*2 : Тоноглогдсон автомашинд

## Арын суудлын энтертейнмент системээр Android Auto-н дуу тоглуулах

Холбосон төхөөрөмжийн Android Auto-н дуу тоглуулна. Тус функцийг зөвхөн аудио дуугаралтыг linked горимд тохируулсан үед ашиглах боломжтой. Apple CarPlay холбогдсон үед тус функцийг ашиглах боломжгүй.

Урд суудлын аудио системд Android Auto-г холбоно.

**1 Дараах аль нэг үйлдлээр эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын суудлын дэлгэцний [**SOURCE**]-г дарна.

Эх үүсвэрийн дэлгэц гарна.

**2 [Android Auto]-г сонгоно.**

Android Auto-н дэлгэц гарна.

**3 Тоглож буй дууг шаардлагатай үед удирдана.**

- Арын суудлын дэлгэц




[ ] : Одоо тоглуулж буй дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхэнд байгаа үед өмнөх дууг эхнээс нь тоглуулна.

[ ] : Тоглуулах, эсвэл түр зогсоох.

[ ] : Дуу солих.

- Арын олон үйлдэлт удирдлагын самбар*1




[ ] : Одоо тоглуулж буй дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхэнд байгаа үед өмнөх дууг эхнээс нь тоглуулна.

[ ] : Дуу солих.

[ ] : Тоглуулах, эсвэл түр зогсоох.

### Холбоотой холбоосууд

Android Auto тоглуулах үеийн анхааруулга(Х. 223)

*1 : Тоноглогдсон автомашинд

Android Auto ашиглах(Х. 164)

## Арын суудлын энтертейнмент системээс холбогдсонBluetooth® төхөөрөмжийн дуу тоглуулах

Урд суудлын аудио системд Bluetooth® зөөврийн аудио тоглуулагч (зөөврийн төхөөрөмж) холбон зөөврийн төхөөрөмжийг шууд удирдаж ажиллуулалгүйгээр тоглуулах боломжтой.

Урд суудлын аудио системд Bluetooth®-р зөөврийн төхөөрөмж холбоно.

**1 Дараах аль нэг үйлдлээр эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын суудлын дэлгэцний [**SOURCE**]-г дарна.

Эх үүсвэрийн дэлгэц гарна.

**2 [Bluetooth audio]-г сонгоно.**

Bluetooth® аудионы дэлгэц гарна.

**3 Шаардлагатай нөхцөлд тоглож буй дууг удирдана.**

- Арын суудлын дэлгэц




[ ] : Дурын дууг тоглуулна. Товч дарах бүрт дурын дууг тоглуулах горим өөрчлөнө.

[ ] : Одоо тоглуулж буй дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхэнд байгаа үед өмнөх дууг эхнээс нь тоглуулна. Удаан дарж хурдан ухраана. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[ ] : Түр зогсоох.

[ ] : Тоглуулах.

[ ] : Дуу солино. Удаан дарж хурдан урагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[ ] : Давтан тоглуулна. Товч дарах бүрт давтан тоглуулах тохиргоо өөрчлөгдөнө.

[**Browse**] : Жагсаалтын дэлгэц гаргаж унтраана.

Жагсаалтын дэлгэц гарсан үед жагсаалтнаас дуу сонгож тоглуулах боломжтой.

Арын суудал дээр гарч байгаа үед жагсаалт урд суудалд гарахгүй.

Жагсаалт арын суудалд гарснаас хойш тодорхой хугацаанд удирдаагүй үед жагсаалт арын суудлаас автоматаар унтарна.

● Арын олон үйлдэлд удирдлагын самбар*1




[]/[] : Удаан дарж хурдан урагш, арагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[] : Одоо тоглуулж буй дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхэнд байгаа үед өмнөх дууг эхнээс нь тоглуулна.

[] : Дуу солих.

[] : Тоглуулах, түр зогсоох.

## Холбоотой холбоосууд

Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 123)

*1 : Тоноглогдсон автомашинд

## Арын суудлын энтертейнмент системээр арын суудлын HDMI медиа тоглуулах

Арын суудлын HDMI портод холбогч ашиглан төхөөрөмж холбож тоглуулах боломжтой.

Арын суудлын HDMI портод HDMI төхөөрөмж холбоно.

1 **HDMI төхөөрөмж асаана.**

2 **Дараах аль нэг үйлдлээр эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [▫▫▫]-г сонгоно.
- Арын суудлын дэлгэцний [**SOURCE**]-г дарна.

Эх үүсвэрийн дэлгэц гарна.

3 **[Rear-HDMI]-г сонгоно.**

> ⚠ **АНХААР**
>
> HDMI порт ашиглаагүй үед тагийг таглана.
>
> Портод гадны биет, шингэн зүйл, бусад зүйлс орсон үед доголдол, эсвэл богино холболт үүсэх аюултай.

### Холбоотой холбоосууд

Арын суудлын энтертейнмент системд HDMI төхөөрөмж холбох (7 суудалтай)(Х. 52)

Арын суудлын энтертейнмент системд HDMI төхөөрөмж холбох (4 суудалтай)(Х. 53)

Арын суудлын энтертейнмент систем дээр арын суудлын HDMI тохиргоо өөрчлөх(Х. 130)

## Арын суудлын энтертейнмент системээр Miracast® тоглуулах

Арын суудлын энтертейнмент системээр урд суудлын аудио системдMiracast®-р холбогдсон ухаалаг утас, таблетны дэлгэц гаргах, аудио тоглуулах үйлдлийг хийх боломжтой.

Урд суудлын аудио системд Miracast® дэмждэг төхөөрөмж холбоно.

**1 Дараах аль нэг үйлдлээр эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын суудлын дэлгэцний [**SOURCE**]-г дарна.

Эх үүсвэрийн дэлгэц гарна.

**2 [Miracast®]-г сонгоно.**

Miracast®-н дэлгэц гарна.

### Холбоотой холбоосууд

Miracast® тоглуулах үеийн анхааруулга (Х. 231)

Miracast® дэмждэг төхөөрөмж холбох (Х. 232)

## Арын суудлаас Miracast® ашиглах үеийн анхааруулга

Арын суудлын энтертейнмент системд Miracast®-р холбосон ухаалаг утас, таблетны дэлгэцийг арын суудлын энтертейнмент системийн дэлгэц дээр гаргах, аудио тоглуулах боломжтой.

### МЭДЭЭЛЭЛ

- Арын суудлын энтертейнмент систем нь төхөөрөмжтэй Wi-Fi® (P2P горим)-р холбогддог.
- Wi-Fi® болон Miracast® нь Wi-Fi Alliance®-д бүртгэлтэй барааны тэмдэгт болно.
- Тус функц нь боломжит хамгийн өндөр гүйцэтгэлээр холболт үүсгэдэг.
- Miracast®-н дэлгэцээр гарах нэр нь төхөөрөмжөөс хамаарч өөр байна.
- Miracast® нь Bluetooth®-тэй адил 2.4 GHz-н радио давтамжаар холболт үүсгэдэг. Ашиглалтын нөхцлөөс хамаарч радио долгионы нөлөөлөл үүсч дүрсний хэлбэр алдагдах, эсвэл аудиод шуугиан орж болно.
- Wi-Fi® сүлжээг идэвхжүүлсэн үед Wi-Fi® сүлжээ болон Miracast® мэдээлэл дамжуулалтууд хоорондоо нөлөөлж дүрсний хэлбэр алдагдах, эсвэл аудиод шуугиан орж болно.
- Miracast®-г дэмждэг Android ухаалаг утас, таблет холбох боломжтой.

  Төхөөрөмж Miracast®-г дэмждэг эсэхийг төхөөрөмжийн гарын авлага, дагалдах бичиг баримтаас шалгана уу.*1

### АНХААР

Бүхээгт ухаалаг утас, таблет үлдээж болохгүй. Бүхээгний хэм хэт халсан үед ухаалаг утас, таблетанд доголдол үүсгэх аюултай.

### Холбоотой холбоосууд

Арын суудлаас Miracast®-д холбогдох(Х. 254)

Арын суудлын энтертейнмент систем дээр арын суудлын Miracast® тоглуулах(Х. 255)

Арын суудлаас Miracast® салгах(Х. 256)

*1 : Арын суудлын энтертейнмент системээр бүх төхөөрөмж удирдаж болох баталгаа байдаггүй.

## Арын суудлаас Miracast®-д холбогдох

**1** **Дараах аль нэг үйлдлээр эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын суудлын дэлгэцний [**SOURCE**]-г дарна.

Эх үүсвэрийн дэлгэц гарна.

**2** **[Rear-Miracast®]-г сонгоно.**

Холболтын дэлгэц гарна.




**3** **Тус үйлдэл нь Miracast®дэмждэг төхөөрөмж холбогдох боломжтой болгодог.**

- Төхөөрөмжийг хэрхэн ажиллуулах тухай дэлгэрэнгүй мэдээллийг төхөөрөмжийн гарын авлагаас харна уу.
- Холболт амжилтгүй болсон үед үйлдлийг дахин эхнээс нь хийнэ.

**4** **Төхөөрөмжийн нэр шалгаад [OK] дарна.**

### Холбоотой холбоосууд

Арын суудлаас Miracast® ашиглах үеийн анхааруулга(Х. 253)

Арын суудлын энтертейнмент систем дээр арын суудлын Miracast® тоглуулах(Х. 255)

Арын суудлаас Miracast® салгах(Х. 256)

## Арын суудлын энтертейнмент систем дээр арын суудлын Miracast® тоглуулах

Miracast® дэмждэг төхөөрөмжийг арын суудлын энтертейнмент системд холбоно.

**1 Дараах аль нэг үйлдлээр эх үүсвэр сонгох дэлгэц гаргана.**

- Үндсэн цэсний [ ]-г сонгоно.
- Арын суудлын дэлгэцний [**SOURCE**]-г дарна.

Эх үүсвэрийн дэлгэц гарна.

**2 [Rear-Miracast®]-г сонгоно.**

[**Rear-Miracast**®]-н дэлгэц гарна.

- Дараах нөхцлүүдэд Miracast® зогсоно:
  - Miracast® дэмждэг төхөөрөмж дээр Miracast® функц дууссан
  - Арын суудлын энтертейнмент системээс арын суудлын Miracast® салгагдсан

### МЭДЭЭЛЭЛ

Miracast® холболтын үед арын суудлын дэлгэц дээр даран холбогдсон төхөөрөмжийг удирдах боломжтой.[*1]

### Холбоотой холбоосууд

Арын суудлаас Miracast® ашиглах үеийн анхааруулга(Х. 253)

Арын суудлаас Miracast®-д холбогдох(Х. 254)

Арын суудлаас Miracast® салгах(Х. 256)

*1 : Тус функцийг зарим төхөөрөмж дэмжихгүй байж болно.

## Арын суудлаас Miracast® салгах

1 **Дараах аль нэг үйлдлээр эх үүсвэр сонгох дэлгэцэнд шилжүүлнэ.**

- Арын суудлын дэлгэцний [**SOURCE**]-г дарна.
- Арын олон үйлдэлт удирдлагын самбарны курсорын түлхүүр дэлгэцээр [**Rear menu**]-г сонгоно.

2 **Үндсэн цэснээс []-г сонгоно.**

3 **[Disconnect]-г сонгоно.**

### Холбоотой холбоосууд

Арын суудлаас Miracast® ашиглах үеийн анхааруулга(Х. 253)

Арын суудлаас Miracast®-д холбогдох(Х. 254)

Арын суудлын энтертейнмент систем дээр арын суудлын Miracast® тоглуулах(Х. 255)

# 7 Гарны оролцоогүй дуудлага


7-1. Гарны оролцоогүй дуудлага ашиглах үеийн анхааруулга

Гарны оролцоогүй дуудлага ашиглах үеийн анхааруулга ..................... 258

Автомашинаа зарах, устгалд оруулах үеийн анхааруулга ..................... 262

Гарны оролцоогүй дуудлагад доголдол үүсэх нөхцөл ..................... 263

7-2. Жолооны хүрдний товчоор гарны оролцоогүй дуудлага удирдах

Жолооны хүрдний товчоор удирдах ............. 267

7-3. Дуудлага хийх

Дуудлагын түүхээс дуудлага хийх .................. 269

Тогтмол ашигладаг жагсаалтаас дуудлага хийх.................................. 270

Холбоо барих хаягнаас дуудлага хийх.................. 271

Дугаар оруулан дуудлага хийх.................................. 272

Хүлээх, эсвэл түр зогсоох сигнал ашиглан дуудлага хийх.................. 273

7-4. Дуудлага хүлээн авах

Дуудлагад хариулах .......... 274

Ирсэн дуудлага таслах...... 276

7-5. Дуудлагын явцад удирдах

Дуудлагын дэлгэцнээс үйлдэл хийх ..................... 277

Давхар дуудлагад хариулах........................... 279

Дуудлага дундуур өөр хүн рүү дуудлага хийх........... 280

Олон хүнтэй зэрэг утсаар ярих.................................. 281

Дуудлага дуусгах............... 282

7-6. Гарны оролцоогүй дуудлагын утас солих

Гарны оролцоогүй дуудлагын утас солих ..... 283

7-7. Холбоо барих хаяг засварлах

Холбоо барих хаяг дамжуулах........................ 284

Холбоо барих хаягт шинэ хаягийн дата нэмэх......... 288

Тогтмол ашигладаг хаяг бүртгэх.............................. 290

7-8. Мессежний функц ашиглах

Мессежний функц ашиглах үеийн анхааруулга ..................... 291

Мессежний функцаас дуудлага хийх.................. 296

## Гарны оролцоогүй дуудлага ашиглах үеийн анхааруулга

Bluetooth® гар утсыг ("гар утас") системд баталгаажуулж бүртгэсэн үед гар утсыг шууд удирдалгүйгээр дуудлага хийх, хүлээн авах боломж бүрддэг. Тус функцийг гарны оролцоогүй дуудлага гэж нэрлэдэг.

Гар утас нь системд холбогдохын тулд мултимедиа системийн үзүүлэлтүүдийг дэмжих шаардлагатай. Нөгөөтэйгүүр гар утасны загвараас хамааран зарим функц хязгаарлагдмал байж болно.

Apple CarPlay, эсвэл Android Auto холбогдсон үед ч тухайн нөхцлөөс хамаарч Apple CarPlay, эсвэл Android Auto-н дэлгэц гарахгүй байж болно.

### МЭДЭЭЛЭЛ

- Гарны оролцоогүй дуудлагад гар утас холбон ашиглах үед дараах зүйлсийг анхаарна.
  - Гарны оролцоогүй дуудлага ашиглахын өмнө гар утсыг мултимедиа системд Bluetooth® ашиглан холбоно. Дуудлага хийхийн өмнө системд гар утсыг бүртгэнэ.
  - Гар утас Bluetooth® функц дэмждэг байх шаардлагатай.
  - Bluetooth® аудио тоглуулах үед дуудлага ирэх, хийх нөхцөлд дуудлагын дэлгэц, эсвэл ая хоцорч гарах, дуугарч болно.
- Тус мултимедиа систем нь бүх Bluetooth® төхөөрөмжтэй холбогдох баталгаа байхгүй.

  Гар утасны загвараас хамаарч дараах нөхцөл байдал үүсч болно
  - Гарны оролцоогүй дуудлагын үед асаах товч унтраасан нөхцөлд дуудлага тасарч болно.
  - Дуудлагын дэлгэц гарахгүй байх, эсвэл харилцагч тал утсаа авахаас өмнө яриа эхэлснийг заах дэлгэц гарч болно.
  - Дэлгэц дээр утасны дугаар оруулсан ч гар утасны оператороос хамаарч дуудлага хийгдэж байгаа ая .
  - Дуудлага хийсний дараа гар утсан дээр үйлдэл хийх шаардлагатай байж болно.
- Дараах нөхцлүүдэд гарны оролцоогүй дуудлага ашиглах боломжгүй.
  - Сүлжээгүй газар байгаа
  - Шугам дүүрсэн зэргээр гарах дуудлага хязгаарлагдсан
  - Яаралтай дуудлагын үед
  - Гар утаснаас холбоо барих хаяг дамжуулж байх үед
  - Гар утсан дээр дуудлага хийх үйлдэл түгжигдсэн

- Дата дамжуулах зэргээр гар утас бусад үйлдэл хийж байгаа үед
- Гар утас доголдсон үед
- Гар утас холбогдоогүй үед
- Гар утасны зайны цэнэг бага үед
- Гар утас унтарсан үед
- Гарны оролцоогүй дуудлага ашиглахаас сэргийлсэн тохиргоо гар утсан дээр хийсэн үед
- Дата дамжуулалт, хаяг дамжуулах горимоос гарны оролцоогүй дуудлага шилжүүлсэн үед. (Шилжүүлэх үед Bluetooth® холболтын байдал мултимедиа систем дээр гарахгүй)
- Гар утас бусад аливаа шалтгаанаар гарны оролцоогүй дуудлага хийх боломжгүй үед

● Гарны оролцоогүй дуудлага болон Wi-Fi® функц (Wi-Fi®, эсвэл Miracast®) зэрэг ашигласан үед гар утасны Bluetooth® холболт салж болно.

### ⚠ АЮУЛТАЙ

● Аюулгүйн үүднээс жолооч жолоодлогын үед гар утсыг шууд удирдаж болохгүй.

● Дотуур суулгасан зүрхний пэйсмейкер, зүрхний ажиллагааг дахин синхрончлох эмчилгээний пэйсмейкер, эсвэл дефибриллятор суулгац эмчилгээтэй хүн Bluetooth® антеннаас зайтай сууна. Радио долгион нь эдгээр төхөөрөмжийн ажиллагаанд нөлөөлөх аюултай.

● Bluetooth® төхөөрөмж ашиглахын өмнө дотуур суулгасан зүрхний пэйсмейкер, зүрхний ажиллагааг дахин синхрончлох эмчилгээний пэйсмейкер, эсвэл дефибриллятор суулгац эмчилгээнээс бусад эмчилгээний электрон төхөөрөмжтэй хүн радио долгионы эмчилгээний төхөөрөмжинд үзүүлэх нөлөөг төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс тодруулна. Радио долгион нь эмчилгээний төхөөрөмжид урьдчилан мэдэх боломжгүй нөлөө үзүүлэх аюултай.

### ⚠ АНХААР

Гар утсыг бүхээгт үлдээж болохгүй. Бүхээг хэт халсан үед гар утсанд доголдол үүсгэх аюултай.

## Холбоотой холбоосууд

Bluetooth® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 134)

Bluetooth® техник үзүүлэлт ба дэмжих функцууд(Х. 137)

Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмж бүртгэх(Х. 139)

## Аудио дуудлагын анхааруулга

Гарны оролцоогүй дуудлагад автомашины микрофон ашиглаж ярьдаг. Гарны оролцоогүй дуудлага хийх үед дараах мэдээлэлд онцгой анхаарна.



- Дуудлага хүлээн авах, эсвэл утсаар ярих үед урд 2 суудлын хажуу талын спикерээс аудио дуугардаг.
- Гарны оролцоогүй системээс аудио, эсвэл утасны ая дуугарах үед дуу хоолойн системийн аудио дууг түр хаадаг.

### МЭДЭЭЛЭЛ

- Утсаар ярих үедээ харилцаж буй талтайгаа ээлжилж ярина. Зэрэг ярьсан үед бие биенийхээ яриаг сонсох нь хүндрэлтэй байж болно.
- Хүлээн авагчийн дууны түвшинг хэт чангаар тохируулсан үед яриж буй хүний дуу автомашины гадна талд сонсогдох, эсвэл цуурай үүсч болно.
- Тод чанга ярина.
- Дараах нөхцлүүдэд таны дуу харилцаж буй хүнд муу сонсогдож болно.
  - Хатуу хучилтгүй замаар явах.
  - Өндөр хурдаар явах.
  - Дээвэр, цонх нээлттэй.
  - Агааржуулалтын сэнс микрофон руу үлээж байгаа.
  - Агааржуулалтын сэнс хэт хүчтэй ажиллаж байгаа.
  - Гар утсаа микрофонд хэт ойртуулсан
- Гар утас, сүлжээнээс хамаарч дууны чанарт сөрөг нөлөө (шуугиан, цуурай) үүсч болно.
- Өөр Bluetooth® төхөөрөмж зэрэг холбогдсон үед гарны оролцоогүй системийн аудионоос шуугиан үүсч болно.
- Мултимедиа системийг Wi-Fi® функц (Wi-Fi®, эсвэл Miracast®) ашиглахаар тохируулсан үед гарны оролцоогүй системийн аудионоос шуугиан үүсч болно.

**⚠ АНХААР**

Микрофонд гараар хүрэх, хурц үзүүртэй зүйлээр хатгахыг хориглоно. Доголдол үүсгэх аюултай.

## Автомашинаа зарах, устгалд оруулах үеийн анхааруулга

Гарны оролцоогүй систем ашиглах үед их хэмжээний хувийн мэдээлэл системд бүртгэгддэг. Автомашин зарах, эсвэл устгалд оруулахын өмнө эдгээр мэдээллийг устгана.

Бүх мэдээллийг тэглэсний дараа мултимедиа системийн бүх дата үйлдвэрийн тохиргоонд тэглэгдэх ба мэдээллийг тэглэхээс өмнөх байдалд буцаах боломжгүй.

### Холбоотой холбоосууд

Аюулгүй байдлын тохиргоо өөрчлөх(Х. 94)

## Гарны оролцоогүй дуудлагад доголдол үүсэх нөхцөл

Дараах шинж тэмдэг мэдрэгдсэн үед хүснэгт дэх боломжит шалтгаан болон шийдлийн дагуу арга хэмжээг аваад шинж тэмдгийг дахин шалгана.

### ■ Гарны оролцоогүй дуудлага ашиглах

| Шинж тэмдэг | Боломжит шалтгаан | Шийдэл |
|---|---|---|
| Гарны оролцоогүй дуудлага ашиглаж болохгүй байх | Гар утас Bluetooth® дэмждэггүй. | Мултимедиа системтэй холбох боломжтой төхөөрөмжийн мэдээллийг та өөрийн Lexus дилерээс авна уу. |
| | Гар утасны үйлдлийн системийн хувилбар Bluetooth®-тэй тохирохгүй. | A төрөл: Bluetooth® Core Specification Ver. 2.1-с хойших техник үзүүлэлттэй гар утас ашиглана.<br>B төрөл: Bluetooth® Core Specification Ver. 5.0-с хойших техник үзүүлэлттэй гар утас ашиглана. |

### ■ Гар утас бүртгэх, холбох

| Шинж тэмдэг | Боломжит шалтгаан | Шийдэл |
|---|---|---|
| Гар утас бүртгэх боломжгүй байх | Гар утасны бүртгэх үйлдэл амжилттай дуусахгүй байх. | Гар утсан дээр баталгаажуулах товч гарсан үед товч дарж бүртгэлийг үргэлжлүүлнэ. |
| | Гар утас, эсвэл мултимедиа систем дээр гар утасны бүртгэлтэй холбоотой мэдээлэл гарсаар байгаа. | Гар утас болон мултимедиа систем дээр бүртгэлийн мэдээллийг устгаад үйлдлийг дахин хийнэ. |
| Bluetooth®-р холбох боломжгүй байх | Тухайн холбох гэж байгаагаас бусад гар утас Bluetooth®-р холбогдсон байгаа. | Мултимедиа системнээс гараар Bluetooth® холболт үүсгэнэ. |
| | Гар утасны Bluetooth® функц асаагүй. | Асаах товчны ACC, эсвэл ON горимд гар утасны Bluetooth® функцийг асаана. |

| Шинж тэмдэг | Боломжит шалтгаан | Шийдэл |
|---|---|---|
| Bluetooth®-р холбох боломжгүй байх | Гар утасны бүртгэлийн мэдээлэл устгагдсан. | Гар утас болон мултимедиа систем дээр бүртгэлийн мэдээллийг устгаад үйлдлийг дахин хийнэ. |

## ■ Дуудлага хийх, хүлээн авах

| Шинж тэмдэг | Боломжит шалтгаан | Шийдэл |
|---|---|---|
| Дуудлага хийх, хүлээн авах боломжгүй байх | Сүлжээгүй орчинд байгаа | Автомашиныг сүлжээтэй орчинд шилжүүлнэ. |
| | Гар утасны дуудлага хязгаарлах функц (дуудлага түгжих) ассан. | Гар утасны дуудлага хязгаарлах функц (дуудлага түгжих) унтраана. |

## ■ Холбоо барих хаяг

| Шинж тэмдэг | Боломжит шалтгаан | Шийдэл |
|---|---|---|
| Холбоо барих хаяг шилжүүлэх боломжгүй, эсвэл автоматаар шилжихгүй байх | Гар утасны профайл холбоо барих шилжүүлэхийг дэмждэггүй. | Мултимедиа системд ашиглах боломжтой төхөөрөмжийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилерээс авна уу. |
| | [**Sync contacts**] тохиргоог мултимедиа системийн Bluetooth® тохиргоо дээр унтраасан. | [**Sync contacts**] тохиргоог мултимедиа системийн Bluetooth® тохиргоо дээр асаана. (→Х. 123) |
| | Гар утас хаяг дамжуулах зөвшөөрөл хүлээж байгаа. | Гар утас дээр хаяг дамжуулахыг зөвшөөрсөн товч дарна. |
| Гар утас дээр хаяг дамжуулахыг баталгаажуулах дэлгэц гарсан | Үргэлж зөвшөөрөх тохиргоог хийгээгүй. | Гар утсан дээр үргэлж зөвшөөрөх тохиргоог хийнэ. |

| Шинж тэмдэг | Боломжит шалтгаан | Шийдэл |
|---|---|---|
| Холбоо барих хаяг өөр газар хадгалагдсан | Гар утсан дээр хаяг бүртгэгдээгүй. | Гар утсан дээр хаяг бүртгэнэ. |
| Холбоо барих хаягийг засах боломжгүй байх | [**Sync contacts**] тохиргоог мултимедиа системийн Bluetooth® тохиргоо дээр асаасан. | [**Sync contacts**] тохиргоог мултимедиа системийн Bluetooth® тохиргоо дээр унтраана. (→Х. 123) |

## ■ Bluetooth® мессеж функц ашиглах үед*1

| Шинж тэмдэг | Боломжит шалтгаан | Шийдэл |
|---|---|---|
| Мессеж дэлгэцээр гарахгүй байх. | Гар утсан дээр автоматаар мессеж дамжуулах функц идэвхжээгүй. | Гар утсан дээр мессеж дамжуулах тохиргоог идэвхжүүлнэ. |
| Шинэ мессежний мэдэгдэл дэлгэцээр гарахгүй байх. | Гар утсан дээр автоматаар мессеж дамжуулах функц идэвхжээгүй. | Гар утасны автоматаар мессеж дамжуулах функцийг идэвхжүүлнэ. |

## ■ Бусад нөхцлүүд

| Шинж тэмдэг | Боломжит шалтгаан | Шийдэл |
|---|---|---|
| Боломжит шийдлийн дагуу арга хэмжээ авсан ч шинж тэмдэг арилахгүй үед. | Гар утас болон мултимедиа систем хоорондоо хэт зайтай. | Гар утас болон мултимедиа системийг ойртуулна. |
| | Цахилгаан соронзон саад холболтонд нөлөөлж байгаа. | Wi-Fi® төхөөрөмж зэрэг цахилгаан соронзон долгион үүсгэх бүх төхөөрөмжийг унтраана.<br>Мултимедиа системийн Wi-Fi® тохиргоог унтраана. |
| | Шалтгаан гар утсанд байж болно. | Гар утас унтраагаад зайг салгана. |

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

| Шинж тэмдэг | Боломжит шалтгаан | Шийдэл |
|---|---|---|
| Боломжит шийдлийн дагуу арга хэмжээ авсан ч шинж тэмдэг арилахгүй үед. | Шалтгаан гар утсанд байж болно. | Гар утасны Bluetooth® холболтыг асаагаад унтраана. |
| | | Гар утасны Wi-Fi® холболтыг унтраана. |
| | | Гар утасны аливаа аюулгүй байдлын программ, эсвэл далд программыг зогсооно. |
| | | Гар утас ашиглахаас өмнө үүрэн холбооны оператор болон суулгасан аппликейшны ажиллагааны байдлыг шалгана. |

### МЭДЭЭЛЭЛ

Дэлгэрэнгүй мэдээллийг гар утасны зааварчилганаас харна уу.

### Холбоотой холбоосууд

Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмж бүртгэх(Х. 139)

Бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмж устгах(Х. 143)

Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 123)

Wi-Fi® салгах(Х. 154)

## Жолооны хүрдний товчоор удирдах

Дуудлага хүлээн авах, хийх зэрэг зарим гарны оролцоогүй утасны функцийг жолооны хүрдний товчоор удирдах боломжтой. Мултимедиа системийн статусаас хамаарч жолооны хүрдний функц өөрчлөгдөнө.



● **Шаардлагатай нөхцөлд товчийг ашиглана.**

**[+] товч**

Ая, ярианы дууны түвшинг нэмнэ.

Удаан дарж үргэлжлүүлэн өөрчилнө.

**[-] товч**

Ая, ярианы дууны түвшинг багасгана.

Удаан дарж үргэлжлүүлэн өөрчилнө.

**[ ] товч**

Дуут командаар дуудлага хийх боломжтой.

Дуут командыг дуусгах үед дуудлага хийх, яриаг дуусгах товчийг удаан дарна.

**[ ] товч**

- Дуудлага хийх боломжгүй үед дуудлагын түүхийн дэлгэц гаргана.
- Дуудлага хийх.
- Дуудлага хийх, эсвэл яриан дундуур дуудлага дуусгана.
- Дуудлага ирэх, эсвэл хүлээлгэнд байгаа үед дуудлагад хариулна.

### МЭДЭЭЛЭЛ

- Apple CarPlay, эсвэл Android Auto холбогдсон үед [ ]-г дарж мултимедиа систем дээр Apple CarPlay, эсвэл Android Auto утасны дэлгэц гаргана.
- Apple CarPlay болон гарны оролцоогүй утас холбогдсон үед [ ]-г дарж Apple CarPlay, эсвэл мултимедиа системийн утасны дэлгэц гаргана. Хамгийн сүүлд ашиглагдсан функцийг түрүүлж ашиглана. Аль нь ч ашиглагдаагүй үед үндсэн төхөөрөмжийг түрүүлж холбоно.
- Android Auto болон гарны оролцоогүй утас холбогдсон үед [ ]-г дарж Android Auto-н утасны дэлгэж гаргана.
- Дуудлага ирэх үед тухайн гар утасны дуудлага ирж буй дэлгэц (гарны оролцоогүй утас, Apple CarPlay, эсвэл Android Auto) гарч ирнэ.

## Холбоотой холбоосууд

Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга(Х. 155)

Дуу хоолойн удирдлага эхлүүлэх(Х. 63)

## Дуудлагын түүхээс дуудлага хийх

Хүлээн авсан, гарсан дуудлагын түүх дэх утасны дугаар луу дуудлага хийх боломжтой.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Recents]-г дарна.**

3 **Хаяг сонгоно.**

Холбоо барих хаягт бүртгэгдээгүй утасны дугаарын зөвхөн дугаар гарна.

4 **Дуудлага хийх утасны дугаар дээр дарна.**




### МЭДЭЭЛЭЛ

- Сүүлд хийгдсэн 100 дуудлагын түүх дээр гарна. Дуудлага 100-с давсан үед хуучин түүхийг автоматаар устгана.
- Тухайн нөхцлөөс хамаарч гарсан дуудлага дараах байдлаар бүртгэгдэнэ.
  - Холбоо барих хаяг, эсвэл навигацийн системд бүртгэлтэй хаяг руу дуудлага хийсэн нөхцөлд хаягийн нэр, зураг байгаа дугаар дээр эдгээрийг хамт хадгална.
  - Нэг утасны дугаар луу олон удаа дуудлага хийсэн үед холбоо барих хаягийн нэрний хажууд дуудлагын тоо гарна.
- Тухайн нөхцлөөс хамаарч ирсэн дуудлага дараах байдлаар бүртгэгдэнэ.
  - Холбоо барих хаягт бүртгэлтэй дугаараас дуудлага ирсэн нөхцөлд хаягийн нэр, зураг байгаа дугаар дээр эдгээрийг хамт хадгална.
  - Нэг утасны дугаараас олон дуудлага ирсэн үед бүх дуудлагыг бүртгэнэ.
  - Хүлээн авч чадаагүй, цуцласан дуудлага мөн бүртгэгдэнэ.
  - Залгасан дугаар дуудлагын ID илгээх үйлчилгээнд хамрагдаагүй үед ирсэн дуудлага **"Unknown"** гэж хадгалагдана.
- Хүлээлгэнд оруулсан дуудлага мөн бүртгэгдэнэ.
- Гар утасны загвараас хамаарч олон улсын дуудлага хийх боломжгүй байж болно.

## Тогтмол ашигладаг жагсаалтаас дуудлага хийх

Тогтмол ашигладаг жагсаалтад бүртгэсэн холбоо барих хаяг руу дуудлага хийх боломжтой.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Favourites]-г дарна.**

3 **Тогтмол ашигладаг жагсаалтаас дуудлага хийх хүнийг сонгоно.**

4 **Утасны дугаар дээр товшино.**




### МЭДЭЭЛЭЛ

- [**Sync contacts**]-г идэвхжүүлсэн үед гар утасны тогтмол ашигладаг хаяг мултимедиа систем рүү автоматаар шилжинэ. (→Х. 123)
- Гар утасны загвараас хамаарч тогтмол ашигладаг жагсаалтыг дамжуулах боломжгүй байж болно.
- Тогтмол ашигладаг жагсаалтыг мөн мултимедиа систем дэх холбоо барих хаягт бүртгэгдсэн мэдээллээс бүртгэж болно.

### Холбоотой холбоосууд

Холбоо барих хаяг дамжуулах(Х. 284)

## Холбоо барих хаягнаас дуудлага хийх

Мултимедиа системд бүртгэгдсэн хаягнаас дуудлага хийх боломжтой.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Contacts]-г дарна.**

3 **Хаяг сонгоно.**

4 **Залгах утасны дугаар дээр дарна.**




### МЭДЭЭЛЭЛ

- Дэлгэц дээр [**Sync contacts**] товч гарсан үед товчин дээр дарж гар утаснаас мултимедиа системд хаяг шилжүүлнэ.
- Хаяг бүртгэгдээгүй үед мултимедиа систем дээр хаяг үүсгэх, эсвэл шилжүүлэх шаардлагатай.
- Гарны оролцоогүй утас тус бүрийн хаяг мултимедиа систем дээр гарна.

  2 гар утас холбогдсон ба гарны оролцоогүй утсаар ашиглах гар утас солисон үед хаяг мөн солигдоно.

### Холбоотой холбоосууд

Холбоо барих хаягт шинэ хаягийн дата нэмэх(Х. 288)

Холбоо барих хаяг дамжуулах(Х. 284)

## Дугаар оруулан дуудлага хийх

Дэлгэцийн гар дээр дугаар оруулан дуудлага хийнэ.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Keypad]-г дарна.**

3 **Утасны дугаар оруулна.**




4 **[ ]-г дарах, эсвэл жолооны хүрдний [ ] товч дарна.**

Дэд цэсний холбоо барих хаяг дээр мөн даран дуудлага хийх боломжтой.

### МЭДЭЭЛЭЛ

Гар утасны загвараас хамаарч гар утсан дээр үйлдэл хийх шаардлагатай байж болно.

### Холбоотой холбоосууд

Жолооны хүрдний товчоор удирдах(Х. 267)

## Хүлээх, эсвэл түр зогсоох сигнал ашиглан дуудлага хийх

Хүлээх буюу wait (w), эсвэл түр зогсоох буюу pause (p) сигнал агуулсан сигналаар дуудлага хийх боломжтой. Хүлээх (w), эсвэл түр зогсоох (p) сигналаар эхэлсэн дугаар луу дуудлага хийх үед дуудлагыг 2 секунд хойшлуулдаг.

- Хүлээх (w) сигнал нь дуудлага дамжуулалтыг хойшлуулдаг. Хэрэглэгч дараагийн хүлээх (w), түр зогсоох (p) сигнал өгсөн үед дамжуулалт дахин эхлэнэ.
- Түр зогсоох (p) сигнал нь дуудлага дамжуулалтыг 2 секунд хойшлуулдаг.

1 **Үндсэн цэсний [ ]-г дарна.**

2 **[Contacts]-г дарна.**

3 **Холбоо барих хаяг сонгоно.**

4 **Хүлээх (;эсвэл w) болон түр зогсоох (, эсвэл p) сигналтай утасны дугаар сонгоно.**

5 **Утасны дугаар хүлээх (w) сигналтай үед [ ]-г сонгоно.**




[ ]-г дарсан үед хүлээх (w) сигналаар дамжуулалт хүлээгдэж байсан дуудлага дараагийн (w), эсвэл (p) сигналаар дахин сэргэнэ.

### МЭДЭЭЛЭЛ

- Гар утасны загвараас хамаарч хүлээх сигналыг таслалаар (,) мөн түр зогсоох сигналыг цэг таслалаар (;) гар утасны дэлгэц дээр харуулж болно.
- Тус функцийг олон улсын дуудлага хийхэд ашиглана.
- Автомат хариулагч эсвэл банкны утасны үйлчилгээ гэх мэт утсанд суурилсан үйлчилгээг автоматаар ажиллуулах шаардлагатай үед дууны аяыг ашиглаж болно. Хүлээх (w), эсвэл түр зогсоох (p) сигналтай утасны дугаар холбоо барих хаягт бүртгэх боломжтой.

## Дуудлагад хариулах

Дуудлага ирэх үед ая дуугарч ирсэн дуудлагын дэлгэц, эсвэл мэдэгдэл гарна.

Дуу хоолойн удирдлагын дэлгэц дээр [**Voice support**]-г идэвхжүүлсэн нөхцөлд дуудлага ирэх үед дуу хоолойн удирдлага ажиллаж эхэлнэ.(→Х. 91)

● **Дараах аль нэг үйлдлээр дуудлагад хариулна.**




- [ ]-г дарна.
- Жолооны хүрдний [ ] товч дарна.
- Дуу хоолойн команд хэлж дуу хоолойн удирдлагын системээр дуудлагад хариулна.

### МЭДЭЭЛЭЛ

- Захын дэлгэц гарах үед ирсэн дуудлагын дэлгэц гарахгүй. Дуудлага ирж буйг зөвхөн утасны аяаар мэдэгдэнэ.
- Дуудлага ирэх үед гарны оролцоогүй утаснаас бусад бүх дууг түр хаадаг. Нөгөөтэйгүүр гарны оролцоогүй утаснаас давуу эрхтэй дуут зааварчилгааны дуу хаагдахгүй.
- Гар утасны аяыг мултимедиа системийн аяаар тохируулсан ч гар утасны тохиргооноос хамаарч мултимедиа системээс өөр ая дуугарч болно.
- Гар утасны жолоодлогын горим зэрэг тохиргооноос хамаарч дуудлага хүлээн авах боломжгүй байж болно.
- Гар утасны загвараас хамаарч дараах нөхцөл үүсч болно.
  - Гар утас болон мултимедиа системээс ая зэрэг дуугарч болно.
  - Дуудлага хүлээн авах үед залгаж буй хүний утасны дугаар дэлгэцээр гарахгүй байж болно.
  - Дуудлаганд утаснаасаа шууд хариулсан, эсвэл гар утас автоматаар дуудлагад хариулт өгсөн үед утасны яриа гар утсан дээр үлдэж болно.
  - Гар утас дата дамжуулах явцад дуудлага ирсэн үед ирсэн дуудлагын дэлгэц мултимедиа систем дээр гарахгүй байх, ая дуугарахгүй байж болно.
- Гар утас автоматаар холбоо барих хаяг дамжуулдаг PBAP функцтай үед хаягны зураг дамжуулагдах ба [**Display contact images**]-г идэвхжүүлсэн нөхцөлд дуудлага ирэх үед утасны дугаарын хажууд залгаж буй хүний зураг гарна. (→Х. 123)

- Мултимедиа систем дээр гар утасны аянаас өөр ая тохируулсан үед гар утасны аяны горимыг чимээгүй (чичиргээ) горимд тохируулсан, эсвэл утасны аяыг устгасан байсан ч мултимедиа системийн ая дуугарна.
- Гар утасны тохиргоогоор дуудлага хүлээн авахгүй тохиргоо хийсэн дугаараас ирсэн дуудлагыг хүлээн авахгүй.

## Холбоотой холбоосууд

Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх(Х. 91)

Жолооны хүрдний товчоор удирдах(Х. 267)

Системийг дуу хоолойн удирдлагын системээр удирдах(Х. 61)

Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 123)

## Ирсэн дуудлага таслах

Мултимедиа систем дээр олон аргаар ирж буй дуудлага таслах боломжтой.

- **Дуудлага ирэх үед дараах аль нэг үйлдлээр таслана.**
  - []-г дарна.
  - Гар утсыг шууд удирдана.
  - Дуу хоолойн удирдлагын систем ашиглан дуут командаар дуудлага таслана.

### МЭДЭЭЛЭЛ

Гар утасны тохиргоон дээр дуудлага хүлээн авахгүйгээр тохируулсан утасны дугаараас дуудлага ирсэн нөхцөлд цуцлагдана.

### Холбоотой холбоосууд

Жолооны хүрдний товчоор удирдах(Х. 267)

Системийг дуу хоолойн удирдлагын системээр удирдах(Х. 61)

## Дуудлагын дэлгэцнээс үйлдэл хийх

Дуудлага хийх үед дуудлагын дэлгэцнээс олон төрлийн үйлдэл хийх боломжтой.




[ ] : Харилцаж буй хүнд таны яриаг дамжуулахгүйгээр дууг хаана. Дууг хаасан үед товч цэнхэр болно.

Цуцлах үед товчийг дахин дарна.

- Та харилцаж буй хүний яриаг өөрийн дууг хаасан үед сонсох боломжтой.

[ ] : Дэлгэцийн гар гаргана. Дэлгэцийн гар гарах үед дуудлагын дэлгэц жижиг болно.

[ ] : Яриаг таслах.

[ ] : Өөр хүн рүү дуудлага хийх үед дэд цэсэн дээр холбоо барих хаягийг харуулна.

- Дуудлагын үед бусад хүн рүү өөр дуудлага хийх үед утасны дугаар дээр товшино.

[ ] : Дуудлагыг гар утас болон мултимедиа систем хооронд шилжүүлнэ. Дуудлага гар утас руу шилжих үед товч цэнхэр болно.

[ ] : Хүлээлгэнд байгаа дуудлагыг цуцлана. Зөвхөн дуудлага хүлээлгэнд байгаа үед гарна.

[ ] : Дуудлагын дэлгэцийг жижигрүүлнэ.

[ ] : Дуудлагын дэлгэцийг үндсэн хэсэг дээр гаргана.

[ ] : Сонголтын дэлгэцийг гаргана.

Сонголтын дэлгэц дээр дараах үйлдлийг хийх боломжтой.




● [**Transmit**] : Дамжуулалтын дууны түвшинг тохируулна.

Дамжуулалтын дууны түвшин өөрчлөх нь дууны чанар бууруулж болно.

● [**Navigation**] : Навигацийн системийн дуут зааварчилгааны дууг хаана.

Цуцлах үед [**Navigation**]-г унтраана.

[**Navigation during calls**]-г унтраасан үед дуудлагын үеийн навигацийн дуут зааварчилгааны дуу хаагдана.(→Х. 115)

● [**On hold**] : Дуудлагыг хүлээлгэнд оруулна.

Цуцлах үед [**On hold**]-г унтраана.

Гар утасны загвараас хамаарч дуудлага хүлээлгэнд оруулах боломжгүй байж болно.

● [ × ] : Дуудлагын дэлгэц рүү буцаана. Дуудлага хүлээлгэнд байгаа үед дуудлагын дэлгэцэнд буцаасан нөхцөлд сонголтын дэлгэцийг дахин гарган хүлээлгэнд байгаа дуудлагыг дуусгана.

## МЭДЭЭЛЭЛ

● Мултимедиа системийн ажиллагааны байдлаас хамаарч дуудлагын дэлгэц жижигрэх, эсвэл гарахгүй байж болно.

● Гар утасны загвараас хамаарч дуудлага шилжүүлэх боломжгүй байж болно.

● Жолоодлогын үед гарны оролцоогүй утасны системээс гар утас руу дуудлага шилжүүлэх боломжгүй. Гар утасны загвараас хамаарч дуудлага шилжүүлэх боломжгүй байж болно.

● Дуудлага хийж буй гар утсыг мултимедиа системд гарны оролцоогүй утсаар холбосон үед утас завгүй байгааг илтгэх дэлгэц гарна. Гар утасны загвараас хамаарч дуудлага гар утас, эсвэл мултимедиа системийн аль нэгээр хийгдэж болно.

● Гарны оролцоогүй утсаар дуудлага хийх үед асаах товч унтраасан нөхцөлд гар утаснаас хамаарч дуудлага тасрах, эсвэл гар утас руу дуудлага шилжиж болно. Гар утсаар дуудлага үргэлжлүүлэх үед гар утсан дээр үйлдэл хийх шаардлагатай байж болно.

## Холбоотой холбоосууд

Жолооны хүрдний товчоор удирдах(Х. 267)

## Давхар дуудлагад хариулах

Дуудлагын явцад гуравдагч талаас давхар дуудлага ирсэн нөхцөлд дуудлага хүлээлгэх функцаар 2 дуудлага зэрэг хийх боломжтой. Давхар дуудлага ирэх үед дэлгэцийн дээд талд дуудлагын мэдэгдэл гарна.

### МЭДЭЭЛЭЛ

- Та гар утасны оператор компанийн давхар дуудлагын үйлчилгээнд хамрагдсан байх шаардлагатай.
- Гар утас HFP Ver 1.5-с хойших хувилбарыг дэмждэггүй үед давхар дуудлага хийх боломжгүй.
- Гар утасны загвар болон хамрагдсан үйлчилгээний нөхцлөөс хамаарч тус функцийг ашиглах боломжгүй байж болно.

- **Давхар дуудлага хүлээн авах үед дэлгэцний [ ]-г дарах, эсвэл жолооны хүрдний [ ] товч дарна.**

  Давхар дуудлагад хариулах үед өмнөх дуудлагыг хүлээлгэнд оруулдаг.

  Дуудлага хооронд [**Swap calls**]-г дарж шилжүүлэх боломжтой.




**Холбоотой холбоосууд**

Жолооны хүрдний товчоор удирдах(Х. 267)

## Давхар дуудлага цуцлах

Дуудлага дундуур давхар дуудлага орж ирсэн үед хүлээгдэж байгаа дуудлагыг цуцлах боломжтой.

Давхар дуудлага ирэх үед [ ]-г дарна.

### МЭДЭЭЛЭЛ

Гар утасны загвараас хамаарч 2 дуудлага зэрэг салгагдаж болно. Гар утасны ашиглалтын гарын авлагаас дэлгэрэнгүй мэдээллийг шалгана уу.

**Холбоотой холбоосууд**

Жолооны хүрдний товчоор удирдах(Х. 267)

## Дуудлага дундуур өөр хүн рүү дуудлага хийх

Утсаар ярих үедээ гуравдагч тал руу дуудлага хийх боломжтой.

**1 Дуудлагын дэлгэцний [ ]-г дарна.**

**2 Холбоо барих хаяг сонгоно.**

**3 Утасны дугаар сонгоно.**

Тус функц нь одоо ярих буй дуудлагыг хүлээлгэнд оруулдаг.



### МЭДЭЭЛЭЛ

- Тус функцийг ашиглах үед өөрийн үүрэн холбооны операторын давхар дуудлагын үйлчилгээнд хамрагдсан байх шаардлагатай.
- Гар утас HFP Ver 1.5-с хойших хувилбар дэмждэггүй үед давхар дуудлага хийх боломжгүй.
- Гар утасны загвар болон хамрагдсан үйлчилгээний агуулгаас хамаарч тус функцийг ашиглах боломжгүй байж болно.

## Олон хүнтэй зэрэг утсаар ярих

Дуудлага хүлээлгэнд байгаа үед одоо ярьж буй утасныярианд хүлээлгэнд байгаа дуудлагын хүнийг нэмэх боломжтой.

● **Гуравдагч талтай утсаар ярих үедээ [Merge calls]-г дарна.**

Хүлээлгэнд байгаа дуудлага одоо яриж байгаа дуудлага руу нэгдэнэ.

### МЭДЭЭЛЭЛ

- Гар утасны операторын тухайн үйлчилгээнд хамрагдсан байх шаардлагатай.
- Гар утасны загвар болон хамрагдсан үйлчилгээнээс хамаарч тус функцийг ашиглах боломжгүй байж болно.
- Дуудлага дуусгах үед бүх ярьж буй талуудтай яриаг дуусгана.

## Дуудлага дуусгах

Гарны оролцоогүй дуудлага дуусгах олон аргууд байдаг.

- **Дуудлагын үед дараах аль нэг үйлдэл хийнэ.**
  - Жолооны хүрдний [ ] товч дарна.

    Товчийг удаан дарсан үед хүлээлгэнд байгаа дуудлагыг оролцуулан бүх дуудлага дуусгана.
  - Дуудлага хийх, эсвэл утсаар ярих дэлгэц гарч байгаа үед [ ]-г дарна.
  - Гар утсыг дарж дуудлага дуусгана.

### Холбоотой холбоосууд

Жолооны хүрдний товчоор удирдах(Х. 267)

## Гарны оролцоогүй дуудлагын утас солих

Гарны оролцоогүй утсаар 2 гар утас холбогдсон үед аль аль утсыг ашиглах боломжтой. Гарны оролцоогүй утасны функц нь ашиглах гар утсыг солих үйлдэлтэй байдаг. Гарны оролцоогүй утас нь сонгосон гар утасны холбоо барих хаяг, дуудлагын түүх зэрэг мэдээллийг харуулна. Сонгоогүй гар утсанд дуудлага ирэх үед мөн хүлээн авах боломжтой.

Гарны оролцоогүй утсанд 2 гар утас холбох үед жолоочийн бүртгэл хийж тохиргоог идэвхжүүлэх шаардлагатай.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 [Devices]-г дарна.**

**3 Ашиглах гар утас сонгоно.**

Дуудлага хийж, хүлээн авч, эсвэл ярьж буй гар утсыг сонгох боломжгүй.




### МЭДЭЭЛЭЛ

- Гарны оролцоогүй утасны дэлгэцээс өөр дэлгэцтэй үед дуудлага хийхэд үндсэн төхөөрөмжөөс дуудлага гарна.
- Аль нэг гар утсаар гарны оролцоогүй утасны функцаар ярьж байгаа үед нөгөө утсаар дуудлага хийх боломжгүй.
- Аль нэг гар утсаар гарын оролцоогүй утасны функцаар дуудлага хийж байгаа үед нөгөө утсанд ирсэн дуудлагыг авсан нөхцөлд анхны дуудлага цуцлагдана.
- Дараах функцуудыг сонгоогүй гар утсан дээр ашиглах боломжтой.
  - Утсан дээр дуудлага хүлээн авах функц
  - Мессеж хүлээн авах болон илгээх функц (мессеж хүлээн авсан үед)
- Ашиглах гар утас солисон ч үндсэн төхөөрөмжийг өөрчлөх шаардлагагүй.

### Холбоотой холбоосууд

Жолооч бүртгэх (Х. 73)

Жолооч бүртгэх, бүртгэл өөрчлөх (Х. 80)

Bluetooth® төхөөрөмжийг үндсэн төхөөрөмжөөр бүртгэх(Х. 148)

## Холбоо барих хаяг дамжуулах

Холбосон гар утас бүрт 5,000 хүртэлх хаяг бүртгэх боломжтой. Зөвхөн тухайн холбосон гар утасны хаяг дэлгэцээр гарна. Хаяг тус бүрт 4 хүртэлх утасны дугаар хадгалах боломжтой. Холбогдсон утас тус бүр дээр хаяг удирдах боломжтой.

Тус функцийг зөвхөн гар утасны хаяг гараар дамжуулах OPP, эсвэл автоматаар дамжуулах PBAP функцтай гар утсан дээр ашиглах боломжтой. Тус функцийг дэмждэг эсэхийг гар утасны хэрэглэгчийн гарын авлагаас гарна уу.

Гар утасны холбоо барих хаягийг PBAP-р дамжуулах үед [**Sync contacts**]-г Bluetooth® тохиргоо дээр асаах шаардлагатай. (→Х. 123)

### МЭДЭЭЛЭЛ

- Хаяг дамжуулах үед дараах хязгаарлалтууд байдаг.
  - Нэг хаяг дээр 5-с олон утасны дугаар бүртгэгдсэн байгаа үед бүх утасны дугаар мултимедиа систем дээр адил нэртэй олон хаяг болж хуваагдаж хадгалагдана.
  - Утасны дугаар дамжуулах үед хаягны нэрийг мөн шилжүүлнэ. Загвараас хамаарч тэмдэг үсэг зэрэг зарим үсэг, эсвэл бүх үсгийг дамжуулж чадахгүй байж болно. Мөн гар утаснаас нэрийг бүрэн дамжуулсан ч системийн дэлгэц дээр зөв гарахгүй байж болно.
  - Ихэвчлэн нууц тэмдэглэлийг уншдаггүй. (Гар утасны үзүүлэлтээс хамаарч зарим нөхцөлд уншиж болно)
  - Гар утсан дээр хадгалагдсан холбоо барих хаягны группийн нэр дамжуулагдахгүй.
  - Мултимедиа систем дээр утасны дугаарын төрлийг гар утсан дээр хадгалагдсан төрлөөр хадгална. Нөгөөтэйгүүр гар утасны загвар болон ашиглалтын орчноос хамаарч утасны дугаарын төрлийг заах тэмдэг бүгд адил байж болно.
  - Гар утасны загвараас хамаарч гар утасны пин код болон баталгаажуулах нууц үг хаяг дамжуулах үед оруулах шаардлагатай байж болно. Энэ нөхцөлд баталгаажуулах нууц үгээр [**1234**]-г оруулна.
  - Холбоо барих хаяг гараар дамжуулах OPP функцийг дэмждэггүй гар утаснаас хаяг шилжүүлэх боломжгүй.
- Холбоо барих хаягийг багцаар дамжуулах үйлдлийг дэмждэг гар утасны загвар дээр дараах нөхцөл үүсч болно.
  - Дамжуулалтанд 10 хүртэлх минут шаардагдаж болно.
  - Холбоо барих хаяг дамжуулах дэлгэц гарсан ч бусад дэлгэц рүү шилжүүлэх боломжтой. Энэ нөхцөлд хаягийг үргэлжлүүлэн дамжуулна.

- Хаяг дамжуулах үед бусад үйлдлүүд дараах байдлаар хийгдэнэ.
  - Хаягийг гараар дамжуулах OPP дамжуулалтын үед ирсэн дуудлагыг гар утсан дээр хүлээн авна. Тус дамжуулалтын үед мултимедиа системээр дуудлага хийх боломжгүй.
  - Хаяг автоматаар дамжуулах PBAP, эсвэл гараар дамжуулах OPP дамжуулалтын үед хаягийг Bluetooth®-р дамжуулах боломжгүй. USB флашаар дамжуулах боломжтой.
  - Хаяг дамжуулах үед асаах товч унтраасан нөхцөлд дамжуулалт цуцлагдана. Хөдөлгүүр асаах үед дамжуулалт үргэлжлэнэ.
- Дараах нөхцлүүдэд дамжуулагдсан хаягийн дата хадгалагдахгүй. (Мөн зарим дата хадгалагдахгүй.)
  - Мултимедиа системийн санах ой дүүрснээс шалтгаалж PBAP функцийн дамжуулалт дутуу хийгдсэн.
  - Бусад шалтгаанаар PBAP автомат дамжуулалт зогссон.
- Мултимедиа системийн хаягийг гар утас руу шилжүүлэх боломжгүй.
- Хаяг дамжуулах үед Bluetooth® аудио холболт салж болно. Дамжуулалт дуусах үед холболт дахин сэргэнэ. (Зарим загвар дээр гараар холбох шаардлагатай)
- Дамжуулалт хийх үед мултимедиа системийг асаана.
- Хаяг автоматаар дамжуулах PBAP функц нь хаяг, тогтмол ашигладаг хаяг, дуудлагын түүхийг мултимедиа системд дамжуулдаг. Зарим гар утас тогтмол ашигладаг хаяг дамжуулдаггүй.
- [**Sync contacts**]-г идэвхжүүлсэн үе гар утасны тогтмол ашигладаг хаяг автоматаар мултимедиа системд дамжуулагдана. (→Х. 123)
- Хаяг автоматаар дамжуулах PBAP функц ашиглах үед гар утасны загвараас хамаарч гар утсан дээр үйлдэл хийх шаардлагатай байж болно.
- Хаяг автоматаар дамжуулах PBAP функц ашиглан хаяг дамжуулах үед гар утсан дээр хаяг хуваалцах тохиргоог идэвхжүүлнэ.
- Хаяг автоматаар дамжуулах PBAP функц асахгүй үед бусад бүх функцийн үйлдэл дууссаны дараа дахин эхлүүлнэ.
- Холбоо барих хаягны зургийг гаргах үед [**Display contact images**]-г Bluetooth® тохиргоо дээр идэвхжүүлнэ. Хаягны зураг дамжуулах үед [**Sync contacts**] болон [**Display contact images**]-г Bluetooth® тохиргоо дээр идэвхжүүлэх шаардлагатай. (→Х. 123)

## Холбоотой холбоосууд

Bluetooth® техник үзүүлэлт ба дэмжих функцууд(Х. 137)

Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 123)

7

Гарны оролцоогүй дуудлага

## Гар утасны холбоо барих хаягийг OPP гар аргаар дамжуулах

Гар утсанд бүртгэгдсэн утасны дугаар (хаяг)-г мултимедиа систем рүү OPP гар аргаар дамжуулах аргаар дамжуулах боломжтой.

[**Sync contacts**]-г идэвхжүүлсэн үед гар утасны хаяг дамжуулах боломжгүй. [**Sync contacts**]-г унтраагаад тус үйлдлийг хийнэ. (→Х. 123)

**МЭДЭЭЛЭЛ**

Android Auto холбогдсон үед гар утасны хаягийг OPP дамжуулалтаар дамжуулах боломжгүй.

**1 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**2 [Update contacts], эсвэл [Edit contacts]-г дарна.**

**3 Дараах дамжуулах аргаас сонгоно.**

[**Overwrite with Bluetooth**] : Одоо байгаа хаяг дээр дарж хадгална.

[**Add with Bluetooth**] : Одоо байгаа хаяг дээр нэмж хадгална.




**4 Гар утсан дээр үйлдэл хийж хаяг дамжуулна.**

Хаяг дамжуулах үйлдэл амжилтгүй болсон мессеж дэлгэц дээр гарсан үед үйлдлийг эхнээс нь дахин эхлэнэ.

## Гар утасны холбоо барих хаяг USB флашаар системд оруулах

Мултимедиа системд USB флашинд хадгалсан гар утасны хаяг оруулах боломжтой.

- [**Sync contacts**]-г идэвхжүүлсэн үед USB флашны хаяг шилжүүлэх боломжгүй. Хаяг шилжүүлэх үед [**Sync contacts**]-г унтраана. (→Х. 123)
- Apple CarPlay, эсвэл Android Auto холбогдсон үед тус функцийг ашиглах боломжгүй.
- USB флаш дээр зөвхөн vCard форматаар (.vcf) хадгалсан хаяг шилжүүлэх боломжтой.

- USB флашнаас өгөгдөл дамжуулах боломжгүй. Үйлдлээ эхлэхээс өмнө мултимедиа системд гар утсаа холбож ашиглах боломжтой эсэхийг шалгана.

**1 USB портонд USB флаш хийнэ.**

**2 Үндсэн цэсний [ ]-г дарна.**

**3 [Update contacts], эсвэл [Edit contacts]-г дарна.**

**4 Дараах дамжуулах аргуудаас сонгоно.**




[**Overwrite with USB**] : Одоогийн хаягийг USB флашны хаягаар давхар бичнэ.

[**Add with USB**] : Одоо байгаа хаяг дээр USB флашны хаяг нэмнэ.

**5 Файлын жагсаалтаас шилжүүлэх файл сонгоно.**

**6 [OK]-г дарна.**

Файл дамжуулах үйлдэл амжилтгүй болсон үед үйлдлийг дахин эхлэнэ.

### МЭДЭЭЛЭЛ

vCard форматтай датаг USB-р холбосон гар утаснаас тухайн хаягийг ашиглаж байсан ч дамжуулах боломжтой. Зарим нөхцөлд гар утсанд хийсэн SD картанд хадгалагдсан файлыг дамжуулдаг.

## Холбоотой холбоосууд

USB портод холбох(Х. 40)

## Холбоо барих хаягт шинэ хаягийн дата нэмэх

